



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Мэндбаярын МАНДХАЙ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-33, Факс: 32-70-16
E-mail: mandkhai@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025. 06. 16 № 44X-03/7402
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Хөдөө аж ахуйн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж, холбогдох судалгаа, танилцуулгын хамт хүргүүлж байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй холбогдох дор дурдсан иж бүрдлийг хавсаргав. Үүнд:

1. Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл;
2. Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл;
3. Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийн товч танилцуулга;
4. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан;
5. Хууль тогтоомжийн төслийг үр нөлөөг үнэлсэн тайлан;
6. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоолол
7. Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй холбоотой дагалдах хуулийн төсөл.

Хавсралт 9/ хуудастай.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

М.МАНДХАЙ



000144



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025. 06. 16 № ХЭГ/1708
танай _____-ны № _____-т

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулсан Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг
Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн
тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хавсралт 3. хуудастай.

ТЭРГҮҮН ДЭД ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.СОЛОНГОО

100255009961

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“11.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайгийн санаачлан боловсруулсан Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайгийн санаачлан боловсруулсан Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг хууль санаачлагчдад уламжлахаар тогтов:

1.Хуулийн төсөлд тусгасан дараах зохицуулалт нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах хууль тогтоомжтой зөрчилдөж байна:

1.1.төслийн 8.5-8.10 дахь хэсэг нь Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 1-д “Хүн, хуулийн этгээд хуулиар хориглосон, эсхүл энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан тусгай болон энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээс бусад төрлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болно” гэж заасантай;

1.2.төслийн 9.1, 9.2, 9.4 дэх хэсэг нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5-д “Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх Хөгжлийн зорилтот хөтөлбөр байна” гэж, мөн 6.7-д “Дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна.” гэж, 6.8-д “Дунд хугацааны буюу дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр байна.” гэж тус тус заасантай;

1.3.төслийн 11.6 дахь хэсэгт хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлд учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээ хийх зардлыг Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлэхээр тусгасан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11.1-д “Засгийн газрын нөөц сан нь тухайн жилийн төсөвт урьдчилан тооцож, төлөвлөн тусгах боломжгүй, хойшлуулшгүй цаг үеийн шинжтэй арга хэмжээ болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.8-д заасан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, 4.1.15-д заасан гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг шат дараатай зохион байгуулах зорилгоор улс, орон нутгийн төсвийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлын хүрэлцэхгүй хэсгийг санхүүжүүлэх зориулалттай байна” гэж, Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно.” гэж тус тус заасантай;

1.4.төслийн 17.3.1-д хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хоёр улсын олон талт гадаад хамтын ажиллагааны хүрээнд худалдаа, эдийн засгийн болон худалдааны ерөнхий хэлэлцээр байгуулахаар тусгасан нь Олон улсын гэрээний тухай хуулийн 6.4-т “Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлаар энэ хуульд заасны дагуу Засгийн газраас олон улсын гэрээ байгуулах эрх авсны үндсэн дээр Засгийн газрын нэрийн өмнөөс Засгийн газар хоорондын олон улсын гэрээ байгуулж болно.” гэж заасантай;

1.5.төслийн 18.2 дахь хэсэг нь Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 6.4.5-д “Төр хувийн хэвшилтэй өрсөлдөж үйл ажиллагаа эрхлэхгүй, зөвхөн стратегийн ач холбогдол бүхий салбарт, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чухал ач холбогдолтой томоохон төслийг хэрэгжүүлэх зорилгоор, мөн төрөөс үнэ тарифын зохицуулалт хийдэг, хувийн салбар дангаараа эрхлэх боломжгүй, нийтийн ашиг сонирхлын үүднээс зайлшгүй эрхлэх үйл ажиллагааны чиглэлд компани байгуулдаг байх, бизнесийн үйл ажиллагааны удирдлагад хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх байдлыг хязгаарлаж, бизнесийн шийдвэр нь улс төрийн нөлөөллөөс ангид байх, төрийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж, нээлттэй хувьцаат компани болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх” гэж заасантай;

1.6.төслийн 15.4-т “хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь судалгаа, хөгжүүлэлтийн үр дүнд бий болсон шинэ мэдлэг, технологийг дамжуулах, зах зээлд нэвтрүүлэх, гарааны бизнесийг дэмжих ажлыг хариуцна” гэж тусгасан нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэг болон Инновацийн тухай хуулийн зохицуулалттай.

2.Хуулийн төслийн 14.3-т аймаг бүрд хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг шинжлэн судалдаг зориулалтын тоног төхөөрөмж, мэргэшсэн шинжээч бүхий лабораторитой байхаар заасан нь ач холбогдолгүй зохицуулалт гэж үзэхээр байна.


Иймд холбогдох судалгаанд үндэслэн төсөлд заасан лабораторийг мал аж ахуй, газар тариалан хөгжсөн бүс нутагт байгуулах байдлаар өөрчлөх нь зүйтэй болохыг анхаарах.

3.Хуулийн төслийн 8.4 дэх хэсэгт хөдөө аж ахуйн өртгийн сүлжээний оролцогч нь “нэг алхам урагш, нэг алхам хойш зарчим” баримтлахаар тусгасан нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан хуулийн төсөл боловсруулах аргачлалд хуулийн төсөл боловсруулахдаа уран сайхны болон чимэг үг хэрэглэхгүй байхаар заасантай нийцэхгүй байна.

4.Хуулийн төслийн 16.1-д хөрөнгө оруулалтын хэлбэрийг хязгаартай байдлаар явцуу хүрээнд тусгасан нь хөрөнгө оруулалтын бусад хэлбэрийг хүлээн зөвшөөрөхгүй агуулгатай болсныг анхаарч тус зохицуулалтыг дахин найруулах, эсвэл хасах.

5.Хуулийн төслийн 6 дугаар зүйлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, түүний төрлийг тодорхойлохдоо хамрах хүрээг багасгаснаас гадна дутуу томъёолсон байгааг анхаарч, гүйцээн боловсруулах шаардлагатай.

6.Хуулийн төслийн 12.1.2-т “энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан бүс нутагт эрхлэхийг зөвшөөрсөн аж ахуйн төрлөөс сонгон аж ахуйгаа хөгжүүлэх” гэж тусгасан нь хөдөө аж ахуйн бүс нутагт хуулийн төсөлд зааснаас өөр төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарласан агуулгатай байгааг анхаарч, нягтлах.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ.

МОНГОЛ УЛСЫН ИХ

ХУРЛЫН ГИШҮҮН



М.МАНДХАЙ

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2.1.2-т “Хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой эрдэс баялаг, хүнс, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, санхүүгийн салбарыг олон улс, Европын Холбооны стандартад нийцүүлэн хөгжүүлнэ.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын зорилт 8.3-т “Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.” гэсэн зорилт дэвшүүлсэн.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.4.1-д “мал аж ахуйн гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалтын түвшнийг сайжруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” гэж, Зорилт 4.4-т “эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж, хүнсний дотоодын хэрэгцээг ханган, экспортын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.” гэж тус тус тусгасан.

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 1.1.1-д “Хөдөө аж ахуйн тухай хуулийн

төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх"-ийг Засгийн газарт даалгасан болно.

Мал аж ахуй, газар тариалангийн салбарын тодорхой харилцааг зохицуулж буй хуулиудын уялдаа, холбоо хангалттай бус, үйлдвэрлэлийн гол хэрэгсэл болох газрын эзэмшил, ашиглалт, хүний нөөцийн бодлоготой холбоотой зохицуулалт тодорхой бус байгаагаас тус салбарын тогтвортой хөгжилд ихээхэн нөлөөлөл үзүүлж байна. Иймд хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангах харилцааг зохицуулсан хуулийн төслийг боловсруулж батлуулах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан тайланд хөдөө аж ахуйн салбарт үүсээд буй нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, түүнийг зохицуулах хэд хэдэн хувилбараас бие даасан анхдагч хуулийн төсөл боловсруулах хувилбарыг хамгийн оновчтой гэж дүгнэжээ.

1.2.Практик шаардлага

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь манай улсын хүн амын гол нэрийн хүнс, боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн зонхилох хэрэгцээг хангаж, хүнс, хөнгөн аж үйлдвэр, худалдаа, үйлчилгээний салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортод шууд болон дам хэлбэрээр онцгой үүрэг гүйцэтгэдэг салбар билээ. Монгол Улсын нийт ажиллах хүчний 23.7 хувь буюу 321.3 мянган хүн тус салбарт ажиллаж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд хөдөө аж ахуйн салбарын эзлэх жин 2024 онд 7.4 хувь болсон нь 2020 онтой харьцуулахад 5.6 пункт хувиар буурсан байна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь байгалиас хэт хараат, эрсдэлд өртөмтгий бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр агаарын хэм нэмэгдэж, хур тундасны хэмжээ буурах болсон өнөө цаг үед тэдгээрийн эрсдэл, сөрөг нөлөөллийг бууруулах, бэлчээрийн газар нутгийн ашиглалт, тэжээл хангамжийг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход төдийлөн анхаарахгүй байна. Газрын хөрсний үндсээ барих чадамж суларч хөрсний гулгалт, шилжилт нэмэгдсэнээр туйран салхи, шороон шуурганы давтамж ихсэх болсон. Ургамалжилтын бүх бүс бүслүүрт тохиолдох зудын индекс өсч, сүүлийн 30 жилийн хугацаанд нийт 21.1 сая толгой мал хорогдсон нь мөнгөн дүнгээр 860.0 орчим тэрбум төгрөгийн хохирол учрахад хүргэжээ. Түүнчлэн газрын доройтол, цөлжилт, бэлчээрийн хомсдол, даац хэтрэлт, ган, зудын давтамж зэрэг олон тулгамдсан асуудал нь экологид сөрөг нөлөөлөл үзүүлэх болжээ.

Мөн хөдөө аж ахуйгаас зах зээлд нийлүүлж байгаа түүхий эд, бүтээгдэхүүнд чанараас хамаарсан үнийн ялгавартай тогтолцоо байхгүй, чанарыг бус тоо хэмжээг харгалзан мөнгөн урамшуулал төрөөс олгож байгаагаас үйлдвэрлэл эрхлэгчид, бэлтгэн нийлүүлэгчид бүтээгдэхүүний чанарт анхаарахгүй байна. Түүхий эдэд анхан шатны тордолт хийх, чанараар үнэлэх тогтолцоо байхгүйгээс үнэ тогтворгүй, зарим тохиолдолд үнэгүйдэж, хаягдаж байна. Түүнчлэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн

орцын хүчин зүйлс, үйлдвэрлэлийн гарц, чанар, бүтээмжид ахиц дэвшил гарахгүй, үйлдвэрлэл эрхлэгчдийн орлого, амьжиргаа төдийлөн сайжрахгүй байна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид олгож буй хөнгөлөлттэй зээлийн болон хөрөнгө оруулалтын дэмжлэг нь хөгжлийн хөшүүрэг болж чадахгүй байгаа, малын тэжээл бэлтгэх, сүрэг сэлбэх үржлийн мал авах, үр, сорт шинэчлэх зэрэгт дотоодын үйлдвэрлэлийг импортын бараанаас хамгаалах бодлого, эрх зүйн зохицуулалт дутмаг зэрэг олон талт хүчин зүйлсийн нөлөөллөөс үүдэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл өрсөлдөх чадвар сул, орлого, ашиг бага байгаа учраас олон иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа зогсоох, үр ашиггүй ч амьжиргаагаа залгуулах зорилгоор аж ахуйгаа эрхлэх байдлаар тойргийн гацаанд ороход хүрчээ. Гэтэл хүн амын тоо, хүнсний хэрэглээ, үнэ цэн өдрөөс өдөрт өссөн ч хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын эрэлт нэмэгдсээр байна.

Хөгжсөн орнуудад хүнсний бүтээгдэхүүний зах зээлийг тогтворжуулах, зах зээлийн үнийг тогтвортой хадгалах, зохицуулах зорилгоор хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд төсвийн байнгын дэмжлэг үзүүлж байна. Тухайлбал, АНУ дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 1.0 хувь, Европын холбоо 1.3 хувь, Япон Улс 1.4 хувьтай тэнцэх санхүүжилтийн дэмжлэгийг улсын төсвөөс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд зарцуулдаг байна. Зарим оронд төрөөс дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд бүх үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулдаггүй ба улс орон бүр өөрийн нөхцөл, шаардлагыг тогтоож, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ болон фермерүүдийн орлогын бодлогыг хэрэгжүүлэхдээ эхний ээлжинд эдийн засгийн үзүүлэлт, стандартыг дагаж мөрдөх шаардлага тавьдаг.

Манай улс дотооддоо үйлдвэрлэх боломжтой хөдөө аж ахуйн гаралтай зарим нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийг импортлон их хэмжээний валютыг гадагш урсгаж байна. Тухайлбал, мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний импорт 2020 онд 77.6 сая ам.доллар байсан бол 2024 онд 149 сая ам.долларт хүрч, жил ирэх тусам тогтмол өсөж байна.

Үүний зэрэгцээ хүнсний хангамжийн баталгаат, аюулгүй байдалд эрсдэл үүсгэж байна. Мөн мал, амьтны эм, биобэлдмэл болон газар тариаланд хэрэглэдэг бордоо, пестицид, гербицидийн үлдэгдэл, малаас хүнд халддаг зооноз өвчин, ургамлын хөнөөлт организм тархах зэрэг хүн, мал, амьтны амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах, байгаль орчинд тааламжгүй нөлөө үзүүлэх зэрэг биологийн аюулгүй байдлын эрсдэл үүсээд байна.

Хөдөө аж ахуйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхдээ хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн өвөрмөц онцлогийг харгалзан цогц байдлаар авч үзэхгүйгээр зөвхөн нэг талаас нь харж шийдвэрлэх, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн уялдаа, холбоо дутмагаас бие биеэ тэтгэн хөгжүүлэх талаар дорвитой үйл ажиллагаа явагдахгүй, төрийн дэмжлэгийн зааг ялгаа их байгаагаас бие биенээ үгүйсгэн шахах, маргаан үүсгэх асуудал хурцдахад хүргэх, эдийн засгийн зарим арга, хөшүүргийг буруу хэрэглэх, төрөөс дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах бодлогыг тууштай хэрэгжүүлэхгүй байх, гадаадын зээл, тусламжийн төслийн

хөрөнгө оруулалтыг оновчтой ашиглахгүй, технологи нэвтрүүлэлт, мэргэжлийн зөвлөн туслах үйлчилгээний эрх зүйн зохицуулалт байхгүй, хүний нөөцийн бодлого, залгамж чанар алдагдсан талаар эрдэмтэд, судлаачид анхааруулсаар байна.

Иймд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх, төрөлжүүлэн хөгжүүлэх бүс нутгийг тодорхой болгох, түүхий эд, бүтээгдэхүүний өртгийн сүлжээ, мөшгих тогтолцоо, бүртгэл, хяналтыг сайжруулах, мал, амьтны гоц халдварт өвчнөөс эрүүл бүс тогтоох, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэлийг үнэлэх, хариу арга хэмжээ авах, үйлдвэрлэлийн цар хүрээ, чиглэлээс хамаарч төрөө үзүүлэх дэмжлэгийн шалгуур, хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалахад чиглэгдсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Дээр дурьдсан хууль зүйн үндэслэл болон практик шаардлагад үндэслэн Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлага зүй ёсоор үүсч байгаа юм.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хөдөө аж ахуйн тухай хуулиар хөдөө аж ахуйн талаар төрөөс баримтлах зарчим, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн төрөл, төрөлжилт, түүхий эд, бүтээгдэхүүний өртгийн сүлжээ, чанарын үнэлгээ, баталгаажуулалт, бүртгэл, мэдээлэл, тогтвортой хөдөө аж ахуйн төлөвлөлт, хөдөө аж ахуйн газар, хүний нөөцийн, судалгаа, хөгжүүлэлт, эрсдэл, түүний үнэлгээ, удирдлага, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, зах зээлийг дэмжих, хамгаалах, хөдөө аж ахуй үйлдвэрлэлийн удирдлага, үйл ажиллагааг хэрэгжүүлэгч этгээдийн чиг үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт зааснаар анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөл нь 6 бүлэгтэй байх ба хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэг буюу Нийтлэг үндэслэлд хуулийн зорилго, хөдөө аж ахуйн хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн нэр томъёоны тодорхойлолт, хөдөө аж ахуйн талаар төрөөс баримтлах зарчмыг тусгана.

Хоёрдугаар бүлэг буюу “Хөдөө аж ахуйн өртгийн сүлжээ” гэсэн бүлэгт хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, түүний төрөл, төрөлжилт, түүхий эд, бүтээгдэхүүний өртгийн сүлжээ, бүртгэл, мэдээлэл, чанарын үнэлгээ, баталгаажуулалт, өртгийн сүлжээнд оролцогчдын эрх үүрэг зэргийг тодорхойлно.

Гуравдугаар бүлэг буюу “Тогтвортой хөдөө аж ахуй” гэсэн бүлэгт тогтвортой хөдөө аж ахуйн төлөвлөлт, хөдөө аж ахуйн газар, усны нөөцийн ашиглалт,

хамгаалал, хүний нөөц, судалгаа ба хөгжүүлэлт, эрсдэлийн үнэлгээ, түүний удирдлага зохицуулалтын талаар тусгана.

Дөрөвдүгээр бүлэг буюу “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжлэг” гэсэн бүлэгт хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид үзүүлэх дэмжлэгийн хэлбэр, шалгуур, дэмжлэг үзүүлэх үйлдвэрлэл, үйл ажиллагааны чиглэл, шалгуур, төрийн дэмжлэгтэй холбогдох зохицуулалтыг тусгана.

Тавдугаар бүлэг буюу “Хөдөө аж ахуйн салбарын удирдлага, зохицуулалт” гэсэн бүлэгт хөдөө аж ахуйн салбар дахь төрийн бодлогын удирдлага, зохицуулалт, хөдөө аж ахуйн бодлогыг хэрэгжүүлэгч төрийн байгууллага, мэргэжлийн зөвлөл, зөвлөх үйлчилгээний бусад байгууллагын эрх, чиг үүрэг, оролцоо, харилцан уялдааг хангах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийг өргөжүүлэхэд төрийн хүлээх үүргийн талаарх зохицуулалтыг тусгана.

Зургаадугаар бүлэг буюу “Бусад зүйл” гэсэн бүлэгт хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага болон хууль хүчин төгөлдөр болох зохицуулалтыг тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар эдийн засаг, нийгмийн дараах үр дүнд хүрнэ гэж үзэж байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлийн төрийн урт, дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, нөөц ашиглалт, бүтээмжийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэлийн үнэлгээ хийх тогцолцоо тодорхой болно.
- Хүн амыг хөдөө аж ахуйн гаралтай гол нэрийн баталгаат хүнсээр, дотоодын боловсруулах үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр тасралтгүй хангах боломжийг бүрдүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлэх төрийн дэмжлэгийн чиглэл, хэлбэр тодорхой болох ба хөдөө аж ахуйд хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэж, үр өгөөж сайжирна.
- Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд, бүтээгдэхүүний чанартай уялдсан үнэ тогтож, үнийн өсөлт болон үнэгүйдлээс сэргийлэх ба инфляцид хөдөө

аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнийн нөлөөллийн эзлэх хувийг бууруулах нөхцөл бүрдэнэ.

- Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах, зах зээлд нийлүүлэх өртгийн сүлжээ, бэлтгэл, нийлүүлэлт өргөжиж, хүнсний аюулгүй байдлын хяналтыг сайжруулна.

- Дотооддоо үйлдвэрлэх боломжтой хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний импорт буурч, хот, суурингийн орчим болон тариалангийн бүс нутагт эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэл хөгжинө.

- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн нийгмийн өмнө хүлээх эрх, үүрэг, хариуцлага тодорхой болж, тус салбарт төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, мэргэжлийн холбоодын хамтын ажиллагаа бэхжинэ.

- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн харилцааг зохицуулсан харилцан уялдаа холбоо бүхий хуулийн зохицуулалт бий болж, эдийн засгийн хөшүүрэг, үр өгөөжийн бүртгэл, хяналттай болгоно.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, хуулийн төслийг тус тус боловсруулна.

-oOo-

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсад хөдөө аж ахуйн салбарын дэд салбар болох мал аж ахуй, мал эмнэлэг, газар тариалангийн салбарт хамаарах нарийвчилсан харилцааг зохицуулж буй 20 гаруй хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. Гэтэл хөдөө аж ахуйн ерөнхий суурь харилцааг зохицуулсан хууль өнөөдрийг хүртэл батлагдаагүй болно.

Иймд хөдөө аж ахуйн дотоодын үйлдвэрлэлийг хамгаалж тогтвортой хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогын суурь зарчмууд, хүний нөөцийн бодлогыг тодорхой болгож, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх, өртгийн сүлжээний нэгдмэл, цогц байдлыг хангах, эрсдэлийн болон чанарын үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид, хөрөнгө оруулагчдыг дэмжих чиглэл, шалгуурыг тогтоох, бүртгэл, хяналтын нэгдсэн сүлжээ бий болгохтой холбогдсон харилцааг зохицуулахаар тусгалаа.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл 6 бүлэг 22 зүйлтэй байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл:

Энэхүү бүлэгт хуулийн зорилт, Хөдөө аж ахуйн тухай хууль тогтоомж, төрөөс баримтлах зарчим, нэр томъёоны тодорхойлолт зэргийг тусгав.

Хуулийн зорилтыг төрөөс хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлогын зарчмыг тодорхойлж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн төрөлжилт, өртгийн сүлжээний нэгдмэл, цогц байдлыг хангах, тогтвортой хөгжлийг дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тодорхойлов.

Хөдөө аж ахуйн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Малчны тухай хууль, Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хууль, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Малын тоо толгойн албан татварын тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль, Тариалангийн тухай хууль, Таримал ургамлын үр, сортын тухай хууль, Үрийн тариалангийн даатгалын тухай хууль, Органик бүтэгдэхүүний тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэхээр заалаа.

Түүнчлэн Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөхөөр заасан.

Төрөөс хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлогын зарчмыг дараах байдлаар хуулийн төсөлд тодорхойлсон. Үүнд:

- үндэсний үнэт зүйл, нүүдлийн соёл, өв уламжлалыг хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх;
- хүн, байгаль орчинд ээлтэй, ногоон, био эдийн засгийн хөгжлийг дэмжих;
- уур амьсгалын өөрчлөлтийг сөрөн тэсвэрлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх;

- шинжлэх ухааны судалгаа, хөгжүүлэлтийг дэмжих, инноваци, дэвшилтэт шинэ технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;
- хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд нөөцийг үр ашигтай ашиглах, орон нутгийн хөгжлийг дэмжих;
- хөдөө аж ахуйн хөдөлмөрийн үнэлэмж, бүтээмж, эдийн засгийн өгөөж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах;
- хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийг тогтворжуулах, шударга өрсөлдөөнийг дэмжих;
- хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхижуулах, залгамж халааг тасралтгүй бэлтгэх тогтолцоог бэхжүүлэх;
- төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа, оролцоог хангах.

Мөн энэ хуульд хэрэглэгдэх нэр томъёог илүү ойлгомжтой болгохоор 14 нэр томъёоны тодорхойлолтыг тусгав. Ингэхдээ бусад хууль, бодлогын баримт бичигт тусгагдан хэрэглэгдсэн, өргөн утгатай, нарийвчлан тодорхойлох шаардлагатай зарим нэр томъёог тодорхойллоо. Тухайлбал, “хөдөө аж ахуйн үйлдвэрлэл”, “тогтвортой хөдөө аж ахуй”, “хөдөө аж ахуйн өртгийн сүлжээ”, “хөдөө аж ахуйн аялал жуулчлал”, “агро-ойн аж ахуй” зэрэг нэр томъёог шинээр тусгасан болно.

Хоёрдугаар бүлэг. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, өртгийн сүлжээ:

Энэхүү бүлэгт хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн төрлийг тогтоож, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх асуудал, өртгийн сүлжээ, түүний бүртгэл, мэдээлэл, түүхий эд, оролцогчдын эрх, үүрэг, бүтээгдэхүүний чанарын үнэлгээ, баталгаажуулалтын талаарх зохицуулалтыг тусгалаа. Үүнд,

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд газар зүйн байрлал, экологийн онцлог, хөдөө аж ахуйн зориулалттай газар, ус, хөрсний чадавх, байгалийн болон биологийн бусад нөөц, зах зээлийн эрэлтэд тулгуурлан төрөлжүүлэн хөгжүүлэхээр тусгасан болно.

Хөдөө аж ахуйн өртгийн сүлжээний анхдагч үйлдвэрлэл эрхлэгч болох мал аж ахуй, тариалангийн үйлдвэрлэлийн үйлдвэрлэл эрхлэгч стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцүүлэн түүхий эд, бүтээгдэхүүнээ бэлтгэн, төвлөрсөн цэг, эсхүл агуулахад нийлүүлэх, хүлээн авагч нь чанараар ангилах, шаардлагатай анхан шатны тордолт хийх, багцлах, савлах, шошголох, хадгалах үйл ажиллагааг хариуцаж, дараагийн шат буюу тээвэрлэлт, эсхүл боловсруулах үйлдвэр, эцсийн хэрэглэгчид нийлүүлэх зохицуулалтыг тусгалаа. Ингэхдээ өртгийн сүлжээний оролцогч бүр нь өөрт хамаарах үе шатанд түүхий эд, бүтээгдэхүүний стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангах шаардлагыг тусган боловсруулав.

Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг холбогдох стандартын дагуу үнэлж, баталгаажуулах, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөдөө аж ахуйн бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим сантай байхаар тус тус тусгалаа.

Гуравдугаар бүлэг. Тогтвортой хөдөө аж ахуй:

Энэхүү бүлэгт тогтвортой хөдөө аж ахуйн төлөвлөлт, хөдөө аж ахуйн газрын эзэмшил, ашиглалт, хүний нөөцийг бэлтгэх, судалгаа ба хөгжүүлэлт болон салбарын эрсдэлийн удирдлагын талаарх зохицуулалтыг тусгав. Үүнд,

Тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх зорилгоор улсын хэмжээнд дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөртэй байх, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймаг, нийслэл, хот, сум, дүүрэг батлан хэрэгжүүлж, тайлагнахаар энэ бүлэгт тусгалаа.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх баталгааг хангах зорилгоор аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасны үндсэн дээр өвөлжөө, хаваржааны бэлчээрийн болон мал услах уст цэг, худгийн хоорондох зай, байршлыг усны нөөц, уст цэгийн хайгуул, судалгааны дүнд үндэслэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид газрыг ашиглуулах, эзэмшүүлэх талаар зохицуулалтыг тусгав.

Мөн тухайн аймаг, нийслэл, хотын хэмжээнд хөдөө аж ахуйн өртгийн сүлжээнд хамаарах үйл ажиллагаа эрхлэх хүний нөөцийн хангамж, эрэлт, нийлүүлэлтийн судалгаа гаргаж, дутагдаж буй ажлын байранд захиалгаар хүний нөөцийг бэлтгэх арга хэмжээг орон нутаг төлөвлөн хэрэгжилтийг хангах, шаардагдах эрэлттэй мэргэжлээр их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд шинээр анги нээх, гадаад оронд сургах, тэтгэлэгт тэргүүн ээлжинд хамруулах асуудлыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дангаар, эсхүл боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулахаар энэ бүлэгт тусган боловсрууллаа.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч, өртгийн сүлжээнд оролцогчид шинэ мэдлэг, инновац, технологи эзэмшүүлэх, дэвшилтэт технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд чиглэгдсэн зөвлөн туслах үйлчилгээг салбарын судалгаа, хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллага болон салбарын мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллага хэрэгжүүлж байхаар тусгав.

Хөдөө аж ахуйн эрсдэлийг ангилж, эрсдэлийг үнэлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг энэ бүлэгт тусгав.

Дөрөвдүгээр бүлэг. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжлэг:

Энэхүү бүлэгт хөдөө аж ахуйн өртгийн сүлжээний оролцогчид төрөөс үзүүлэх дэмжлэгийн хэлбэр, шалгуурыг тогтоож, хөдөө аж ахуйн дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, үйлдвэрлэлийн цар хүрээг тэлэх, тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх, салбар хоорондын уялдааг хангах зорилгоор дэмжлэг үзүүлэх үйлдвэрлэл, үйл ажиллагааг тодорхойлов.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн мөнгөн болон мөнгөн бус дэмжлэгийн нийт хэмжээ, бүтээмж, эдийн засаг, нийгэм, байгаль орчны нөлөөлөл, өгөөжийг жил бүр тооцож, үр дүнд суурилсан төсөв, бодлогын арга хэмжээг төлөвлөх, дэмжлэгийг оновчтой тогтоох, хуваарилахад ашигладаг байхаар хуулийн төсөлд тусгалаа.

Тавдугаар бүлэг. Хөдөө аж ахуйн салбарын удирдлага, зохицуулалт :

Энэхүү бүлэгт хөдөө аж ахуйн салбарын бодлого боловсруулах, төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, тайлагнах, мэдээлэх, хяналт тавих, дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудыг тодорхойлов.

Зургаадугаар бүлэг: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийг тэлэх, экспорт, гадаад худалдааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд төрийн хүлээх үүргийг энэ бүлэгт тусгав.

Долоодугаар бүлэг. Бусад зүйл: Төгсгөлийн бүлэгт хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааг тус тус заасан.

Уг хуулийн төсөлтэй уялдуулан Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. Үүнд:

1. Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд: Малчинд нар, салхины эрчим хүч ашиглахад болон гэр авахад нь зориулан хөнгөлөлттэй зээл олгох, малчдын саналыг үндэслэн зургаан настай хүүхдийг эцэг, эхийн асрамжаас нь хөндийрүүлэхгүйгээр зайнаас сургах сургалтад хамруулах талаарх зохицуулалт тусгав.

2. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд: Мал, амьтны эрүүл мэндийн өөр өөр статустай бүс тогтоох тухай зохицуулалтыг тусгав.

3. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд: Өвөлжөө, хаваржааны газарт байрлах гэр, сууцны болон малын хашаа, саравчны доорх газрыг Монгол Улсын иргэн хот айлаар дундаа хамтран эзэмшихээс гадна малчин өрх дангаар эзэмшиж болох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан. Мөн бэлчээрийн газраас улсын тусгай хэрэгцээнд авах, эсхүл газрын нэгдмэл сангийн өөр ангилалд шилжүүлэх тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг авсны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх талаарх зохицуулалтыг тусган боловсрууллаа.

4. Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд: Агро-ойн аж ахуйн талаарх зохицуулалтыг хуулийн төсөлд шинээр тусгаж, тариалангийн үйлдвэрлэлийн дунд хугацааны төлөвлөлтийг Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй нийцүүлэн өөрчлөв.

5. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд: Хөдөө аж ахуйн тухай хуульд заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх, хөдөө аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх, орон нутгийн хөгжлийн бодлогын уялдааг хангах зэрэг арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахтай холбоотой зохицуулалтыг тусгав.

6. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд: Малын тоо толгойн албан татвараас орон нутгийн хөгжлийн санд төвлөрсөн хөрөнгийн зарцуулах арга хэмжээнд өөрчлөлт оруулах талаар зохицуулалт тусгав.

7. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд: хөдөө аж ахуйн дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, үйлдвэрлэлийн цар хүрээг тэлэх, тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх, салбар хоорондын уялдааг хангах зорилго бүхий Хөдөө аж ахуйн тухай хуульд тусгайлан заасан зарим үйлдвэрлэл, үйл ажиллагаанд төрөөс дэмжлэг үзүүлэх талаарх зохицуулалтыг тусгасан.

Хөдөө аж ахуй тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуульд нийцүүлсэн болно.

Хуулийн төсөлд шинээр байгууллага байгуулах, шинэ албан тушаал бий болгох заалт оруулаагүй бөгөөд хуулийг баталсны дараа нийгэм эдийн засаг, хууль зүйн сөрөг үр дагавар үүсэхгүй гэж үзэж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар эдийн засаг, нийгмийн дараах үр дүнд хүрнэ гэж үзэж байна. Үүнд:

-Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлийн төрийн урт, дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

-Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, нөөц ашиглалт, бүтээмжийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.

-Хүн амыг хөдөө аж ахуйн гаралтай гол нэрийн баталгаат хүнсээр, дотоодын боловсруулах үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр тасралтгүй хангах боломжийг бүрдүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.

-Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлэх төрийн дэмжлэгийн чиглэл, хэлбэр тодорхой болох ба хөдөө аж ахуйд хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэж, үр өгөөж сайжирна.

-Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд, бүтээгдэхүүний чанартай уялдсан үнэ тогтож, үнийн өсөлт болон үнэгүйдлээс сэргийлэх нөхцөл бүрдэнэ.

-Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний өртгийн сүлжээнд хамаарах үйл ажиллагаа, үе шат тодорхой болж, стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэр, зах зээлд нийлүүлэх нөхцөл бүрдэнэ.

-Дотооддоо үйлдвэрлэх боломжтой хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний импорт буурч, хот, суурингийн орчим болон тариалангийн бүс нутагт эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэл хөгжинө.

-Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн нийгмийн өмнө хүлээх эрх, үүрэг, хариуцлага тодорхой болж, тус салбарт төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, мэргэжлийн холбоодын хамтын ажиллагаа бэхжинэ.

-Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн суурь харилцааг зохицуулсан, тус салбарт мөрдөж буй нарийвчилсан зохицуулалт бүхий хуулиудын харилцан уялдаа холбоог хангасан хуулийн зохицуулалт бий болно.

-oOo-

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Дэлхийн зах зээлд хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэ өсөж, хүн амын хүнсний хэрэгцээ өдрөөс өдөрт нэмэгдэж, улс орон бүр хөдөө аж ахуйн дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийг сөрөн тэсвэрлэх, тогтвортой хөгжүүлэхэд анхаарч байна.

Манай улсын хувьд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь хүн амын гол нэрийн хүнсний, үндэсний хөнгөн аж үйлдвэрийн түүхий эдийн зонхилох хэрэгцээг хангаж, хүнс, хөнгөн аж үйлдвэр, худалдаа, үйлчилгээний салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортод шууд болон дам хэлбэрээр онцгой үүрэг гүйцэтгэдэг. Монгол Улсын нийт ажиллах хүчний 23.7 хувь буюу 321.3 мянган хүн тус салбарт ажиллаж, 2024 оны байдлаар ДНБ-д хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 7.4 хувийг эзэлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор баталсан Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 1.1.1-д “Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх”-ийг Засгийн газарт даалгажээ.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан тайланд хэдийгээр мал аж ахуй, тариалангийн салбарт технологийн зохицуулалт бүхий хуулиуд үйлчилж байгаа ч хөдөө аж ахуйн салбарт үүсээд буй нөхцөл байдалд дүн шинжилгээ хийснээр тэдгээрийн зөрчлийг арилгах, нэгдмэл байдлыг бүрдүүлэхийн тулд “анхдагч хуулийн төсөл” боловсруулах хувилбарыг хамгийн оновчтой гэж дүгнэжээ.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасны дагуу Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлэн хуулийн төслийг боловсруулан, холбогдох судалгаа, тооцоог хийв.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл нь 6 бүлэг, 22 зүйлтэй байхаар боловсруулсан.

Хуулийн төслийн зорилт нь төрөөс хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлогын суурь зарчмыг тодорхойлох, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн төрөлжилт, өртгийн сүлжээний нэгдмэл, цогц байдлыг хангах, тогтвортой хөгжлийг дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хуулийн төсөлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд чанараас хамаарсан үнийн тогтолцоог бүрдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүний нөөцийн бодлого, судалгаа хөгжүүлэлтийг төлөвшүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид, хөрөнгө оруулагчдыг дэмжих хэлбэр, чиглэл, шалгуурыг тогтоох, бүртгэл, хяналтын нэгдсэн сүлжээ бий болгох зэрэг дараахь зарчмын шинжтэй зохицуулалтын харилцааг тусгав.

Хөдөө аж ахуйн өртгийн сүлжээний үе шат бүрт нэмүү өртөг шингээх боломжийг бүрдүүлэхийн тулд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн ангилал, төрөлжилт, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн өртгийн сүлжээг хөгжүүлэх харилцааг тодорхой болгосон.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, нөлөөллийн үнэлгээ хийхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан.

Хуулийн төсөлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд холбогдох зохистой дадал, стандарт, техникийн зохицуулалтыг мөрдөх, шаардлагыг хангуулах, чанартай уялдсан үнийн

тогтолцоог хөгжүүлэхэд чиглэсэн идэвхжүүлэлтийг төрийн дэмжлэг олгох нөхцөлтэй уялдуулав.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрэлт, нийлүүлэлт, нөөц ашиглалт, бүтээмжийн дүн шинжилгээ хийх, түүнд суурилан тогтвортой хөгжүүлэх Зорилтот хөтөлбөрийг баталж өөр хэрэгжүүлэх, орон нутгийн түвшинд уг зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг зохион байгуулахаар заав.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд төрөөс үзүүлж байгаа дэмжлэгийг оновчтой болгох, чанар, бүтээмжтэй уялдуулах зорилгоор нийт дэмжлэгийн хэмжээ, эдийн засгийн өгөөжийг тооцдог байх харилцааг хуульчлан тусгав.

Хөдөө аж ахуйн салбарын бодлого, зохицуулалттай гадаад орон, олон улсын байгууллагын санхүүжилттэй төслийн зорилго, үйл ажиллагаа уялдуулах, нэгдмэл байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэхээр зохицуулав.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дэх төрийн удирдлагын тогтолцооны цар хүрээг тогтоож, бүртгэл, хяналтын нэгдсэн цахим систем бий болгох харилцааг хуульчлан тусгав.

Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан Хууль санаачлагчаас дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан БНХАУ, ОХУ, Япон, Авсрали зэрэг гадаад орны туршлага, энэ чиглэлийн судалгаа, шинжилгээний тайлан, дүгнэлттэй танилцаж, зохицуулалтын харилцааг харьцуулан судалсан.
- Хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах, холбогдох судалгаа, тооцоог хийхдээ хөдөө аж ахуйн салбарын дэд салбар тус бүрийн төлөөлөл, туршлагатай эрдэмтэн, судлаач, мэргэжилтэн, эрх зүйчээс бүрдсэн дэд Ажлын хэсэг байгуулж ажилласан.
- Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг <https://d.parliament.mn/> цахим сайтад 2025 оны 04 дүгээр сарын 15-ний өдөр байршуулж, олон нийтээс хуулийн төсөлд санал авсан ба нийт 586 дэмжиж хоёр санал ирсэн.
- Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг салбарын эрдэмтэн судлаачид, аж ахуйн нэгж, иргэд, мэргэжлийн холбоод, олон улсын байгууллагын төлөөллийг оролцуулан Төрийн ордонд болон Хөдөө аж ахуйн Их сургууль дээр 2 удаа хэлэлцүүлэг зохион байгуулж, санал, шүүмжийг хэлэлцүүлгийн явцад болон цаасаар хүлээн авсан. Нийт 50 гаруй асуулт, 101 санал ирсэн.
- Улсын Их Хурлын даргын 2024 оны 42 дугаар захирамжаар байгуулагдсан Улсын Их Хурлын гишүүдэд хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг танилцуулж, санал, шүүмжийг авав.
- Дээр дурдсан хэлэлцүүлгүүдийн явцад болон цахимаар, цаасаар ирүүлсэн санал, шүүмж тус бүрийг дэд ажлын хэсэг дээр хэлэлцэн, хуулийн төслөөр зохицуулж байгаа харилцаанд шууд хамааралтай саналыг хуулийн төсөлд тусгаж, зарим зохицуулалтын хэсгийг хасах, нэмэх, өөрчлөлт оруулан, хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулсан.
- Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, холбогдох танилцуулга, судалгаа, тайланг Засгийн газарт санал, дүгнэлт авахаар 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дугаар 03/4598 албан бичгээр хүргүүлсэн.

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн бүрдүүлбэрийг хангаж, тус хуулийн 41.2- зааснаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоолгохоор Улсын Их Хурлын Тамгын газарт албан бичгийг холбогдох бүрдүүлбэрийн хамт хүргүүлээд байна.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл батлагдсанаар эдийн засаг, нийгмийн дараах ач холбогдол, үр дүн гарна гэж үзэж байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйн салбар нь улс орны эдийн засгийн үндсэн, тэргүүлэх салбар байх тогтвортой хөгжлийн суурийг бэхжүүлнэ..
- “Алсын хараа 2050”-д дэвшүүлсэн “Тогтвортой хөдөө аж ахуй”-г хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг дэмжиг, дэд салбар хоорондын харилцан уялдаа, нэгдмэл байдлыг хангах эрх зүйн орчныг сайжруулна.
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлэх төрийн дэмжлэгийн чиглэл, шалгуурыг тодорхой болгосоноор хөдөө аж ахуйд хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлж, салбарын эдийн засгийн өсөлт, экспортыг дэмжинэ.
- Хөдөө аж ахуйн өртгийн сүлжээнд төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, мэргэжлийн байгууллага, холбоодын хамтын ажиллагаа бэхжинэ.

Иймд Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн үзэл баримтлалд туссан хууль зүйн үндэслэл болон практик шаардлагад үндэслэн боловсруулсан хуулийн төслийг, холбогдох судалгаа, тайлангийн хамтаар танилцуулж байна.

-oOo-

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202. оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь төрөөс хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлогын зарчмыг тодорхойлж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн төрөлжилт, өртгийн сүлжээний нэгдмэл, цогц байдлыг хангах, тогтвортой хөгжлийг дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн хууль тогтоомж

2.1.Хөдөө аж ахуйн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Малчны тухай хууль, Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хууль, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Малын тоо толгойн албан татварын тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль, Тариалангийн тухай хууль, Таримал ургамлын үр, сортын тухай хууль, Үрийн тариалангийн даатгалын тухай хууль, Органик бүтэгдэхүүний тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх, өртгийн сүлжээг хөгжүүлэхтэй холбогдосон харилцаанд үйлчилнэ.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хөдөө аж ахуйн үйлдвэрлэл” гэж хөдөө аж ахуйн газарт байгалийн болон биологийн нөөцөд тулгуурлан мал аж ахуй, тариалангийн үйлдвэрлэл дагнан, эсхүл хослуулан эрхлэх үйл ажиллагааг;

4.1.2.“мал аж ахуйн үйлдвэрлэл” гэж мал, амьтныг өсгөн үржүүлж, ашиглалтын орц, үйлдвэрлэсэн түүхий эд, бүтээгдэхүүний гарцаар тодорхойлогдох бэлтгэн нийлүүлэлтийн үе шатны цогц үйл ажиллагааг;

4.1.3.“тариалангийн үйлдвэрлэл” Тариалангийн тухай хуулийн 16.1-д заасныг;

4.1.4.“бэлчээрийн мал аж ахуй” гэж мал сүргийг тэжээлийн үндсэн суурь болсон бэлчээрт жилийн туршид улирлын хуваарьтайгаар идээшлүүлэн маллаж, ашиг шимийг нь хүртдэг, нүүдлийн өв соёлыг хадгалсан уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэлийг;

4.1.5.“эрчимжсэн мал аж ахуй” гэж ашиг шим өндөртэй мал, амьтныг арчилгаа, маллагаа, тэжээллэгийн технологийн дагуу суурин, хагас суурин хэлбэрээр маллаж ашиг хүртдэг үйлдвэрлэлийг;

4.1.6.“бэлчээрийн мал аж ахуйн эрчимжилт” гэж уламжлалт мал аж ахуйг техник, технологийн дэвшлийг ашиглан, эсхүл хөрөнгө оруулалт хийж бүтээмжийг нэмэгдүүлэн эрсдэлгүй, хүн, байгальд ээлтэй арга барилаар эрхлэх үйл явцыг;

4.1.7.“хадлан, тэжээлийн үйлдвэрлэл” гэж мал, амьтны тэжээллэгийн хэрэгцээг хангах, шимт бодисын хэмжээг тэнцвэржүүлэх, тарга тэвээрэг, ашиг шимийг нэмэгдүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийн байгалийн эрсдлийг бууруулах зорилгоор бэлтгэж, үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлж байгаа үйл ажиллагааг;

4.1.8.“хамгаалалттай аж ахуй” гэж Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.18-д заасныг;

4.1.9.“агро-ойн аж ахуй” гэж мод, сөөг тариалалтыг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлтэй зориудаар хослуулсан, нийгэм, эдийн засаг, байгаль орчны ашиг тустай аж ахуйн зохион байгуулалтыг;

4.1.10.“хөдөө аж ахуйн аялал жуулчлал” гэж мал аж ахуй, газар тариалан, уламжлалт нүүдлийн ахуйн хэв маяг, нутгийн соёл, хоол хүнс зэргийг жуулчдад таниулах, сурталчлах замаар орон нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, үндэсний соёл, өв, уламжлалыг хадгалах зорилготой аялал жуулчлалын төрлийг;

4.1.11.“хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч” гэж энэ хуулийн 4.1.1-д заасан үйл ажиллагааг эрхэлж, эдийн засгийн өгөөж хүртэж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг;

4.1.12."эдийн засгийн өгөөж" гэж Татварын ерөнхий хуулийн 6.1.45-д заасныг;

4.1.13."хөдөө аж ахуйн өртгийн сүлжээ" гэж хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээс эхлэн бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, хэрэглэгчид хүргэх бүх үйл ажиллагааг хамарсан, шат тус бүрт нэмүү өртөг шингээж, эцсийн бүтээгдэхүүний үнэ цэнийг бүрдүүлэх үйл явцыг;

4.1.14."тогтвортой хөдөө аж ахуй" гэж хүн, байгаль орчинд ээлтэй, эрсдэл даах чадавхтай, хариуцлагатай, нөөцийн зохист ашиглалт, эдийн засаг, нийгмийн өгөөж, эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн, урт хугацаанд үргэлжлэх, бүтээмжтэй, ухаалаг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг.

5 дугаар зүйл.Төрөөс хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлогын зарчим

5.1.Хөдөөг аж ахуйг хөгжүүлэх бодлого нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангах, эдийн засаг, нийгэм, байгаль орчны тэнцвэрийг хадгалахад чиглэгдэнэ.

5.2.Хөдөөг аж ахуйг хөгжүүлэх бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд дараах зарчим баримтална:

5.2.1.үндэсний үнэт зүйл, нүүдлийн соёл, өв уламжлалыг хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх;

5.2.2.хүн, байгаль орчинд ээлтэй, ногоон, био эдийн засгийн хөгжлийг дэмжих;

5.2.3. уур амьсгалын өөрчлөлтийг сөрөн тэсвэрлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх;

5.2.4.шинжлэх ухааны судалгаа, хөгжүүлэлтийг дэмжих, инноваци, дэвшилтэт шинэ технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

5.2.5.хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд нөөцийг үр ашигтай ашиглах, орон нутгийн хөгжлийг дэмжих;

5.2.6.хөдөө аж ахуйн хөдөлмөрийн үнэлэмж, бүтээмж, эдийн засгийн өгөөж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах;

5.2.7.хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийг тогтворжуулах, шударга өрсөлдөөнийг дэмжих;

5.2.8.хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхижуулах, залгамж халааг тасралтгүй бэлтгэх тогтолцоог бэхжүүлэх;

5.2.9.төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа, оролцоог хангах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ӨРТГИЙН СҮЛЖЭЭ

6 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн ангилал, төрөл

6.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь дараах ангилалтай байна:

- 6.1.1.мал аж ахуй;
- 6.1.2.тариалан;
- 6.1.3.хадлан, тэжээл үйлдвэрлэл;
- 6.1.4.агро-ойн аж ахуй;
- 6.1.5.хөдөө аж ахуйн аялал жуулчлал.

6.2.Мал аж ахуйн үйлдвэрлэл нь үйл ажиллагааны онцлогоос хамаарч доор дурдсан төрөлтэй байна:

- 6.2.1.бэлчээрийн мал аж ахуй;
- 6.2.2.эрчимжсэн мал аж ахуй;
- 6.2.3.бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй хосолсон;
- 6.2.4.ашиг шимийн чиглэлээр төрөлжсөн аж ахуй;
- 6.2.5.захиалгат бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн аж ахуй;
- 6.2.6. бусад.

6.3.Тариалангийн үйлдвэрлэл нь Тариалангийн тухай хуулийн 16.2-т заасан төрөлтэй байна.

6.4.Агро-ойн аж ахуй нь доор дурдсан төрөлтэй байна:

- 6.4.1.тариалан-ой хосолсон;
- 6.4.2.мал аж ахуй-ой хосолсон;
- 6.4.3.хөдөө аж ахуй-ой хосолсон;

6.5.Хөдөө аж ахуйн аялал жуулчлал нь энэ хуулийн 6.1.1-6.1.2-т заасан үйлдвэрлэлийн чиглэлээр төрөлжсөн байж болно.

6.6.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч нь энэ хуулийн 6.1 дэх хэсэгт заасан үйлдвэрлэлийг хослуулан эрхэлж болно.

7 дугаар зүйл.Хөдөө аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх

7.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд газар зүйн байрлал, экологийн онцлог, хөдөө аж ахуйн

зориулалттай газар, ус, хөрсний чадавх, байгалийн болон биологийн бусад нөөц, зах зээлийн эрэлтэд тулгуурлан төрөлжүүлэн хөгжүүлнэ.

7.2.Хөдөө аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх бүс нутгийн байршил, хэмжээг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.

7.3.Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд энэ хуулийн 7.1-д заасан хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, арга хэмжээг тусган хэрэгжүүлнэ.

7.4.Энэ хуулийн 7.3-т заасан тэргүүлэх чиглэлд бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, тэжээл үйлдвэрлэл, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо, үр тариа, буурцагт ургамал, хамгаалагдсан хөрсний тариалан, газар зүйн заалттай, эсхүл органик бүтээгдэхүүн үйлдвэрлэл, цөм сүрэг, үр үржүүлэг, агро-ойн аж ахуй, хамгаалалттай мал аж ахуйг хөгжүүлэх асуудлыг тусгайлан хамааруулж болно.

7.5.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хоршоо, кластерын зохион байгуулалтаар болон хөдөө аж ахуйн захиалгат бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр төрөлжүүлэн хөгжүүлж болно.

7.6.Хөдөө аж ахуйн захиалгат бүтээгдэхүүнийг арилжихтай холбогдсон харилцааг Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулиар зохицуулна.

7.7.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд орон нутгийн хөгжлийн бодлогын уялдааг хангах, экосистемийн ээлтэй орон зайг бий болгох нөхцөлийг бүрдүүлэх, дэд бүтцийг сайжруулах зэрэг арга хэмжээг тухайн шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага хэрэгжүүлнэ.

7.8.Тариалангийн болон мал, амьтны өвчнөөс эрүүл, тайван бүс, отрын нөөц нутаг, үүлдэр, омгийн цөм сүргийн мал үржүүлэх байршлыг тогтоохтой холбогдсон харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

8 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний өртгийн сүлжээ

8.1.Хөдөө аж ахуйн өртгийн сүлжээний анхдагч үйлдвэрлэлд мал аж ахуй, тариалангийн үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаа хамаарна.

8.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч нь өөрийн үйл ажиллагаанд хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлж, холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлагын дагуу түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэнэ.

8.3.Бэлтгэсэн түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, эрүүл ахуйн баталгаа нь холбогдох бүртгэл, мэдээллийн цахим санд баталгаажсан байна.

8.4.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг төвлөрсөн цэг, эсхүл агуулахад хүлээн авахдаа холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлагын хүрээнд чанарыг үнэлж, чанараас хамаарсан үнийг талууд харилцан тохиролцож тогтооно.

8.5.Төвлөрсөн цэг, эсхүл агуулахыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн тухайн аймаг, нийслэл, хот, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд заасан байршилд ажиллуулна.

8.6.Төвлөрсөн цэг, эсхүл агуулах ажиллуулах хүсэлтэй этгээд нь тухайн сум, дүүргийн Засаг даргад хүсэлт гаргасны үндсэн дээр гэрээ байгуулж ажиллана.

8.7.Энэ хуулийн 8.6-д заасан гэрээний хэрэгжилтэд тухайн сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасаг, байгаль орчны хяналтын улсын байцаагч хамтран хяналт тавина.

8.8.Энэ хуулийн 8.4-т заасан түүхий эд, бүтээгдэхүүнийг холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлагын дагуу чанараар ангилах, шаардлагатай анхан шатны тордолт хийх, багцлах, савлах, шошголох, хадгалах үйл ажиллагааг төвлөрсөн цэг, эсхүл агуулах хариуцан гүйцэтгэнэ.

8.9.Төвлөрсөн цэг, эсхүл агуулах нь энэ хуулийн 10.1-д заасан бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санд бүртгүүлж, хүлээн авсан, худалдсан түүхий эд, бүтээгдэхүүний мэдээллийг оруулах үүрэгтэй.

8.10.Төвлөрсөн цэг, эсхүл агуулахаас түүхий эд, бүтээгдэхүүнийг зориулалтын тээврийн хэрэгслээр хөдөө аж ахуйн өртгийн сүлжээний дараагийн шатны хүлээн авагчид хүргэх асуудлыг талууд гэрээгээр тохиролцоно.

8.11.Энэ хуулийн 8.10-д заасан хүлээн авагч нь түүхий эд, бүтээгдэхүүнийг стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг ханган эцсийн хэрэглэгчид хүргэх үүрэгтэй.

8.12.Төвлөрсөн цэг, эсхүл агуулахыг байгуулах, өргөтгөх, тогтвортой ажиллахтай холбогдон гарах зардлыг энэ хуулийн 8.6-д заасны дагуу гэрээ байгуулсан этгээд хариуцна.

9 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний чанарын үнэлгээ, баталгаажуулалт

9.1.Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг холбогдох стандартын дагуу үнэлж, баталгаажуулна.

9.2.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний төрөл тус бүрээр ангилал, зэрэглэлийн стандартын төсөл боловсруулах, эрх бүхий байгууллагаар

батлуулах, батлагдсан стандартын хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

9.3.Аймаг бүр хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг шинжлэн судалдаг зориулалтын тоног төхөөрөмж, мэргэшсэн шинжээч бүхий лабораторитай байна.

9.4.Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний эрүүл ахуй, чанарын шинжилгээг холбогдох хуулиар зохицуулна.

9.5.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулан өвс хадлан бэлтгэх, жор тэнцвэржүүлсэн тэжээл үйлдвэрлэх, импортлоход тавих шаардлагыг холбогдох стандартаар нарийвчлан тогтооно.

10 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн өртгийн сүлжээний бүртгэл, мэдээлэл

10.1.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь блокчейн технологийг өгөгдлийн дүн шинжилгээний програмтай хослуулан нэвтрүүлсэн хөдөө аж ахуйн бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим сан (цаашид “нэгдсэн цахим сан” гэх)-тай байна.

10.2.Нэгдсэн цахим санд хүнсний баталгаат болон аюулгүй байдлын, зөвшөөрлийн, мал аж ахуй, тариалангийн үйлдвэрлэлийн, малын генетик нөөц, мал, амьтан, ургамлын эрүүл мэндийн, биологийн аюулгүй байдлын, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний, хөдөө аж ахуйн зах зээл, түүхий эд, бүтээгдэхүүний үнийн бүртгэл, мэдээллийн дэд сан ажиллана.

10.3.Нэгдсэн цахим сан нь цахим хөгжлийн төрийн бодлого, хөтөлбөрт нийцсэн байх бөгөөд цаг хугацаа, орон зайнаас үл шалтгаалан хэрэглэгчид төрийн үйлчилгээг хурдан шуурхай, ил тод, хүндрэл чирэгдэлгүй авах бололцоог бүрдүүлсэн байна.

10.4.Нэгдсэн цахим санг бүрдүүлэх, хөтлөх, мэдээллийн дүн шинжилгээ хийх, их өгөгдөл боловсруулах, мэдээлэл дамжуулах, хадгалах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна.

10.5.Нэгдсэн цахим сан нь урт хугацааны мэдээллийн архивтай байна.

11 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн өртгийн сүлжээнд оролцогчдын эрх, үүрэг

11.1.Хөдөө аж ахуйн өртгийн сүлжээнд оролцогч нь дараах эрх, үүрэгтэй:

11.1.1.үйлдвэрлэлээ өргөтгөх, хөгжүүлэх, бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулах зорилгоор төсөл боловсруулж, зээл, санхүүгийн дэмжлэг авах;

11.1.2.шинэ техник, технологи, тоног тэхөөрөмжийг нэвтрүүлэх, ашиглах, зөвлөн туслах үйлчилгээ авах;

11.1.3.өртгийн сүлжээний өөрт хамаарах үе шатанд зохистой дадал нэвтрүүлэх, түүнийг баталгаажуулах;

11.1.4.холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангах;

11.1.5.үйлдвэрлэсэн, бэлтгэн нийлүүлсэн, боловсруулсан түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, эрүүл ахуй, чанарын баталгааг хариуцах;

11.1.6.үйлдвэрлэсэн, бэлтгэн нийлүүлсэн, боловсруулсан бүтээгдэхүүний тоо хэмжээг бүртгэл, мэдээллийн холбогдох дэд санд мэдээлэх;

11.1.7.хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ

12 дугаар зүйл.Тогтвортой хөдөө аж ахуйн төлөвлөлт

12.1.Тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх зорилгоор улсын хэмжээнд дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөртэй байна.

12.2.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 12.1-д заасан зорилтот хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохицуулна.

12.3.Зорилтот хөтөлбөрт тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх зорилго, зорилт, үйлдвэрлэх түүхий эд, бүтээгдэхүүний жил бүрийн төлөвлөлт, хүрэх түвшин, тэдгээрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа, арга хэмжээ, санхүүжилтийн хэмжээ, эх үүсвэрийг тодорхойлсон байна.

12.4.Аймаг, нийслэл, хот, сум, дүүрэг нь өөрийн онцлогт нийцүүлэн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.

12.5.Энэ хуулийн 12.4-т заасан төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй байгуулсан гэрээний дагуу тайлагнана.

12.6.Энэ хуулийн 12.2-т заасан зорилтот хөтөлбөр, 12.5-д заасан гэрээний хэрэгжилтийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж жил бүр үнэлж, тайлагнана.

13 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн газар

13.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх баталгааг хангах зорилгоор төрөөс холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид газрыг ашиглах, эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.

13.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах, эзэмших газрын байршил, хэмжээ, отор нүүдэл хийх, доройтсон бэлчээрийг сайжруулах арга хэмжээ, өвөлжөө, хаваржааны бэлчээрийн болон мал услах уст цэг, худгийн хоорондох зай, байршлыг усны нөөц, уст цэгийн хайгуул, судалгааны дүнд үндэслэн аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгана.

13.3.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээний усны нөөц, уст цэгийн хайгуул, судалгаа хийх, хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг Усны тухай хуулиар зохицуулна.

13.4.Энэ хуулийн 13.2-т заасан төлөвлөгөөний салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь бэлчээр ашиглалтын төлөвлөгөө байна.

13.5.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалттай газар, уст цэг ашиглалтын төлөв байдал, хөрсний үржил шим, чанарыг хянан баталгаагаар холбогдох эрх бүхий мэргэжлийн байгууллага тогтоож, үнэлнэ.

13.6.Хөдөө аж ахуйн газрын ангиллыг өөрчлөх, ангилал шилжүүлэх тохиолдолд Газрын тухай хуулийн 23.2.9-д заасныг баримтлах ба улсын хөгжлийн бодлогын зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд хөдөө аж ахуйн газрыг нэгдмэл сангийн өөр ангилалд шилжүүлэхгүй.

13.7.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч нь газрыг зориулалтын дагуу зохистой эзэмшиж, ашиглана.

13.8.Энэ хуулийн 13.6-д заасан газрын хөрсний бүтэц, үржил шимийг өмнөх хянан баталгааны дүнгээс дордуулахгүй байх, хамгаалах, доройтлоос сэргийлэх, нөхөн сэргээх, сайжруулах үүргийг хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч хариуцна.

13.9.Гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон, мал аж ахуйн өвөлжилт, хаваржилт хүндэрсэн үед Газрын тухай хуулийн 52.9-д заасны дагуу тогтоосон отрын нөөц нутгийг ашиглах ба нийт бэлчээрийг ашиглахтай холбоотой харилцааг тухайлсан хуулиар зохицуулна.

14 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хүний нөөц

14.1.Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн зорилтыг шийдвэрлэхэд шаардагдах мэргэшсэн хүний нөөцийн хэрэгцээг мэргэжил, мэргэшлийн түвшнээр урт, дунд хугацаанд тодорхойлж, хэрэгцээг хангах арга хэмжээг энэ хуулийн 12.1-д заасан зорилтот хөтөлбөрт тусгана.

14.2.Тухайн аймаг, нийслэл, хотын хэмжээнд хөдөө аж ахуйн өртгийн сүлжээн дэх хүний нөөцийн хангамж, эрэлт, нийлүүлэлтийн судалгаа гаргаж, дутагдаж буй ажлын байранд захиалгаар хүний нөөцийг бэлтгэх арга хэмжээг энэ хуулийн 12.4-т заасан төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг зохион байгуулна.

14.3.Энэ хуулийн 14.2-т заасны дагуу захиалгаар бэлтгэх хүний нөөцийн сургалтын зардлыг орон нутгийн төсвөөс хариуцаж, төгсөлтийн дараах ажлын байранд ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

14.4.Хөдөө аж ахуйн өртгийн сүлжээнд ажиллаж буй мэргэжилтнийг 3 жил тутамд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, мэргэжлийн ур чадварын түвшнээр үнэлэх, мэргэшлийн зэрэг олгох асуудлыг тухайн чиглэлийн мэргэжлийн холбоо холбогдох сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулна.

14.5.Энэ хуулийн 14.4-т заасан хөдөө аж ахуйн салбарын ажилтан, мэргэжилтний мэргэжлийн ур чадварын түвшинг үнэлэх, мэргэшлийн зэрэг олгох асуудлыг тухайн салбарын хуулиар зохицуулна.

14.6.Хөдөө аж ахуйн өртгийн сүлжээний мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, ажлын байранд зуучлах асуудлыг мэргэжлийн сургалтын байгууллага, сургалт, үйлдвэрлэлийн төв, эсхүл сургалт явуулах эрх бүхий мэргэжлийн холбоо хариуцан гүйцэтгэнэ.

14.7.Малчныг сургах, мэдлэг, туршлага солилцох, тэдгээрийн залгамж халааг бэлтгэхтэй холбогдсон харилцааг Малчны тухай хуулиар зохицуулна.

14.8.Тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд шаардагдах эрэлттэй мэргэжлээр их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд шинээр анги нээх, гадаад оронд сургах, тэтгэлэгт тэргүүн ээлжинд хамруулах асуудлыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дангаар, эсхүл боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулна.

14.9.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчийн албан, албан бус сургалтаар боловсрол эзэмших, бие даан суралцахад мэдээллээр ханган, зөвлөн туслах, мэргэшүүлэн сургах чиг үүргийг хөдөө аж ахуйн чиглэлийн сургалтын байгууллага, салбарын судалгаа, хөгжлийн болон болон бусад сургалтын төв, мэргэжлийн холбоо, насан туршийн суралцахуйн төв тус тус хэрэгжүүлнэ.

14.10.энэ хуулийн 14.9-д заасан байгууллага нь хөдөө аж ахуйн сургалт хариуцсан менежертэй байна.

14.11.Хөдөө аж ахуйн албан бус боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хөдөө аж ахуйн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.

14.12.Энэ хуулийн 14.9-д заасан албан бус сургалтын үр дүнг чадамжийн гэрчилгээгээр баталгаажуулж болно.

14.13.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сургалтын хөтөлбөрийн чанарт мэргэжлийн хараат бус үнэлгээг хийлгэж болно.

14.14.Олон улсын гэрээний хүрээнд хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нь зохион байгуулсан сургалт, түүнд хамрагдагсдын талаарх мэдээллийг нэгдсэн цахим санд тухай бүр оруулна.

15 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн судалгаа ба хөгжүүлэлт

15.1.Хөдөө аж ахуйн судалгаа ба хөгжүүлэлтийн тогтолцоо нь дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, оюуны өмчөөр хамгаалагдсан мэдлэгийг эргэлтэд оруулах, зах зээлд гаргах, энэ хуулийн 12.1-д заасан зорилтот хөтөлбөрт тусгасан судалгаа, хөгжүүлэлтийг гүйцэтгэхэд чиглэгдэнэ.

15.2.Салбарын шинжлэх ухаан, технологи, инновацийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах чиг үүргийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

15.3.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дэргэдээ салбарын шинжлэх ухаан, технологи, инновацын орон тооны бус салбар зөвлөл /цаашид "Салбар зөвлөл" гэх/-тэй байна.

15.4.Салбар зөвлөл нь Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 13.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

15.5.Энэ хуулийн 15.1-д заасан үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн, эдийн засгийн өгөөж, нөлөөллийн талаарх тайланг салбарын судалгаа, хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллага жил бүр хариуцан гаргаж, Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

15.6.Салбар зөвлөл энэ хуулийн 15.5-д заасан тайланг хэлэлцэн дүгнэлт, зөвлөмжийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

15.7.Салбарын судалгаа, хөгжлийн асуудал хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага нь энэ хуулийн 15.5-д зааснаас гадна хөдөө аж ахуйн салбарын технологи, инновацийн судалгааны үр дүнг нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

15.8.Хөдөө аж ахуйн өртгийн сүлжээнд оролцогчид шинэ мэдлэг, инновац, технологи эзэмшүүлэх, дэвшилтэт технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд чиглэгдсэн зөвлөн туслах үйлчилгээг салбарын судалгаа, хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллага болон салбарын мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллага, дангаар болон түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.

15.9.Салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд хийгдсэн судалгаа, хөгжүүлэлтийн ажлын үр дүнг төсөл хэрэгжүүлэгч Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дүгнэлт, зөвлөмж гаргуулж, тайланг салбарын судалгаа, хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллагад хүргүүлнэ.

15.10.Тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх хүрээнд гадаадын зээл, тусламжаар шинээр хэрэгжүүлэх төслийн саналыг Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, дүгнэлт гаргуулж, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж байна.

16 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх

16.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах удирдлагын нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлнэ.

16.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэлийг доор дурдсан ангиллын дагуу үнэлэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 16.2.1.байгаль орчны;
- 16.2.2.эдийн засгийн;
- 16.2.3.нийгмийн.

16.3.Энэ хуулийн 16.2.1-д заасан нөлөөллийн эрсдэлд бэлчээрийн болон тариалангийн газрын доройтол, усны хомсдол, генетик нөөцийн төлөв, уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгаруулалт, хог хаягдлын менежмент хамаарна.

16.4.Энэ хуулийн 16.2.2-т заасан нөлөөллийн эрсдэлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр, бүтээмж, өрсөлдөх чадвар, эдийн засгийн өгөөж, түүхий эд, бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл, санхүүжилтийн хүртээмж, төрийн дэмжлэгийн үр дүн хамаарна.

16.5.Энэ хуулийн 16.2.3-т заасан нөлөөллийн эрсдэлд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчийн тогтвортой ажлын байр, ажиллах орчны аюулгүй байдал, нийгмийн баталгааны өөрчлөлтөд дасан зохицох чадамж хамаарна.

16.6.Аймаг, нийслэл, хот, сум, дүүрэг нь энэ хуулийн 16.2-т заасан эрсдэлээс сэргийлэх, хариу арга хэмжээ авах төлөвлөгөөтэй байна.

16.7.Энэ хуулийн 16.6-д заасан төлөвлөгөөг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, Засаг дарга хэрэгжилтийг зохион байгуулна.

16.8.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэлийн түвшинг тухайн эрсдэлийн магадлал, үр дагаврын харилцан хамаарлыг үндэслэн их, дунд, бага гэж ангилна.

16.9.Эрсдэлийн түвшинг тогтоох, үнэлэх ажлыг тухайн чиглэлийн мэргэжлийн байгууллага, эсхүл шинжээчийн баг энэ хуулийн 16.10-д заасан аргачлалын дагуу жил бүр хийнэ.

16.10.Тогтвортой хөдөө аж ахуйн эрсдэлийн түвшинг тогтоох, үнэлэх аргачлалыг хөдөө аж ахуй, байгаль орчин, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран батална.

16.11.Энэ хуулийн 16.9-д заасан эрсдэлийн үнэлгээ хийхэд шаардагдах зардлыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

16.12.Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд Засгийн газар шийдвэр гаргаж, холбогдох этгээд хэрэгжилтийг хангана.

16.13.Аймаг дундын отрын бүс нутгийн бэлчээр, хашаа, худаг, бусад байгууламжийг ашиглах, хамгаалах, төлөвлөх үйл ажиллагааг аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын асуудал хариуцсан төрийн байгууллага холбогдох шатны Засаг даргатай хамтран зохион байгуулна.

16.14.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн гамшгийн бэлэн байдлыг хангах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг Гамшгаас хамгаалах тухай хуулиар зохицуулна.

16.15.Энэ хуулийн 16.8-д заасан эрсдэлийн түвшингийн ангиллын хүрээнд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, тухайн шатны Засаг дарга хэрэгжилтийг зохион байгуулна.

17 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн даатгал

17.1.Хөдөө аж ахуйн дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, эрсдэл, түүний нөлөөллийг бууруулах зорилгоор хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог хөгжүүлнэ.

17.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн даатгал олон төрлийн багцтай байж болно.

17.3.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч нь үйл ажиллагааны төрөлжилт, онцлогоос хамаарч даатгалын нэр төрөл, багцыг сонгон хэрэглэнэ.

17.4.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн даатгалтай холбогдох харилцааг хуулиар зохицуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДЭМЖЛЭГ

18 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжлэг

18.1.Энэ хуулийн 5.2-т заасан бодлогын зарчим, зорилгыг үндэслэн хөдөө аж ахуйн өртгийн сүлжээний оролцогчид төрөөс дэмжлэг үзүүлнэ.

18.2.Төрөөс үзүүлэх дэмжлэг нь дараах хэлбэртэй байна:

- 18.2.1. шууд болон шууд бус татаас;
- 18.2.2.тарифын болон тарифын бус зохицуулалт;
- 18.2.3. хөнгөлөлттэй зээл, зээлийн хүүгийн хөнгөлөлт;
- 18.2.4.бусад.

18.3.Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор төрөөс дэмжлэг үзүүлэх өртгийн сүлжээний оролцогч нь дараах шаардлагыг хангасан байна:

- 18.3.1.зохистой дадал нэвтрүүлсэн, баталгаажуулсан;
- 18.3.2.стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан, баталгаажуулсан;

18.3.3.чанараас хамаарсан үнийн тогтолцоог нэвтрүүлсэн.

18.4.Хөдөө аж ахуйн дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор доор дурдсан үйлдвэрлэл, үйл ажиллагаанд тэргүүн ээлжинд дэмжлэг үзүүлнэ:

18.4.1.таримал ургамлын үр үржүүлэг, үрийн шинэчлэл, дэвшилтэт шинэ сорт бүтээх;

18.4.2.үржлийн цөм сүргийн мал үржүүлэх, шинэ үүлдэр, омог бүтээх, удмын сан, ашиг шимийг сайжруулах;

18.4.3.импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх.

18.5.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цар хүрээг тэлэх зорилгоор энэ хуулийн 18.3-д заасан шаардлагыг хангасан дараах чиглэлийн үйлдвэрлэл эрхлэгчид дэмжлэг үзүүлнэ:

18.5.1.хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний төвлөрсөн цэг, эсхүл агуулахын үйл ажиллагаа;

18.5.2.органик, эсхүл газар зүйн заалттай, эсхүл брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэл;

18.5.3.экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэл;

18.5.4.ногоон үйлдвэрлэл;

18.5.5.биотехнологийн үйлдвэрлэл;

- 18.5.6.агро-ойн аж ахуй;
- 18.5.7.хөдөө аж ахуйн аялал жуулчлал;

18.6.Тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх, салбар хоорондын уялдааг хангах зорилгоор энэ хуулийн 18.3-д заасан шаардлагыг хангасан доор дурдсан үйлдвэрлэл, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж болно:

18.6.1.үйлдвэрлэлийн цар хүрээ, хүчин чадлыг нэмэгдүүлэх, дэд бүтэц, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, сайжруулах;

18.6.2.шинэ мэдлэг, технологи бүтээх, нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх, судалгаа ба хөгжүүлэлт хийх;

18.6.3.гарааны бизнес болон орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр, логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх, хувийн хэвшлийн болон хоршоодын үйл ажиллагааг эрчимжүүлэх;

18.6.4.тариалангийн бүсэд эрчимжсэн мал аж ахуй, тариалан хослон эрхлэх;

18.6.5.сургалт, мэргэжлийн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх;

18.6.6.хүлэмжийн хийг бууруулах, шингээх санаачилга нэвтрүүлэх;

18.6.7.уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох;

18.6.8.бэлчээрийн газрыг доройтлыг бууруулах, доройтлоос сэргийлэх;

18.6.9.сум дундын хэрэгцээг хангах өвс, тэжээлийн нөөцийн агуулах, тэжээлийн үйлдвэр барьж байгуулах, ажиллуулах.

18.7.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн мөнгөн болон мөнгөн бус дэмжлэгийн нийт хэмжээ, бүтээмж, эдийн засаг, нийгэм, байгаль орчны нөлөөлөл, өгөөжийг жил бүр тооцож, үр дүнд суурилсан төсөв, бодлогын арга хэмжээг төлөвлөх, дэмжлэгийг оновчтой тогтоох, хуваарилахад ашиглана.

18.8.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэхтэй холбоотой нарийвчилсан харилцааг тухайн салбарын хууль тогтоомжоор зохицуулна.

18.9.Салбар хоорондын уялдааг хангах зорилгоор төрөөс тухайлсан бүс нутагт бодлогын тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж болно.

18.10.Үндэсний баялгийн сангаас хөдөөгийн хөгжил, хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэл, бүтээмж, экспортыг нэмэгдүүлэхэд зориулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлж, энэ хуулийн 18.3-18.6-д заасан дэмжлэгийг үзүүлж болно.

18.11.Гадаад орон, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжих төслийн зорилго, зорилт, хамрах хүрээг энэ хуулийн 18.3-18.6-д дэмжлэг үзүүлэхээр заасан үйлдвэрлэл, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ

19 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн салбар дахь төрийн удирдлага, зохицуулалт

19.1.Хөдөө аж ахуйн салбарын бодлого боловсруулах, төлөвлөх, хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих, дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх чиг үүргийг улсын хэмжээнд хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

19.2.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд мал, таримал ургамлын генетик нөөц, ургамлын болон мал, амьтны эрүүл мэнд, генийн сан, малын эм үйлдвэрлэл, лаборатори, аймаг дундын отрын бэлчээр, шинжлэх ухаан, инновац, судалгаа, шинжилгээ, нэвтрүүлэлт, хөдөө аж ахуйн өртгийн сүлжээ хариуцсан төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд тус тус ажиллана.

19.3.Аймаг, нийслэл, сум, дүүрэгт хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн болон өртгийн сүлжээний бодлого, түүний хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэдээлэх, тайлагнах асуудлыг тухайн шатны нутгийн захиргааны байгууллага хариуцна.

19.4.Энэ хуулийн 19.2, 19.3-т заасан байгууллага нь энэ хуульд болон тухайн салбарын хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

20 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийг өргөжүүлэхэд төрийн чиг үүрэг

20.1.Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний мал эмнэлэг, ургамлын ариун цэвэр, хорио цээрийн гэрээ, хэлэлцээрийг байгуулж, худалдааны түнш орны тоог нэмэгдүүлэх арга хэмжээг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санаачлан зохион байгуулна.

20.2.Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын зах зээлийг судалж, экспортын голлох бүтээгдэхүүн тус бүрээр бодлого, стратеги төлөвлөгөөг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.

20.3.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт, гадаад худалдааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газар, холбогдох байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

20.3.1.хоёр улсын болон олон талт гадаад хамтын ажиллагааны хүрээнд худалдаа, эдийн засгийн болон худалдааны ерөнхий хэлэлцээр байгуулах, тарифын болон тарифын бус хязгаарлалтыг зохицуулахад оролцох;

20.3.2.гадаад улс, олон улсын байгууллагатай байгуулсан мал эмнэлэг, ургамлын ариун цэвэр, хорио цээрийн гэрээ, хэлэлцээрийн бүртгэл, мэдээллийн дэд сан үүсгэж, олон нийтэд нээлттэй хүргэх боломжоор хангах.

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ БУСАД ЗҮЙЛ

21 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

21.1.Энэ хуулийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол холбогдох албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

21.2.Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

22 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

22.1.Энэ хуулийг ... оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202. оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуульд доор дурдсан агуулгатай 52.14 дэх хэсэг нэмсүгэй:

“52.14.Бэлчээрийн газраас улсын тусгай хэрэгцээнд авах, эсхүл газрын нэгдмэл сангийн өөр ангилалд шилжүүлэх тохиолдолд тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг авсны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.”

2 дугаар зүйл. Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.9 дэх хэсгийн “ашиглах” гэсний дараа “сумын отрын нөөц нутаг, түүний заагийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“52.7.Өвөлжөө, хаваржааны газарт байрлах гэр, сууцны болон малын хашаа, саравчны доорх газрыг Монгол Улсын иргэн хот айлаар дундаа хамтран, эсхүл малчин өрх дангаар эзэмшиж болно. Газар эзэмших малчин өрхийн гишүүд нь Монгол Улсын иргэн байх ба нэг малчин өрхөд эзэмшүүлэх гэр, сууцны болон малын хашаа, саравчны доорх газрын хэмжээ нь энэ хуулийн 29.1-д зааснаас хэтрэхгүй байна.”

4 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “29.1-д” гэснийг “29.1, 52.7-д” гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Хөдөө аж ахуйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202. оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МАЛЧНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Малчны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.4 дэх заалтын “орон сууцны” гэсний өмнө “нар, салхины эрчим хүч ашиглахад болон гэр,” гэж, мөн зүйлийн 4.2.5 дахь заалтын “малчнаар” гэсний өмнө “малчдын саналыг үндэслэн зургаан настай хүүхдийг эцэг, эхийн асрамжаас нь хөндийрүүлэхгүйгээр зайнаас сургах сургалтад хамруулах,” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийн “хоршоо,” гэсний дараа “дундын хоршоо,” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Малчны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.1.2.”мал аж ахуйн үйлдвэрлэл” гэж Хөдөө аж ахуйн тухай хуулийн 4.1.2-т заасныг;”.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хөдөө аж ахуйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202. оны ... дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Тариалангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг:

”16.4.Энэ хуулийн 16.1-д заасан тариалангийн үйлдвэрлэлд холбогдох стандарт, техникийн зохицуулалтыг дагаж мөрдөнө.”

2/3 дугаар зүйлийн 3.1 7, 3.1.8 дахь заалт:

3.1.7.“эрчимжсэн мал аж ахуй” гэж Хөдөө аж ахуйн тухай хуулийн 4.1.5-д заасныг;

3.1.8.“агро ойн аж ахуй” гэж Хөдөө аж ахуйн тухай хуулийн 4.1.9-д заасныг.”

2 дугаар зүйл.Тариалангийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/12 дугаар зүйл:

“12 дугаар зүйл.Агро-ойн аж ахуйн газар

12.1.Агро-ойн аж ахуйн газарт мод, сөөг тариалалтыг тариалангийн, эсхүл мал аж ахуйн, эсхүл тариалан болон мал аж ахуйн үйлдвэрлэлтэй зориудаар хослуулан эрхэлж байгаа газар хамаарна.

12.2.Тариалан эрхлэгч агро-ойн аж ахуйг өөрийн тариалангийн газарт эрхэлж болно.

12.3.Агро-ойн аж ахуйд жимс, жимсгэний аж ахуй болон тариалангийн газрын хөрсийг салхины элэгдэл, эвдрэлээс хамгаалах зорилгоор байгуулсан тариалангийн ойн зурвас хамаарна.”

2/21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 21.3 дахь хэсэг:

“21.1.Хөдөө аж ахуйн тухай хуулийн 12.1-т заасан дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөрт тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөлтийг тусган хэрэгжүүлнэ.

21.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн тариалангийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг Хөдөө аж ахуйн тухай хуулийн 12.4-т заасан төлөвлөгөөнд тусгаж, сум, дүүрэг бүрээр хэрэгжилтийг зохион байгуулна.

21.3.Энэ хуулийн 21.2-т заасан төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг Хөдөө аж ахуйн тухай хуулийн 12.5-т заасны дагуу тайлагнана.”

3/22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг:

“22.1.Хүн амыг дотоодод тариалсан төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнээр хангах арга хэмжээг энэ хуулийн 21.1-т заасан хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.”

4/6 дугаар зүйлийн 6.2.6 дахь заалт:

“6.2.6.агро-ойн аж ахуйн газар;”

5/25 дугаар зүйлийн 25.1.3 дахь заалт:

“25.1.3.агро-ойн аж ахуй эрхлэх;”

3 дугаар зүйл.Тариалангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 21.3 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг тус тус доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

4 дүгээр зүйл.Тариалангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 5.1, 5.3, 5.5, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “атар” гэснийг “бэлчээр, хадлангийн” гэж, 15 дугаар зүйлийн 15.1, 15.4, 15.5 дахь хэсгийн “тариалангийн” гэсний дараа “болон эрчимжсэн мал аж ахуйн” гэж, мөн зүйлийн 15.3 дахь хэсгийн “тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтний” гэсний “хөдөө аж ахуйн тасгийн” гэж, мөн зүйлийн 15.7 дахь хэсгийн “атар” гэснийг “болон бэлчээр, хадлангийн” гэж, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “засаг захиргааны нэгжээр” гэснийг “засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр” гэж, мөн зүйлийн 17.5 дахь хэсгийн “тусгайлсан бэлчээрт эрхэлнэ.” гэснийг “эрхлэхдээ тариалангийн газрын ашиглагдахгүй байгаа талбайг таримал бэлчээрээр, эсхүл малын тэжээлийн ургамал тариалж ашиглана.” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Тариалангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсгийн “суурин болон хагас суурин” гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Тариалангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Хөдөө аж ахуйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202. оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт:

“35.1.18.Хөдөө аж ахуйн тухай хуулийн 12.4-т заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах;”

2/60 дугаар зүйлийн 60.1.21, 60.1.22 дахь заалт:

“60.1.21.Хөдөө аж ахуйн тухай хуулийн 12.4-т заасан төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

60.1.22.Хөдөө аж ахуйн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан хөдөө аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх, орон нутгийн хөгжлийн бодлогын уялдааг хангах зэрэг арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах;”

3/63 дугаар зүйлийн 63.1.15, 63.1.16 дахь заалт:

“63.1.15.Хөдөө аж ахуйн тухай хуулийн 12.4-т заасан төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

63.1.16.Хөдөө аж ахуйн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан хөдөө аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх, орон нутгийн хөгжлийн бодлогын уялдааг хангах зэрэг арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах;”

2 дугаар зүйл. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.7 дахь заалтын “хөтөлбөр” гэсний дараа “төлөвлөгөө” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11 дэх заалтын “мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах” гэснийг “хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх экосистемийн ээлтэй орон зайг бий болгох, малын генетик нөөц, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах ажлыг зохион байгуулах” гэж, 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалтын дугаарыг “35.1.19” гэж, 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалтын дугаарыг “60.1.23” гэж, 63 дугаар зүйлийн 63.1.15 дахь заалтын дугаарыг “63.1.17” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Хөдөө аж ахуйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202. оны ... дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалтын “газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх,” гэснийг “малын үүлдэр, ашиг шимийг сайжруулах, тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, Малчны тухай хуулийн 13.2.3-т заасны дагуу Малчны хөгжлийн санд хөрөнгө хуваарилах,” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хөдөө аж ахуйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202. оны ... дугаар
сарын ..-ны өдөр

Улаанбаатар
хот

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.1.11 дэх заалт нэмсүгэй:

“8.1.11.Хөдөө аж ахуйн тухай хуулийн 18.4, 18.5, 18.6-д заасан үйлдвэрлэл, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөдөө аж ахуйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202. оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 16¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“16¹ дүгээр зүйл. Мал, амьтны эрүүл мэндийн өөр өөр статустай бүс тогтоох

16¹.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх байгалийн саад, зохиомол болон дэд бүтцийн байгууламжийг ашиглан мал, амьтны эрүүл мэндийн өөр өөр статустай бүс байгуулж болно.

16¹.2. Мал, амьтны эрүүл мэндийн өөр өөр статустай бүсийг дараах байдлаар тогтоон зарлана:

16¹.2.1. мал, амьтны тодорхой нэрийн халдварт өвчний дэгдэлт, үе хөлтний шимэгчлэл сүүлийн 3 жил гараагүй, мал эмнэлгийн мэргэжлийн байгууллагаас явуулсан тандан судалгаагаар тухайн халдвар, үе хөлтний шимэгчлэл зорилтот эх сүрэгт илрээгүй тохиолдолд тухайн өвчнөөр эрүүл, тайван сум болох тухай сумын иргэдийн Төлөөлөгчийн Хурлаас гаргасан шийдвэрийг аймгийн Засаг даргын мэдүүлснээр мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталгаажуулан гэрчилгээ олгож, нийтэд зарлана.

16¹.2.2. тодорхой нэрийн халдварт болон үе хөлтний шимэгчлэх өвчнөөр эрүүл, тайван бүс болох тухай хэд хэдэн сумын иргэдийн Төлөөлөгчийн Хурлаас гаргасан шийдвэрийг аймгийн Засаг дарга хүлээн авч, энэ хуулийн 16¹.2-т заасан журмын дагуу тухайн өвчнөөр тайван, эрүүл бүсийн хилийн заагийг тогтоож, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

16¹.2.3. мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аймгийн Засаг даргын хүсэлтийг хүлээн авч, холбогдох бичиг баримт, мэдээллийг нягтлан шалгасны үндсэн дээр тухайн аймгийн өвчнөөр тайван, эрүүл бүс байгуулах тухай шийдвэрийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулан гэрчилгээ олгож, нийтэд зарлана.

16¹.2.4. тодорхой нэрийн халдварт болон үе хөлтний шимэгчлэх өвчнөөр эрүүл, тайван болох тухай хэд хэдэн аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлаас гаргасан шийдвэрийг малын эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүлээн авч, энэ хуулийн 16¹.3-т заасан журмын дагуу тухайн өвчнөөр тайван, эрүүл бүсийн хилийн заагийг тогтоолгож, мал, амьтны

эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад холбогдох бичиг баримтыг бүрдүүлж хүргүүлнэ.

16¹.2.5.мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн өвчнөөр тайван бүс нутаг байгуулах тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлнэ. Засгийн газар Монгол Улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг хамруулан мал, амьтны тодорхой нэрийн халдварт болон үе хөлтний шимэгчлэх өвчнөөр тайван, эрүүл бүс байгуулах тухай шийдвэр гаргаж, олон улсын хэмжээнд зохих журмын дагуу зарлан мэдээлнэ.

16¹.2.6.мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мал, амьтны тодорхой нэрийн өвчнөөр эрүүл тайван бүсийг тухайн халдварт өвчний эсрэг вакцин хэрэглэдэг эрүүл бүс, вакцин хэрэглэдэггүй эрүүл бүсийн аль нь болохыг ялган тодорхойлох бөгөөд энэ тухай холбогдох шатны байгууллагын шийдвэрт тодорхой тусгаж, баталгаажуулсан байна.

16¹.2.7.мал, амьтны тодорхой нэрийн өвчнөөр эрүүл, тайван бүсийн нутаг дэвсгэрийн хамрах хилийн заагийг өөрчлөх, шинэчлэн тогтоох, статусыг түдгэлзүүлэх, өөрчлөх асуудлыг энэ хуулийн 16¹.1.1, 16¹.1.3, 16¹.1.5-д заасан байгууллагууд энэ хуулийн 16¹.3-д заасан журмын дагуу хянан шийдвэрлэж байна.

16¹.3.Мал, амьтны эрүүл мэндийн өөр өөр статустай бүсийн хилийн заагийг тогтоох, түүний хугарлын цэгүүдийг тодорхойлохтой холбогдсон журмыг Засгийн газар холбогдох олон улсын байгууллагаас тогтоосон шаардлагад нийцүүлж батална.

16¹.4.Мал, амьтны эрүүл мэндийн өөр өөр статустай бүсэд хэрэгжүүлэх мал эмнэлэг, хорио цээрийн арга хэмжээний журмыг олон улсын холбогдох стандартад нийцүүлэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хөдөө аж ахуйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН СУДАЛГААНЫ
ТАЙЛАН

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

НЭГ.УДИРТГАЛ	3
ХОЁР.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН НЬ	5
1.1.Асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоосон нь:.....	5
1.2.Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, бусад этгээдийг тодорхойлсон нь.....	10
1.3.Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон нь:.....	10
ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЪЁОЛСОН НЬ.....	14
ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРЫГ ТОГТООЖ, ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН НЬ	15
ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН НЬ	19
4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө	19
4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө	21
4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө.....	23
4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө:	25
4.5.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх.....	26
ЗУРГАА.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛЖ, ДҮГНЭЛТ ХИЙСЭН НЬ	27
ДОЛОО. ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН НЬ.....	29
НАЙМ.ЗӨВЛӨМЖ	35
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	37
I.Судалсан хууль, тогттомж:.....	37
II. Ашигласан судалгаа, мэдээ, мэдээллийн жагсаалт:	37

НЭГ.УДИРТГАЛ

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.3 дахь зорилтыг хэрэгжүүлэх 1-р үе шатанд “... 5.Малчин, тариаланчдын бэлтгэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх оновчтой тогтолцоог бий болгосон байна...” гэж, 8.3 дахь зорилтыг хэрэгжүүлэх 1-р үе шатанд “...7.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтод зах зээл, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг сайжруулна.” гэж, 2-р үе шатанд “... 2.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд чанарын үнэлэмж бий болгож, биржийн арилжааны системийг бэхжүүлэх, нөөцөд түшиглэсэн боловсруулах үйлдвэрийн хүчин чадлын ашиглалтыг сайжруулж, өргөтгөнө...” гэж тус тус хөгжлийн урт хугацааны зорилгыг тодорхойлсон.

Мөн УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр”¹-ийн 3.4.1-д “мал аж ахуйн гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалтын түвшнийг сайжруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх”, 3.5.5-д “төрөөс ноос ноолуур, арьс шир, мах болон экспортын ач холбогдол бүхий бусад түүхий эдийн нэгдсэн агуулах болон тээвэр, логистикийн дэд бүтцийг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх”, Зорилт 4.4-д “эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж, хүнсний дотоодын хэрэгцээг ханган, экспортын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.” гэж тус тус тусгажээ.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.4 дэх зорилт болох “Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр”-ийн хүрээнд тус салбарын хөгжлийн талаар өргөн хүрээтэй арга хэмжээг авахаар төлөвлөөд байна. Үүнд:

“3.3.4.1.“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг үргэлжлүүлж, “Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.3.4.2.“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо бүрэн хангаж, экспортод гаргах чиглэл баримтална.

3.3.4.3.Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн, хоршооны загвар төслүүдийг бэлтгэж, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэн, сургалт зохион байгуулна.

3.3.4.4.Малын гаралтай түүхий эд бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх дундын хоршоог сумдаар бүсчлэн байгуулна.

3.3.4.5.Ноос боловсруулах үйлдвэрийг сэргээж, ноосон эдлэл, бүтээгдэхүүн, шинэ бүтээгдэхүүн болох ноосон бордоо, ноосоор хийсэн барилгын дулаалга бүтээгдэхүүнийг экспортолно.

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2022, №09

3.3.4.6.Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг жилийн дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах иж бүрэн механикжсан агуулахын нэгдсэн цогцолборыг байгуулна.

3.3.4.7.Малчдад өвөлжөө, хаваржааны газрыг урт хугацаатай эзэмших, ашиглах, тэжээлийн ургамал тариалах боломжийг олгох эрх зүйн орчныг бий болгоно.

3.3.4.8.Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулж, өвс, тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

3.3.4.9.Байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог сайжруулна.

3.3.4.10.Олон улсын стандартад нийцсэн малын вакциныг дотооддоо үйлдвэрлэж, мал эмнэлгийн лабораторийн чадавхыг сайжруулна.

3.3.4.11.Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт малын эзлэх хувийг нэмэгдүүлж, малын генийн санг хамгаалж, биотехнологийн ололтыг нэвтрүүлнэ.

3.3.4.12.Орон нутгийн онцлогт тохирсон үржлийн цөм сүрэг бий болгох ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, хүртээмжтэй зохион байгуулж, үржлийн аж ахуйг бүсүүдэд байгуулахыг дэмжинэ.

3.3.4.13.Хүн амын өсөн нэмэгдэж байгаа хүнсний хэрэгцээг хангах зорилгоор "Атар IV" аяныг хэрэгжүүлж, газар тариалангийн нийт эргэлтийн талбайг 200 мянган га-аар нэмэгдүүлнэ.

3.3.4.14."Цагаан алт" хөдөлгөөний хүрээнд малын гаралтай түүхий эдийн инновац шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжих бодлогыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.

3.3.4.15.Малын гаралтай дайвар бүтээгдэхүүнийг хаягдалгүй боловсруулж, уургийн агууламж өндөртэй түүхий эд бэлтгэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлд хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

3.3.4.16.Экспортын түүхий махны мал эмнэлэг, хорио цээрийн олон улсын шаардлагыг хангасан "Монгол мах" брэндийг хөгжүүлж, махны үнийг зах зээлийн зарчимд шилжүүлнэ.

3.3.4.17.Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн олон улсын стандартыг нутагшуулж, гадаад худалдааны хориг, хязгаарлалтыг арилгаж, сүү, цагаан идээ, мах, ноолуур, арьс ширийг дотоод, гадаадын зах зээлд борлуулах боломжийг бүрдүүлнэ.

3.3.4.18.Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийн мөшгөлт, чанарын хяналтыг сайжруулж, биржээр дамжуулан экспортолно.

3.3.4.19.Стратегийн хүнсний хангамж, нөөцийн тогтвортой байдлыг бэхжүүлнэ.

3.3.4.20.Өвлийн хүлэмжийн агро паркийн цогцолборыг 50 га талбайд байгуулж, хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор бүрэн хангана.

3.3.4.21.Бэлчээрийг нөхөн сэргээх, сэлгэх, тарималжуулах, хамгаалах, усжуулах, ургамал хамгааллыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.3.4.22.Тариалангийн газрын хөрсний үржил шимийг хамгаалан сайжруулж, усалгаатай газар тариаланг нэмэгдүүлэх хөв, цөөрөм байгуулна.

3.3.4.23.Чанар, стандартын шаардлага хангасан бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

3.3.4.24.Арьс ширний үйлдвэрийн бүсүүдэд дундын хаягдал ус цэвэрлэх байгууламж байгуулна.

3.3.4.25.Итгэмжлэгдсэн лабораториудыг лабораторийн мэдээллийн удирдлагын тогтолцоонд нэгтгэн, мэдээллийн нэгдсэн санг бий болгож, лабораторийн хүний нөөцийг чадавхжуулж, хүчин чадлыг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн лабораторийг хөгжүүлнэ.

3.3.4.26.Хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгаанд олон улсын стандартад нийцсэн арга зүйг нэвтрүүлэн, хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг сайжруулна.

3.3.4.27.Хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулна.

3.3.4.28."Биокомбинат" ТӨХХК-ийн өргөтгөл, шинэчлэлийг эхлүүлж, олон улсын стандартад нийцсэн малын халдварт, гоц халдварт өвчний вакциныг үйлдвэрлэнэ.

3.3.4.29.Малын генийн санг хамгаалж, биотехнологийн ололтыг нэвтрүүлж, өндөр ашиг шимт үхэр сүргийн тоо толгойг нэмэгдүүлж 200000-д хүргэнэ.

3.3.4.30.Мал аж ахуй, газар тариалан, жимс, хүнсний ногоо тариалалтад дэмжлэг үзүүлэх зорилготой хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн түрээсийн аж ахуйн тогтолцоог бий болгоно.

3.3.4.31.Хоршоодод "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг байгуулах, хувьцаа эзэмших, хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлж, хоршооны үйл ажиллагааг дэмжих зорилготой "Малын эзэн-Үйлдвэрийн эзэн" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.3.4.32.Хөдөө аж ахуйн салбарын хүний нөөц, залуу малчид, тариаланчдыг бэлтгэх зохистой бодлогыг хэрэгжүүлнэ.

3.3.4.33.Сорт, сорилын төв, үрийн аж ахуйг дэмжиж, үрийн шинэчлэл, хангалтыг сайжруулан, гол нэр төрлийн таримлын үр үйлдвэрлэлд урамшуулал олгоно.

3.3.4.34.Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх, хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн нөөц бүрдүүлэх хүрээнд жил бүр 100.0 мянган тонн хүнсний улаан буудайн нөөц бүрдүүлнэ.

3.3.4.35.Малчдад эрчим хүчний хэмнэлттэй өвлийн жишиг сууцны загвар түгээж, мэдлэг олгоно.” гэж тусгасан.

Манай улсад хөдөө аж ахуйн салбарт Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хууль, Тариалангийн тухай, Хүнсний тухай зэрэг дэд салбарт хамаарах бие даасан хуулиуд байдаг хэдий ч дээр дурдсан бодлогын зорилтуудад үр дүнтэй хүрэх хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн суурь харилцааг зохицуулах эрх зүйн орчин хангалттай бүрдсэн эсэхийг судлах нь зүйтэй байна.

ХОЁР.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН НЬ

1.1.Асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоосон нь:

Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталж эдийн засгийн төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцоог халснаас хойшхи хугацаанд хөгжлийн талаарх хэд хэдэн

бодлогын баримт бичиг баталж, хэрэгжүүлсээр ирсэн. Түүнчлэн хөдөө аж ахуйн салбарт шууд хамааралтайгаар доорх хуулиуд үйлчилж байна:

- Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
- Баяжуулсан хүнсний тухай хууль;
- Газрын төлбөрийн тухай хууль;
- Газрын тухай хууль;
- Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль;
- Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль;
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль;
- Малын генетик нөөцийн тухай хууль;
- Органик хүнсний тухай хууль;
- Тариалангийн тухай хууль;
- Таримал ургамлын үр, сортын тухай хууль;
- Технологи дамжуулах тухай хууль;
- Ургамал хамгааллын тухай хууль;
- Усны тухай хууль;
- Үрийн тариалангийн даатгалын тухай хууль;
- Хоршооны тухай хууль.
- Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль;
- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль;
- Хувиргасан амьд организмын тухай хууль;
- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль;
- Хүнсний тухай хууль;

Хэдийгээр хэд хэдэн хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг батлан хэрэгжүүлж байгаа боловч зорилтот үр дүнд хүрсэн эсэхийг дүгнэн судлах зайлшгүй шаардлагатай байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал²-ын 3.2.1.2-д “хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой эрдэс баялаг, **хүнс, хөдөө аж ахуй**, эрчим хүч, зам, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, санхүүгийн салбарыг олон улс, Европын Холбооны стандартад нийцүүлэн хөгжүүлнэ.” гэж заасан байдаг.

Стратегийн ач холбогдол бүхий хөдөө аж ахуйн салбар нь Монгол Улсын ДНБ-нд эзлэх хувийг тооцож үзвэл 2022 онд 13 хувь, 2023 онд 9.9 хувь, 2024 онд 7.4 хувийг тус тус эзэлж байжээ. Тус салбарын ДНБ-ийг 2015 оны зэрэгцүүлэх үнээр 2015 оны суурь нөхцөлтэй нь харьцуулж үзвэл 2022 онд +32 хувь, 2023 онд +20 хувь байсан боловч 2024 оныг -14 хувь хүртэл буурсан үзүүлэлттэй буюу 3 жил дараалан уналтад орсон байна.

Дээрх үзүүлэлтээс ажиглахад хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдээр дэвшүүлсэн зорилго, зорилтууд үр дүнд хүрэхгүй байгааг илтгэж байна.

² Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2022, №09

Энэ салбарт цөөнгүй төрийн дэмжлэг, зохицуулалт хэрэгжиж, төрөл бүрийн өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр зорьж буй боловч зорилгодоо хүрсэн зохицуулалт механизмыг бүрдүүлэхэд тулгарч буй асуудал, нөхцөл байдлыг дараах байдлаар бүлэглэн авч үзье:

1.1.1. Мал аж ахуйн салбар:

Мал аж ахуйн салбар нь 1999 он хүртэл ДНБ-ий 30-40 орчим хувийг эзэлж байсан бол 2000 оноос хойш уул уурхай, үйлчилгээний салбарын өсөлтөөс үүдэн эзлэх хувийн жин буурч 2002 онд 16,5 хувь, 2010 онд 10 хувь, 2020 онд 12 хувь, 2024 онд 7.4 хувьд хүрээд байна.

Хэдий бусад салбарын өсөлтөөс шалтгаалан ДНБ-д эзлэх хувь буурч ирсэн байх мэт боловч малын тооны хэт өсөлт, ган, зудын давтамж, газрын доройтол, цөлжилт, бэлчээрийн хомсдол, даац хэтрэлт зэрэг олон тулгамдсан асуудал энэ салбарт байна.

Тухайлбал малын тоо толгой сүүлийн 30-аад жилд тасралтгүй өссөн ч эдийн засгийн эргэлт нь удаашралтай байна. Тухайлбал, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн төгсгөл буюу 1989 онд оны эхэнд нийт 25,0 сая малын 32.8 хувьтай тэнцэх малыг хэрэглээнд ашиглаж байсан бол 2020 онд нийт мал сүргийн 21.3 хувьтай тэнцэх малыг хэрэглээнд зарцуулж байна. Энэ нь нийт малын өсөлтөөс хэрэглээнд зарлагадсан малын өсөлт хоцорч байгааг харуулж байна.

Хэдийгээр малын тоо өсч 57-71 сая толгойд хэлбэлзэж байгаа ч дотооддоо үйлдвэрлэх боломжтой малын гаралтай зарим нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийг импортоор авсаар байна. Тухайлбал, мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний импорт 2020 онд 77.6 сая ам.доллар байсан бол 2024 онд 149 сая ам.долларт хүрч, жил ирэх тусам тогтмол өсөж байна. Харин экспортын хэмжээ 2018 онд 102 сая ам.доллар, 2020 онд 52 сая ам.доллар, 2024 онд 197 сая ам.доллар зэргээр өндөр хэлбэлзэлтэй, харьцангуй тогтворгүй байна.

Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гүн боловсруулах зэргээр тэдгээрийн үнэ ханшийг тогтвортой өсгөх гарц боломж байгаа ч хэрэгжилтийг хангах **цогц бодлого дутагдалтай байгааг сүүлийн 10 жилийн статистик үзүүлэлтээс дүгнэж болохоор** байна.

Хэрэгцээнээс илүү байгаа түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулж, нэмүү өртөг шингээн гадаад зах зээлд борлуулах, хэрэглэгчийн эрэлтэд нийцүүлэхэд чиглэгдсэн нэгдмэл бодлогыг хэрэгжүүлэхийн тулд мал аж ахуйн салбарт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах, ашиглахгүй байгаа нөөцийг бүрэн ашиглаж эдийн засгийн эргэлтэд оруулах, үнийн уналтаас сэргийлэх зэрэг иргэний болоод улс орны эрх ашгийн төлөө сонирхлын хөшүүрэг, өрсөлдөөн бий болгох, аюулгүй, чанартай байх баталгаа бүхий тогтолцоог бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага ихээхэн байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэл нь байгалиас хэт хараат, эрсдэлд өртөмтгий хэвээр байсаар атал эрсдэлийн сөрөг нөлөөллийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, малын чанарыг сайжруулах, ашиг шим, бүтээмжийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалт, тэжээл хангамж, сайжруулах, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, төрөлжсөн үүлдрийн мал, амьтны эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх

зэрэг мал аж ахуй үйлдвэрлэлийн технологийн буюу орцын хүчин зүйлсэд болон үйлдвэрлэлийн гарц, чанар, хэрэглэгчийн сонирхол дээр төдийлөн анхаарахгүй хэвээр байна.

Иргэд, аж ахуйн нэгжийн хувьд эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх оролдлого, хандлага, сонирхол их байгаа ч малын тэжээлээ бэлтгэх, малаа бэлчээх газрын асуудал хүндрэлтэй, сүрэг сэлбэх үржлийн аж ахуй байхгүй, хөнгөлттэй зээлийн болон хөрөнгө оруулалтын дэмжлэгт хамрагдах боломжгүй, дотоодын үйлдвэрлэлийг импортын бараанаас хамгаалах бодлого, эрх зүйн зохицуулалтгүй зэрэг олон талт хүчин зүйлсийн нөлөөллөөр үүдэн орлого, ашиг бага байгаа учраас цөөнгүй аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа зогсооход хүрсэн байна.

Үүнээс дүгнэхэд мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашиг бага, нэг малаас авах түүхий эд, бүтээгдэхүүний гарц доогуур, малын тэжээлийн хангамж, хүртээмж туйлын хангалтгүй, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн өрсөлдөх чадвар сул, нэгж бүтээгдэхүүний үнэ бага учраас алдагдалтай ажиллажээ гэж үзэж болохоор байна.

Цаашид мал аж ахуйн үйлдвэрлэлийг тодорхой түвшинд эрчимжүүлж, бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, дотоодын үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалах, малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний импортыг үе шаттай бууруулах, хот суурингийн болон тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд тулгарч байгаа бэрхшээлийг шийдвэрлэхэд хувийн хэвшил, мэргэжлийн холбоодын санал санаачилгыг төрийн бодлогоор дэмжих, төрөөс эрх зүй, эдийн засгийн тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Мал аж ахуйн салбарын эдийн засгийн өсөлтөд ахиц гарахгүй байгаа нь **малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэ, зах зээл тогтсон системгүйтэй холбоотой** байна гэж ихэнх судлаачид үздэг. Өндөр хөгжилд хүрч чадсан Зүүн Азийн зарим орны туршлагаас харахад төрийн дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлт нь өөрийн орны эдийн засгийн хүчин чадал, багтаамж, газар зүйн байршил, байгаль цаг агаарын нөхцөл, ард түмний ахуй, амьдрал, сэтгэлгээ, түүх, соёл, уламжлал, зан заншил зэрэг өвөрмөц онцлогуудыг сайтар харгалзан үзэж, ард түмнийхээ язгуур эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, үсрэнгүй хөгжлийн ололт, амжилтад хүргэсэн байгааг дурдах нь зүйтэй.³

Олон малчин өрх малаа бүрэн саахгүй, мах сүү арьс шир, ноос ноолуурыг хүссэн хэмжээгээрээ борлуулж чадахгүй байгаагийн гол шалтгаан нь зах зээлээс газар зүйн хувьд алс хол оршдог, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид үйлдвэрлэсэн түүхий эд, бүтээгдэхүүнээ шууд нийлүүлэх зах зээлгүй буюу хүлээн авах тогтсон цэггүй, байгаа цэг нь маш хямд үнээр авах сонирхолтой, үйлдвэрт хүргэх нэгдсэн системгүй, түүнд ажиллах хүний нөөцийг бэлтгэх асуудал бүрхэг, хөдөө аж ахуйн биржийн систем орон нутагт хүрч ажиллахгүй байгаа байдаг зэрэгтэй холбоотой байна.

Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 12 дугаар сард баталж, 2018 оны 6 сараас эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Малын генетик нөөцийн тухай,

³ Монгол Улсын хөгжлийн бодлогын тогтвортой байдал, залгамж чанар уялдаанд хийсэн шинжилгээ тайлан I, Үндэсний хөгжлийн газар, УБ, 2018 он

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд мал аж ахуйн үйлдвэрлэл дэх малын генетик нөөцийг бүртгэх, төлөв байдлыг тодорхойлох, тогтвортой ашиглах, судлан хөгжүүлэх, хамгаалах, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон үйл ажиллагаа, тогтолцоо, уг харилцаанд оролцогч талуудад хамаарах эрх, чиг үүргийг нарийвчлан тогтоосон мал аж ахуйн салбарын эрх зүйн орчныг тодорхой болгоход томоохон түлхэц болсон.

Гэхдээ мал аж ахуйн салбарыг улс орны эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, дэмжихтэй холбогдсон харилцаа нь зохицуулалтгүй хэвээр байна. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэлбэр, эхлэл, төгсгөл зааггүй, **мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч субъектуудын ялгаа, заагийг эрх зүйн хүрээнд нарийвчлан тодорхойлоогүй**, бусад оролцогч талуудын эрх, чиг үүрэг, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн зарчим, хариуцлагын механизм тодорхойгүйгээс үүдэлтэйгээр төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээ, дэмжлэг үр дүн муутай, дотоодын зах зээлийн үнэ тогтворгүй байх, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн зорилтот бүлэг, үр дүнг тогтоох, мал аж ахуйн салбарын цаашдын хөгжлийг тодорхойлон чиглүүлэхэд хүндрэл учирсаар байна.

Улсын төсвөөс сүүлийн 5 жилд мал аж ахуйн салбарт 420 орчим тэрбум төгрөгийн татаас дэмжлэг үзүүлсэн байна. Гэвч салбарын эдийн засгийн үзүүлэлт, тогтвортой байдалд төдийлөн нөлөөлөөгүй байгааг анхаарах нь зүйтэй байна.

Тухайлбал ХХААХҮЯ, НҮБ-ын ХХААБ-аас гаргасан 2021 оны Монгол Улсын малын генетик нөөцийн төлөв байдлын үндэсний тайланд “малын нөхөн үйлдвэрлэлийг удирдан зохион байгуулах, тэдгээрийн биологийн нөөц боломжийг бүрэн ашиглах нөхцөл бүрдээгүйн улмаас улс орны эдийн засагт сүүлийн 10 жилд 831.1 тэрбум төгрөгийн, жилд дундажаар 81.1 тэрбум төгрөгийн хохирол учирч байна.”⁴ гэж дурдсан байдаг.

Банк, санхүүгийн байгууллагынхан мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрсдэл өндөртэй гэж үздэг учраас арилжааны зээлийг богино хугацаатай, бага хэмжээтэй, өндөр хүүтэйгээр олгодог туршлага хэвээр байна. Харин **мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд үйлдвэрлэл явуулах газар нутгийн ашиглалтын эрх баталгаагүй** учраас тогтмол хөрөнгө оруулалт хийх сонирхол нь харьцангуй бага байдаг байна.

Эдгээр асуудал нь тус салбарын тогтвортой хөгжилд тушаа болж байна гэж иргэний нийгмийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийнхэн удаа дараалан шүүмжилсэн байна.

1.1.2. Газар тариалангийн салбар:

Монгол улс нийтдээ 1050.0 мянган га тариалангийн эргэлтийн талбайтай бөгөөд өнөөдрийн байдлаар нийт 22.3 мянган иргэн, аж ахуйн нэгж үр тариа, төмс, хүнсний ногоо, жимсгэний тариалан эрхэлж байна.

Тухайлбал, 2023 оны ургац хураалтын дүнгээр 326.3 мянган га талбайгаас 456.4 мянган тонн үр тариа, үүнээс 433.8 мянган тонн улаанбуудай, 17.8 мянган га-гаас 175.0 мянган тонн төмс, 13.4 мянган га-гаас 183.0 мянган тонн хүнсний ногоо,

⁴ Монгол Улсын малын генетик нөөцийн төлөв байдлын үндэсний тайлан, ХХААХҮЯ, НҮБ-ын ХХААБ, УБ, 2021 он

92.1 мянган га-гаас 253.0 мянган тонн тэжээлийн ургамал, 113.0 мянган га-гаас 50.5 мянган тонн тосны ургамал тус тус хураан авчээ.

Энэ нь 2022 оны ургацын дүнтэй харьцуулахад улаанбуудайн үйлдвэрлэл 8 хувиар буюу 32 мянган тонн, хүнсний ногооны ургац 23 хувь буюу 35 мянган тонноор тус тус нэмэгдэж, хүн амын хүнсний ногооны хэрэгцээний 85 хувийг дотоодын үйлдвэрлэлээс хангах боломж бүрдсэн байна.

Харин улаанбуудайн ургацын 53 хувийг гурилын үйлдвэрүүд худалдан авч байгаа бол 25 хувь нь малын тэжээл болон бусад үндсэн бус хэрэглээнд хуваарилагдсан бөгөөд экспортод гараагүй тухай статистик мэдээлэл байна. Энэ нь нэг талаар улаанбуудайн ургацын илүүдэлтэй буюу салбарын үр өгөөжийг бууруулж мэдэхээр байгааг анхааралдаа авах нь зүйтэй байна. Иймд цаашид улаанбуудай тариалалтын тогтвортой байдлыг хангахын тулд экспортын зах зээлийг нээх эсвэл дотоодын хэрэгцээнд нийцүүлж тариалалтын хэмжээг төлөвлөх нь энэ салбарын жижиг дунд аж ахуйн нэгжүүдийн эрсдэлийг бууруулахаар байна.

Газар тариалангийн салбарын хувьд дотоодын үйлдвэрлэл харьцангуй эерэг үзүүлэлттэй байгаа боловч мал аж ахуйн салбартай уялдуулах, усны нөөц ашиглалтыг сайжруулах, үйлдвэрлэлийн зардлыг бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна.

1.2.Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, бусад этгээдийг тодорхойлсон нь:

Энэхүү хэсгээр тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлсон.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1	Иргэд	Манай улс уул уурхай, хөдөө аж ахуйд суурилсан эдийн засагтай улс болохын хувьд хөдөө аж ахуйн салбарын хөгжил нь иргэдийг эрүүл хоол, хүнсээр хангах, улмаар эдийн засгийн солонгоруулах, ажлын байрыг нэмэгдүүлэхэд өндөр ач холбогдолтой юм.
2	Үйлдвэрлэл эрхлэгч	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд нь малчны гараас үйлдвэрлэлийн шатанд хүргэх тогтолцоо, ложистик тодорхойгүй, зохицуулалт хангалтгүйгээс үйлдвэрлэл эрхлэгч нар үйл ажиллагаагаа тогтвортой эрхлэх боломж хязгаарлагдаж байна. Улмаар түүхий эд үнэгүйдэх нөхцөл үүсч байна.

1.3.Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон нь:

Монгол Улсын мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх асуудал төр, засгийн бодлогын төвд байнга оршсоор ирсэн ба хэд хэдэн бодлого, хөтөлбөр баталж, хэрэгжүүлж ирсэн. Гэвч мал аж ахуйн үйлдвэрлэл байгалиас хараат, эрсдэлд

өртөмтгий хэвээр байхын зэрэгцээ дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, хөгжүүлэх асуудлыг цогц байдлаар нь авч үзээгүйгээс хөгжил нь удаашралтай хэвээр байна.

Социализмын үед МАА-г бэлчээрт тулгуурласан хэлбэрээр (МАА-н хоршоолол буюу нэгдэл), мөн газар тариалан-мал аж ахуйн хосолсон хэлбэр (улсын сангийн аж ахуй, ферм)-ээр хөгжүүлж, улирлын чанартай газар тариалангийн үйлдвэрлэлээс малын тэжээлийг хангаж, жилийн 4 улирлын туршид үйлдвэрлэлтэй мал аж ахуйгаас эдийн засгийн эргэлтээр санхүүжилтийг босгох, бордоог ашиглах зэрэг бодлогыг баримтлан ажиллаж байжээ. Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн 1990-ээд оны үеэс газар тариалан ба МАА-н салбарын аль аль нь ихээхэн өөрчлөгдөж, нэгдэл, сангийн аж ахуй задрах үед иргэд хувийн өмч, малтай болж, малчдын уламжлалт мал маллагааны арга, амьдрах хэлбэр дахин сэргэж бэлчээрт тулгуурласан үйлдвэрлэлийн систем рүү шилжсэн байна. Энэ үед малчдад үзүүлдэг байсан нийгмийн үйлчилгээ үгүй болсон нь МАА-н үйлдвэрлэлийг илүү уламжлалт шинжтэй болгон өөрчлөхөд хүргэсэн.(Nixson, Walters, 2006; Sheehy, 1996, Азийн Хөгжлийн Банк, 1997; Mearns, R., 2004a, b).

Шилжилтийн үеийн өөрчлөлтөөс улбаалсан мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өнөөгийн хэлбэр нь үйлдвэрлэгчдийн зүгээс дараах нөхцөл байдалд үзүүлсэн хариу үйлдэл байсан гэж судлаачид үздэг байна.Үүнд:

- социализмын үеийн нэгдсэн тогтолцоо, удирдлага, зохион байгуулалт байхгүй болж, сангийн аж ахуй, нэгдэл задарч байхгүй болсон;
- төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн бодлогоор мал аж ахуйн үйлдвэрлэлд оруулж байсан хөрөнгө оруулалт зогсож, дэд бүтцэд болон мал аж ахуйн үйлдвэрлэлд үзүүлдэг төрийн шууд дэмжлэг үгүй болсон;
- малыг хувьчилж, малчдад мал аж ахуйгаа бэлчээр ашиглах хэлбэрээр хөтлөн явуулахаас өөр хувилбаргүй болсон;
- мал аж ахуйн үйлдвэрлэлийг удирдан зохион байгуулах мэргэжлийн тогтолцоо байхгүй болсон тул малчид аж ахуйгаа удирдах ямар ч бэлтгэлгүйгээр зах зээлийн эдийн засагт шилжин орсон;
- мал аж ахуйн салбарт олон улсын байгууллага, доноруудын туслалцаа, дэмжлэгийг тодорхой хэмжээгээр авч байсан ч энэ нь мал аж ахуйн үйлдвэрлэлд үүсч байсан бодит хэрэгцээг хангахад бүрэн чиглэгдэж чадаагүй;
- малчид ган, зудыг хохирол багатайгаар даван туулах чадавхиа бүрдүүлж чадахгүй болсон г.м

1990 оноос хойшхи хугацаанд мал аж ахуйг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхдээ малын тоо толгойг өсгөх, малын өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, бэлчээрийн царцаа, оготнотой тэмцэх, отрын бэлчээрийг ашиглах зэрэг асуудалд голлон анхаарчээ. Мөн хүн амын хүнсний хангамж, экспортыг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, байгалийн эрсдэлийн сөрөг нөлөөллийг бууруулах, малын чанарыг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх, тэжээл хангамж, бэлчээр ашиглалтыг сайжруулах зэрэг үйлдвэрлэлийн технологийн буюу орцын хүчин зүйлсийг анхаарч үйлдвэрлэлийн гарц, чанар, хэрэглэгчийн сонирхол дээр төдийлэн анхаараагүй.

Түүнчлэн эдийн засгийн бодлого, арга, хөшүүргийг хэрэгжүүлэх асуудлыг орхигдуулж, эрх зүйгээр нарийвчлан зохицуулалт хийгээгүйн улмаас хэрэгжүүлсэн

үйл ажиллагааны үр дүн тодорхой бус, бүрхэг үлдээж, зарим хэрэгжүүлж байгаа арга хэмжээг хэрэгжилтийн явцад зогсоох явдал оршиж байгаа нь бодлого, хөтөлбөрүүдийн үр дүнг хангалтгүй байдалд хүргэж байна гэж судлаачид онцлон тэмдэглэжээ.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.19-д Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хүн амын хүнсний хангамжийн бодлого; хүнсний аюулгүй байдлын асуудал; мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого; газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого; мал эмнэлэг, малын үржлийн талаар төрөөс явуулах бодлого; мал, амьтан, ургамлын хорио, цээрийн асуудал; бэлчээрийн болон таримал ургамлыг хамгаалах асуудал; мал, таримал ургамлын гаралтай хүнсний зүйл, түүхий эд болон хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт, импортын асуудал; хөдөө аж ахуйн эдэлбэр газрын болон бэлчээр ашиглалтын бодлого; малыг цаг агаарын гэнэтийн аюулаас хамгаалах бодлого; хөнгөн үйлдвэрлэлийн асуудал; жижиг, дунд үйлдвэрийн асуудал; дотоод худалдаа, үйлчилгээний бодлого, зохицуулалт; үйлдвэрлэл, технологийн паркийн асуудал; салбарын мэргэжлийн хяналтын асуудал; төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах асуудал; агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал.

Гэвч бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалтын бодлого, зохицуулалтад хамаарах асуудлууд нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамтай давхардал, хийдэл, зөрчил үүсгэж, төрийн бодлого, зорилтыг хэрэгжүүлэх ажил цалгардах тал ажиглагдаж байна. Түүнчлэн усан хангамжийн бодлогын асуудал Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, аймаг, сумын Засаг даргын хариуцах ажилд хамаарахаар Төсвийн тухай хуулиар зохицуулсан. Гэтэл Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хөдөөгийн хүн, малын усан хангамж, тариалангийн газрын усжуулалтын бодлого, зохицуулалтыг хариуцаж байгаа юм.

Мөн мал аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шууд хамааралтай байгалийн гэнэтийн аюулыг даван туулах, өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлэх асуудал Онцгой байдлын ерөнхий газрын хариуцах чиг үүрэгт хамааруулах болсны улмаас малчдын дунд өвс, тэжээлийн чанар, хүртээмжээс хамааралтай маргаан багагүй гарах үндэслэл болдог байна.

Иймд дээр дурьдсанчилан холбогдох төрийн байгууллагуудад хуулиар заасан зарим чиг үүргээ хэрэгжүүлэхэд үүсдэг давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, төрийн институцийн үйл ажиллагааны уялдаа холбоог нягтруулах замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангах, дэмжих эрх зүйн орчинг боловсронгуй болгох, тэдгээрт чиглэгдсэн цогц үйл ажиллагааг үе шаттай авч хэрэгжүүлэх шаардлага байна.

Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн уялдаа, холбоо дутмагаас бие биеээ тэтгэн хөгжүүлэх талаар дорвитой үйл ажиллагаа явагдахгүй, хоорондоо зааг ялгаатай хэвээр байсаар байна. Ялангуяа хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын удирдлага нь байнга солигдож, тогтвортой бус, мэргэшиж амждаггүй, дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх арга замыг оновчтой сонгодоггүй зэрэг нь ихээхэн нөлөөлөл үзүүлж байна гэж нийгэмд

үйлчилгээ үзүүлж байгаа, хөндлөнгийн байгууллагууд удаа дараалан шүүмжилсэн байна.

ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЪЁОЛСОН НЬ

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн орчинд тулгарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудлуудыг судалж, тодорхойлж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 4 дүгээр зүйлд заасны дагуу асуудлуудыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар томъёолж байна.

Асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгыг мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэлбэр, цар хүрээ, төрөлжилт, тогтвортой байдлыг хангах, төрөөс мал аж ахуйн хөгжлийг дэмжих зарчим, чиглэл, үйл ажиллагаа, шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах, үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад чиглэсэн хуулийн төсөл боловсруулах гэж тодорхойлж байна.

Хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуйн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг тодорхой зохицуулсан эрх зүйн орчин, бодлогын тогтвортой байдал, уялдаа холбоо сул байгаа нь мал аж ахуйн салбарын үр ашиг сул байхад тодорхой нөлөөлөл үзүүлж байна.

Мал аж ахуй, газар тариалангийн үйл ажиллагаа нь харьцангуй өөр өөр туршлага мэдлэг шаардагддаг тул малчдад тэжээлийн ургамал тариалах газар олгох нь тэднийг санхүүгийн хохиролд оруулах эрсдэлтэйг анхаарч үзэх нь зүйтэй.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн төрийн хяналт, удирдлагын тогтолцоо нь хэд хэдэн байгууллага болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудад хуваагдаж байгаа нь бодлогын нэгдмэл байдлыг алдагдуулах, үр дүнг сулруулах эрсдэлийг үүсгэж байна.

Иймд асуудлыг шийдвэрлэх зорилгыг доорх байдлаар тодорхойлж байна:

- Иймд хөдөө аж ахуйн салбарын оролцогч талуудыг оновчтой тодорхойлох, улмаар төрөөс үзүүлэх дэмжлэг, урамшууллыг тэдгээрийн зохистой оролцоонд тулгуурлах;
- Хөдөө аж ахуйн салбарын газар зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх замаар замаар салбарт үйл ажиллагаа явуулж буй иргэд, бизнесийнхэнд урт хугацаанд үйл ажиллагаа эрхлэх, улмаар хөрөнгө оруулалт татах, хамтарч ажиллах нөхцөл боломжийг дээшлүүлэх;
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоонд оролцогч талуудад зориулсан даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, татварын хөнгөлөлт урамшууллыг нэвтрүүлэх;
- Иймд төрийн хяналт, удирдлагын тогтолцоог тодорхой болгох.

Ерөнхий зорилгын хүрээнд хуулийн төслөөр мал аж ахуй үйлдвэрлэлийн төрөл, хэв шинж, хэлбэр, үйл ажиллагааны төрөлжилт, цар хүрээг тогтоож, мал аж ахуйн үйлдвэрлэлийн ангилал, төрөлжилтийг тодорхой болгон, цахим бүртгэлд оруулах, төрөөс мал аж ахуйн тогтвортой хөгжлийг дэмжихэд баримтлах зарчим, дэмжлэгийн чиглэл, хэлбэр, үйл ажиллагаа, шаардлагыг тогтоож уг харилцаанд оролцогчдын эрх, чиг үүргийг тодорхойлох, төрийн дэмжлэгийг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих, тэдгээртэй холбоотой харилцааг зохицуулах зорилтыг тавина.

ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРЫГ ТОГТООЖ, ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН НЬ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 4 дэх хэсэгт заасан зорилгыг биелүүлэхэд чиглэсэн зохицуулалтын хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг “зорилгод хүрэх байдал”, “зардал, үр өгөөжийн харьцаа”, “үр дүн” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд харьцуулан судалж, дараах дүгнэлтийг гаргаж байна.

Хүснэгт 1

Асуудлуудыг шийдвэрлэх хувилбаруудын харьцуулалт

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	“Тэг” хувилбар	Хөдөө аж ахуйн талаар төрөөс бодлого, үндэсний хөтөлбөрүүдийг баталж, хэрэгжүүлсэн ч үр дүнг бүрэн гаргаагүй. Салбарт олон төрлийн судалгаа хийгдэж, хурал зөвлөгөөнөөс дүгнэлт, зөвлөмжүүд гаргасан ч мал аж ахуйн салбарын өнөөгийн тулгамдаж буй асуудлууд, бэрхшээл хэвээр үргэлжлэхээр байна. Иймд энэхүү хувилбарыг дэвшүүлснээр зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ. Үр өгөөж өгөхгүй.	Үр ашиг муутай.
2	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Энэ хувилбараар тулгамдаад байгаа асуудлууд, тавьсан зорилгыг бүрэн шийдвэрлэхгүй, асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгаж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй тул бэрхшээл хэвээр үргэлжлэхээр байна. Иймд энэхүү хувилбараар зорилгод хүрэх боломжгүй. Харин энэ хувилбарыг 7 дахь хувилбарыг хэрэгжүүлсний дараа хэрэглэх боломжтой гэж үзэж байна.	Тодорхой хэмжээнд зардал гарах боловч тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхгүй, мал аж ахуйн үйл ажиллагааны төрөлжилт тус бүрт ижил үр дүн үзүүлэхгүй тул сөрөг үр дагавар үргэлжилнэ.	Бүрэн үр дүнд хүрэхгүй, үр ашиг муутай
3	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Энэхүү хувилбараар зорилгод бүрэн хүрэх боломжгүй. Салбарын хөрөнгө оруулалт удаан хугацаанд нөхөгддөг, байгалиас хараат, эрсдэлтэй, бүтээгдэхүүн нийлүүлэлт улирлын шинэ чанартай, орон	Зардал гарах боловч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг	Үр ашиг муутай

		нутагт тээвэр, логистикийн сүлжээ хөгжөөгүй, дэд бүтэц бүрдээгүй тул зах зээлийн механизм бүхий л үйл ажиллагаанд хүрч үйлчлэхгүй. Зах зээлийн үнийн тогтвортой бус байдалд гадаад, дотоодын олон хүчин зүйлс нөлөөлж байгаа тул энэ зохицуулалтаар тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, зорилгод хүрч чадахааргүй байна.	бууруулж чадахгүй, үр өгөөж бага.	
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Энэ хувилбар нь зорилгын тодорхой хэсэгт үр дүнтэй байж болох ч эрх зүйн орчин дутагдалтай байгаа тул зорилгод бүрэн хүрэхгүй. Хууль тогтоомж хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг эдийн засгийн арга хэрэгслээр зохицуулах боломжгүй. Нөгөө талаас тулгамдаж буй асуудлуудыг төрөөс шууд мөнгөн хэлбэрийн санхүүжилт үзүүлэх замаар шийдвэрлэх боломжгүй бөгөөд тохиромжгүй тул тус хувилбараар зорилгод хүрч чадахгүй.	Төрөөс тодорхой хэмжээний зардал гарах боловч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаварыг бүрэн бууруулж чадахгүй.	Үр ашиг муутай
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн тулгамдсан асуудлууд нь өргөн цар хүрээтэй, олон талт, салбар дундыг хамарч байгаа тул төрийн холбогдох байгууллагууд нэгдсэн бодлогын хүрээнд мэргэжлийн нийгэмлэг, холбоо зэрэг төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй харилцан уялдаатай хамтран ажиллах шаардлага үүсэх хэдий ч эрх зүйн орчныг нарийвчлан зохицуулж тодорхой болгоогүй тохиолдолд тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэхээр тодорхойлох боломжгүй юм. Энэ хувилбараар зорилгын тодорхой хэсэгт үр дүн гаргах ч тулгамдсан асуудлуудыг бүрэн	Төрөөс бага хэмжээнд зардал гарах ч асуудлыг цогцоор нь бүрэн шийдвэрлэхгүй тул үр өгөөж бага.	Бүрэн үр дүнд хүрэхгүй, үр ашиг муутай

		шийдвэрлэх зорилгод хүрч чадахгүй.		
6	Захиргааны шийдвэр гаргах	Хуулиар зохицуулагдаагүй харилцаанд захиргааны шийдвэр гарган хэрэгжүүлэх боломжгүй тул энэ хувилбараар зорилгод хүрэхгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч үр өгөөж гарахгүй.	Үр ашиг муутай
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зарим харилцаа, тулгамдсан асуудлыг зохицуулсан, хууль, тогтоомж, шийдвэрийг Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас гаргаж, хэрэгжүүлж байна. Салбарын үйлдвэрлэлийн тулгамдсан асуудлуудыг цогц байдлаар нь авч үзэхгүйгээр ихэнхдээ зөвхөн нэг талыг харж асуудлыг шийдвэрлэдэг байна. Салбараас хүн амын гол нэрийн хүнсийг, үндэсний боловсруулах үйлдвэрийн түүхий эдийг бүрэн хангах, тэдгээрт нэмүү өртөг шингээх, улмаар экспортлох замаар улс орны эдийн засагт тогтортой өсөлт бий болгох асуудал нь чухал бөгөөд үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн асуудалд хамаарч байгаа ч хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, түүний нөөцийг бүрэн ашиглахад чиглэгдсэн эрх зүйн орчинг хараахан бүрдүүлж чадаагүй байна. Үүний зэрэгцээ салбарт хамааралтай зарим хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар арилгах боломжтой.	Тодорхой хэмжээний зардал гарах боловч энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгаануудыг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх, үр өгөөжтэй байх боломжтой хувилбар гэж үзэж байна.	Үр дүнтэй

Дээр харуулсанаар асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулж үзэхэд одоогийн зохицуулалтаар хэвээр байлгах, хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх, зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн интервенц хийх, төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг

үүрэг гүйцэтгүүлэх, захиргааны шийдвэр гаргах замаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй байгаа тул хууль тогтоомж батлан гаргах хувилбар нь хамгийн оновчтой хувилбар гэж үзэв. “Зардал, үр өгөөжийн харьцаа” шалгуур үзүүлэлтийг тухайн зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбогдон улсын төсвөөс зардал гарах эсэх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд захиргааны ачаалал, нэмэлт зардал үүсэх эсэхийг ерөнхий байдлаар тандан судалж, зардал их/бага гарна, эсхүл зардал гарахгүй гэж дүгнэсэн болно. Зохицуулалтын хувилбаруудын нийгэмд үзүүлэх үр өгөөжийг ерөнхий байдлаар тодорхойлж, зардал нэмэгдэх тохиолдолд тухайн хувилбарыг хэрэгжүүлснээр нийгэмд үзүүлэх үр өгөөж нь гарсан зардлаас илүү байхаар бол үр ашигтай гэж үзэн энэ тухай тайлбарлан дүгнэлтэд оруулав. Харин зардал нэмэгдэх бөгөөд үр өгөөж бага байх төсөөлөл гарсан тохиолдолд уг хувилбар үр ашиг муутай гэж дүгнэлээ. Судалж байгаа асуудал, зохицуулалтын хувилбарын зардлыг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу нарийвчлан тооцох шаардлагатай гэж зөвлөж байна.

Түүнчлэн энэхүү тайланд дурдсан асуудлуудыг зохицуулах хувилбаруудын эерэг ба сөрөг талыг харьцуулж, асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсоны үндсэн дээр манай улсын мал аж ахуйн үйлдвэрлэл, түүний хөгжлийг дэмжихтэй холбоотой асуудлуудыг зохицуулахад хууль тогтоомж батлан гаргах хувилбар нь хамгийн сайн хувилбар мөн гэж сонгож байгаа тул Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг шинээр боловсруулах нь зүйтэй гэж дүгнэж байна.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН НЬ

Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газраас баталсан аргачлалын Тав дахь хэсэгт заасан үе шатанд сонгож авсан “хуулийн төсөл боловсруулах” хувилбарын үр нөлөөг “хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө”, “Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн дагуу тандан судалж, асуудлыг тус бүрт нь асуултад хариулах замаар дараах байдлаар дүгнэн нэгтгэн гаргасан болно. (Хүснэгт 2, 3, 4, 5-д харуулав)

Хүснэгт 2

4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Үгүй	Эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилготой арга хэмжээ биш болно.
	1.2.Оролцоог хангах		
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	үйлдвэрлэл эрхлэгчид, мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачид, мэргэжлийн холбоод, орон нутгийн удирдлагын төлөөллийг оролцуулж хэлэлцүүлэг хийж, хуулийг боловсруулах шаардлага байгаа эсэхийг тогтоосон. Оролцогчдын

		санал, хүсэлтийг хуулийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төсөлд тусгах шаардлагатай
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага	
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Үгүй
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Үгүй
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Үгүй
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм

5.Жендэрийнэрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь хүний эрхэд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй, харин хуулиар тунхагласан хүний эрхийг баталгаажуулахад ахиц гаргаж, эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Хүснэгт 3

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй

	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Зардлыг тооцоог тухайлсан аргачлалын дагуу

9.Төрийн захиргааны байгууллага	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Үгүй	нарийвчлан гаргах шаардлагатай Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбарын нэг болох мал аж ахуйн салбарыг төрөлжин хөгжихөд дэмжлэг үзүүлэх замаар үйлдвэрлэлийн өсөлт, эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.

Хүснэгт 4

4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй.

	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй.

7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхээргүй байна. Харин эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор нийгмийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Хүснэгт 5

4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө:

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй

	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөгүй

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь байгаль орчинд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй, харин эсрэгээрээ бэлчээрийн доройтол, бэлчээрийн даац хэтрэлт, нөөцийн хомсдолыг бууруулж, хариуцах, хамгаалах эзэн нь тодорхой болж, цаашид байгаль орчинд учрах эрсдэлээс сэргийлэх ихээхэн эерэг нөлөөлөл авчрахаар байна.

4.5.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Хөдөө аж ахуйн салбарын харилцааг зохицуулах зорилго бүхий шинээр боловсруулах хуулийн төсөл, түүнийг дагалдан нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцэх бөгөөд уг хуулийн төсөлтэй уялдуулан хүчингүй болгох хууль тогтоомж байхгүй гэж үзэж байна.

Харин хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Тариалангийн тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд тус тус холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулахаар байна.

ЗУРГАА.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛЖ, ДҮГНЭЛТ ХИЙСЭН НЬ

Аргачлалын 7-д зааснаар зохицуулалтын хувилбарын үр нөлөөг урьдчилан тандаж судалсны үр дүнд илрүүлсэн зохицуулалтын хувилбар тус бүрийн эерэг болон сөрөг үр нөлөөг хооронд нь харьцуулан дүгнэлт хийж, зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцаа, хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, хууль тогтоомжтой нийцэж буй эсэх, гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягталж үзэж, дор дурьдсанаар нэгтгэн харуулж байна.

Шалгуур үзүүлэлт	Зохицуулалтын хувилбар: “шинээр хуулийн төсөл боловсруулах”
Зорилгод хүрэх байдал	Хууль тогтоомжийн төсөл боловсруулснаар төрөөс дэвшүүлсэн урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг салбарт үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн таатай орчин бүрэн бүрдэхээр байна. Асуудлыг зохицуулах ерөнхий зорилгын хүрээнд хуулийн төсөл боловсруулснаар хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зохицуулалт цар хүрээг тогтоож, хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг дэмжихэд баримтлах зарчим, дэмжлэгийн чиглэл, хэлбэр, үйл ажиллагаа, шаардлагыг тогтоож уг харилцаанд оролцогчдын эрх, чиг үүргийг тодорхойлох, төрийн байгууллагуудын чиг үүргийг үйлчилгээний шатнаас шийдвэр гаргах шат хүртэл тодорхой болгох харилцааг зохицуулах шаардлага байна.
Хүний эрх, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	Сонгосон зохицуулалтын хувилбар нь хүний эрхэд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй, хуулиар тунхагласан хүний эрхийг баталгаажуулахад ахиц гаргаж, эерэг нөлөө үзүүлэхээр байна. Хуулийн төсөл боловсруулах зохицуулалт нь эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэхгүй ба Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбарын нэг болох мал аж ахуйн салбарыг төрөлжин хөгжихөд дэмжлэг үзүүлэх замаар үйлдвэрлэлийн өсөлт, эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ. Сонгосон хувилбар нь нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй, харин эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор нийгмийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэхээр байна. Энэ хувилбарын зохицуулалт нь байгаль орчинд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй, эсрэгээрээ бэлчээрийн доройтол, бэлчээрийн даац хэтрэлт, нөөцийн хомсдолыг бууруулж, хариуцах, хамгаалах эзэн нь тодорхой болж, цаашид байгаль орчинд учрах эрсдэлээс сэргийлэх ихээхэн эерэг нөлөөлөл авчрахаар байна.

Зардал үр өгөөжийн харьцаа	Сонгосон хувилбарт зардал гарах боловч асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг шийдвэрлэхэд хамгийн үр дүнтэй арга зам юм. Иймд цаашид Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төслийн зардал тооцох аргачлалын дагуу зардлыг тооцон гаргах нь үр дүнтэй юм.
Гарч болох сөрөг үр дагаврыг илрүүлэх	Сонгосон зохицууллатын хувилбарыг хэрэгжүүлснээр хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй болох нь харьцуулалтын дүгнэлтээр тодорхойлогдож байгаа тул хуулийн төсөл боловсруулснаар аливаа сөрөг үр дагавар гарахгүй гэж үзэж байна.
Хууль тогтоомжид нийцэх эсэх	Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжид бүрэн нийцэхээр байна.
Тухайн зохицуулалтаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийг тогтоох	Тухайн зохицуулалтаар мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөхийн зэрэгцээ хангагдахаар байна.

Дээрх зохицуулалтын хувилбаруудын харьцуулалтыг хийж, дүгнэсэний үндсэн дээр асуудлуудыг зохицуулах хүрээнд хууль тогтоомж батлан гаргах замаар шийдвэрлэх хувилбар нь “хамгийн тохиромжтой, оновчтой хувилбар” гэж үзэж байна.

Энэ хуулийг баталснаар эдийн засаг, нийгмийн дараах үр дүнд хүрнэ гэж үзэж байна.. Үүнд:

- Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэлийн тогтолцоог бэхжүүлнэ;
- Хүн амыг малын гаралтай гол нэрийн баталгаат хүнсээр тогтвортой хангах, дотоодын боловсруулах үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр тасралтгүй хангах боломжийг бүрдүүлж, экспортыг нэмэгдүүлнэ;
- Үйлдвэрлэл хөдөө аж ахуй хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэж, үр өгөөж сайжирна;
- Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд, бүтээгдэхүүний үнэ тогтворжиж, үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх ба инфляцид махны үнийн нөлөөллийн эзлэх хувийг бууруулна.;
- Мал, амьтны гаралтай зарим нэр төрлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах, зах зээлд нийлүүлэх сүлжээг өргөжүүлж, хүнсний аюулгүй байдлын хяналтыг сайжруулна;
- Дотооддоо үйлдвэрлэх боломжтой малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний импорт буурч, хот, суурингийн орчим болон тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл хөгжинө;
- Үйлдвэрлэл эрхлэгчдийн нийгмийн өмнө хүлээх эрх, үүрэг, хариуцлага тодорхой болж, мал аж ахуйн салбарт төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, мэргэжлийн холбоодын хамтын ажиллагаа бэхжинэ;

ДОЛОО. ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН НЬ

БНХАУ

Дэмжлэг

Хятад улсын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих үндсэн арга бол татаас юм. Улс, орон нутгийн онцлогтоо тохируулан ДХБ-ын дүрэмд нийцүүлэх замаар хөдөө аж ахуйн үндсэн бодлогоо хэрэгжүүлдэг. Татаас нь дараах үндсэн хэлбэртэй:

- Үр тариа үйлдвэрлэгчдэд олгох шууд татаас .
- Дээд зэргийн үр тарианы сортын татаас.
- Хөдөө аж ахуйн орцод зориулсан ерөнхий татаас.
- Газар тариалангийн дэвшилтэт багаж хэрэгсэл, машин механизм худалдан авахад зориулсан татаас.

Тариалангийн талбайн бүтээмжийг хадгалах, хүнсний үйлдвэрлэлийн зохистой хэмжээг дэмжих зорилгоор Засгийн газраас 2013 онд “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хөгжлийн санхүүжилтийн удирдлагын арга хэмжээ”-г хэрэгжүүлдэг ба тогтмол шинэчилдэг. Уг баримт бичгийн 6-р зүйлд зааснаар хөдөө аж ахуйд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нь дараахь зүйлд чиглэгддэг.

- Тариалангийн газар нутгийг анхаарч, тариалангийн газрын нөөцийг хамгаалах.
- Хөдөө аж ахуйн, голчлон дэвшилтэт машин техник худалдан авах, машин механизмыг худалдаж авах, шинэчлэх, инновацийн туршилтын төслүүдийг хэрэгжүүлэх татаас.
- Газар тариалан, техникийн үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлэх, атар газар эзэмших, ус хэмнэх, жимс, хүнсний ногоо, цайны химийн бордоог органик бордоогоор солих туршилт, техникийн тусламжтай хөрсийг гүн бэлтгэх, шинэчлэх, газар тариалангийн технологийг бий болгож, сурталчлах, сайжруулсан үр, аргыг сурталчлах.
- Хөдөө аж ахуйн шинэ аж ахуйн нэгжүүдийг дэмжих, хөдөө аж ахуйн нийгмийн үйлдвэрлэлийн үйлчилгээ, чадварлаг тариаланчдад зориулсан тариалалтын төлөвлөгөө, хөдөө аж ахуйн зээлийн баталгаа
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхдээ голчлон:
 - ашигтай, онцлог шинж чанартай хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих;
 - сүүний үйлдвэрийг сэргээж, мал, шувууг эрүүлжүүлэх;
 - хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн парк, суурин газруудад анхдагч, хоёрдогч, гуравдагч үйлдвэрүүдийг нэгтгэх;
 - хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний газарзүйн заалтыг хамгаалах;
 - тосгодуудад мэдээллийн технологи нэвтрүүлэх.

Мөн 8 дугаар зүйлд санхүүгийн дэмжлэгийг голчлон тариаланчид, шинээр хөдөө аж ахуй эрхлэгчид, үйл ажиллагаанд оролцогч нэгж, хувь хүмүүст олгодог.

Шинжлэх ухаан, технологийн яамнаас (ХБХЯ) байгуулсан Хөдөө аж ахуйн шинжлэх ухаан, технологийн сан нь хөдөө аж ахуй дахь технологийг арилжааны болгоход дэмжлэг үзүүлж, судалгаа, боловсруулалтад анхаарлаа хандуулж, хөдөө аж ахуйн шинэ технологийг сурталчилдаг. Санхүүжилт авахын тулд:

- Өргөдөл гаргагч нь эх газрын Хятадад байгуулагдсан аж ахуйн нэгж эсвэл судалгаа шинжилгээний байгууллага байх ёстой. Бүртгэлтэй аж ахуйн нэгжийн хувьд хувьцааных нь хувийг бүхэлд нь буюу ихэнх хувийг Хятадын дотоодын хөрөнгө оруулагчид эзэмших ёстой.
- Аж ахуйн нэгж нь дор хаяж нэг жил оршин тогтносон байх ёстой бөгөөд түүний дүрмийн сан нь хүссэн хөрөнгөөс их байх ёстой.
- Төслийг яам эсвэл Сангийн яамнаас аймгийн хэлтэст санал болгосон байх ёстой.

Удирдлага

Хятад улс төрийн олон шатлалтай бүтэцтэй, дээрээс доош чиглэсэн засаглалын загвартай. Орон нутгийн засаг захиргаа нь Төрийн зөвлөлийн удирдлаган дор байдаг төрийн захиргааны байгууллага бөгөөд түүнд харьяалагдана.

MARA болон Төрийн зөвлөлийн бусад хэлтэс

MARA нь Төрийн зөвлөлийн хөдөө аж ахуй, хөдөөгийн эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн газар юм. Түүний үндсэн чиг үүрэгт дараахь зүйлс орно.

- Хөдөө аж ахуйн хөгжлийн төлөвлөгөө, аж үйлдвэрийн бодлого боловсруулах.
- Хөдөөгийн эдийн засгийн шинэчлэлийг судалж, нэвтрүүлэх.
- Хөдөө аж ахуйн төрөл бүрийн үйлдвэрлэлийн техникийн стандартыг гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах.
- Амьтан, ургамлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, хорио цээрийн дэглэм тогтоох тухай хуулийн төсөл боловсруулах
- Гадаадтай холбоотой хөдөө аж ахуйн асуудалд хяналт тавих.

Төрийн зөвлөлийн бусад хэлтэс өөр өөрсдийн чиглэлээр хөдөө аж ахуйтай холбоотой чиг үүргийг гүйцэтгэдэг. Тухайлбал, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (YXXX), Сангийн яам, МХЕГ, Хяналтын яам зэрэг байгууллагууд хөдөө орон нутгийн татварыг хариуцдаг.

Орон нутгийн засаг захиргааны хувьд MARA нь дараахь газарт байгуулагдсан.

- Аймгийн түвшинд, тухайн орон нутгийн засаг захиргаа, ШУА-ийн үйл ажиллагааны удирдлага, удирдлага дор.
- Хотын түвшинд, тухайн орон нутгийн засаг захиргаа, ШУА-ийн үйл ажиллагааны удирдлага эсвэл дээд түвшний удирдлаган дор.

Австрали

Дэмжлэг

Хөдөө аж ахуй, Ус, Байгаль орчны газар (DAWE) нь хөдөө аж ахуй, загасны аж ахуй, ойн аж ахуйн салбарын бүтээмж, экспортыг нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын үйл ажиллагааг дэмжих зорилгоор буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалт, санхүүгийн тусламж, татварын хөнгөлөлт үзүүлдэг.

DAWE нь Австралийн фермерүүдэд дараах хэлбэрээр дэмжлэг, хөнгөлөлт үзүүлнэ.

- Ойн түймрийн гамшгийн дараа : санхүүгийн дэмжлэг, тэр дундаа тариаланчид болон хөдөөгийн ард иргэдэд туслах санхүүжилт.

- Ган болон хөдөөгийн дэмжлэг: гантай холбоотой нөхцөл байдлыг зохицуулах, ирээдүйн ган гачигт бэлтгэхэд туслах сан.
- Байгаль орчныг хадгалах, хамгаалах чиглэлээр ажилладаг эрх бүхий байгууллагуудад хандив өгөхөд татварын хөнгөлөлт үзүүлэх.

Хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор үе үе буцалтгүй тусламж олгосон бөгөөд үүнд:

- Австрали-Хятадын Хөдөө аж ахуйн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд Австрали, Хятадын хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагаа, тухайлбал техникийн солилцоо, хурал, худалдааны төлөөлөгчийн газар, семинар, ТЭЗҮ зэргийг санхүүжүүлсэн.
- Хөдөө аж ахуйн худалдаа, зах зээлд нэвтрэх хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Австралийн хөдөө аж ахуйн худалдааг гадаад зах зээлтэй явуулахад хувь нэмэр оруулах төсөл, санаачлагуудыг дэмжсэн.

Засгийн газрын хөдөө аж ахуй дахь инновацийг санхүүжүүлэх үндсэн хэрэгсэл нь Хөдөөгийн Судалгаа, Хөгжлийн Корпорацуудын сүлжээ юм. Эдгээр төрийн өмчит аж ахуйн нэгж, аж үйлдвэрийн өмчит ашгийн бус байгууллагууд нь хөдөө аж ахуйн бүтээмж, ашигт ажиллагаа, тогтвортой байдлыг сайжруулахын тулд судалгаа шинжилгээ, хөгжүүлэлт, нэвтрүүлэх, зах зээлд нэвтрэх, зах зээлийг хөгжүүлэх, сурталчлахад хөрөнгө оруулалт хийх замаар ажилладаг.

Үр тариатай холбоотой судалгаа шинжилгээний ажлыг үр тарианы судалгаа, хөгжлийн корпораци зохицуулдаг. Энэ нь 1989 онд анхдагч үйлдвэрлэлийн судалгаа, хөгжлийн хуулийн дагуу байгуулагдсан хууль ёсны корпораци бөгөөд голчлон тариалагчдын татвар, засгийн газрын шимтгэлээр санхүүждэг. Судалгаа, хөгжлийн буцалтгүй тусламж авах өргөдлийг хүлээн авч тендерийн үндсэн дээр шалгаруулдаг.

Удирдлага

Хөдөө аж ахуй, загас агнуур, ойн аж ахуйн салбарын хувьд холбоо, муж, нутаг дэвсгэр, орон нутгийн засаг захиргаа зохицуулалт, бодлогыг хэрэгжүүлдэг. Тэдгээр нь хөдөө аж ахуй, хүнсний хуулийн төрөл бүрийн асуудлыг хариуцдаг бөгөөд заримдаа байгаль орчныг хамгаалах гэх мэт салбарыг хамарсан давхцсан зохицуулалттай байдаг.

Холбооны засгийн газар

Холбооны засгийн газар нь үндэсний болон нутаг дэвсгэр дундын асуудлыг зохицуулдаг. Үндсэн хуулийн дагуу татвар, худалдаа, зохиогчийн эрх, хорио цээр, загас агнуур зэрэг асуудлаар тогтоомж гаргах эрх мэдэлтэй.

Холбооны болон муж улсын хууль тогтоомжийн хооронд зөрчил гарсан тохиолдолд холбооны хууль үйлчилнэ. Зарим асуудлын хувьд муж улсууд холбооны засгийн газарт үүрэг хариуцлагаа хүлээлгэж өгсөн бөгөөд ингэснээр компанийн хууль (Корпорацийн тухай хууль 2001), зам тээвэр, хүнсний стандарт, хэрэглэгчийн эрх (Өрсөлдөөн ба хэрэглэгчийн тухай хууль 2010) зэрэг үндэсний нэгдсэн холбооны хуулийг хэрэгжүүлэх боломжтой болсон.

DAWE нь хөдөө аж ахуй, усны нөөц, байгаль орчин, өвийг хамгаалах, бэхжүүлэх чиглэлээр холбооны түвшинд ажилладаг. Био аюулгүй байдал, амьтдын

хамгаалал, экспортын хяналт, усны бодлого, ашиглалт, ойн аж ахуй, загас агнуур зэрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлдэг.

DAWE-ийн Хөдөө аж ахуйн бодлогын хэлтэс нь хүнс, нийлүүлэлтийн сүлжээ, инноваци ба хэрэглэгчид, хураамж, үр тариа, зах зээл, өрсөлдөөнд чиглэсэн бодлого боловсруулдаг. Эдгээр бодлого нь аж үйлдвэрийн хөгжил, зохицуулалт, нийлүүлэлтийн сүлжээний удирдлага, чанарын тогтолцоо, бүтээгдэхүүний бүрэн бүтэн байдал, инноваци, хөдөлмөр, боловсрол, аюулгүй байдал, худалдаа, зах зээлд нэвтрэх зэрэгт эерэг, жигд үр дүнд хүрэхэд хувь нэмэр оруулдаг.

Муж, нутаг дэвсгэрийн засгийн газар

Муж, нутаг дэвсгэр нь эрүүл мэнд, байгалийн баялаг, хөдөө аж ахуй, нийтийн аж ахуй (цахилгаан, ус), ой мод зэрэг асуудлаар хууль гаргах өргөн хүрээний эрхтэй.

Муж, нутаг дэвсгэрийн засгийн газрууд газар эзэмших, газар ашиглах, байгаль орчныг хамгаалах, уугуул ургамлын менежмент, генийн өөрчлөлттэй (ГМ) тариалалт, зам тээвэр, мал аж ахуйн зохицуулалт зэрэг зохицуулалтыг хэрэгжүүлдэг.

Биотехнологийн бодлого, биологийн олон янз байдал болон хөдөө аж ахуйн бусад бодлогууд нь муж улсуудад өөр өөр байдаг.

Орон нутгийн засаг захиргаа

Орон нутгийн засаг захиргаанд эрх мэдлээ муж улсын хуулиар олгодог. Тэд газар ашиглалт, төлөвлөлт, хог хаягдал, байгаль орчныг хамгаалах, хүнсний аюулгүй байдал, тусгай зөвшөөрөл олгох чиглэлээр зохицуулалтыг (ихэвчлэн муж, нутаг дэвсгэрийн засгийн газрын нэрийн өмнөөс) хэрэгжүүлж, орон нутгийн замд нэвтрэх, тээвэрлэх, машин механизм ашиглах нөхцөлийг тогтоодог.

ОХУ

Дэмжлэг

Газар тариаланг хөгжүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэг 13 үндсэн чиглэл байдаг. Эдгээр чиглэлүүд нь дараахь асуудалд анхаардаг.

- Үүлдэрийн мал аж ахуй.
- Элит үрийн үйлдвэрлэл.
- Хөрсний үржил шимийг сайжруулах.
- Зорилтот нутагт хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдийг дэмжих.
- Органик хөдөө аж ахуйг хөгжүүлж, органик үйлдвэрлэгчдийг дэмжих.

Төрийн дэмжлэгийн эдгээр хэлбэрийг Улсын хөдөө аж ахуйн хөтөлбөрт илүү нарийвчлан тодорхойлсон бөгөөд энэ нь ОХУ-ын Засгийн газраас бүс нутгийн төсөвт татаас хэлбэрээр тусгагддаг. Эдгээр татаас олгох тусгай журам, шалгуурыг бүс нутгийн түвшинд тогтоож, хөдөө аж ахуйн нэгжүүдэд олгох татаасын хэмжээг бүс нутгийн эрх баригчид тогтоодог.

Төрийн дэмжлэгийн нэмэлт хэлбэр болгон төрөөс сонгон шалгаруулсан хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, боловсруулагчдад олгох зээлийн хүүгийн хүртээмжтэй, хөнгөлөлттэй нөхцөл, түүнчлэн хөдөө аж ахуйн эрсдэлийн татаасаар даатгалд хамруулдаг.

Засгийн газар

Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийн ашиглалтыг холбооны болон бүс нутгийн түвшинд хамтран зохицуулдаг. Хөдөө аж ахуйг хамтарсан засаглалын

хүрээнд тусгайлан дурдаагүй ч практикт хөдөө аж ахуйн харилцааг холбооны болон бүс нутгийн түвшинд зохицуулдаг.

Холбооны түвшний гол хууль бол Хөдөө аж ахуйн хөгжлийн тухай хууль юм. Үүнд:

- Хөдөө аж ахуйг төрийн дэмжлэг үзүүлэх үндсэн хэлбэрүүд.
- Тэдгээрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин.
- ОХУ-ын Засгийн газраас Хөдөө аж ахуйг хөгжүүлэх холбооны улсын хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар.
- Хяналтын механизм.

Хөдөө аж ахуйн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээг бүс нутгийн хөтөлбөрийн хүрээнд бүс нутгийн түвшинд тогтоодог. Тэдгээрийн агуулга нь тухайн бүс нутгийн онцлог шинж чанар, хөдөө аж ахуйн боломж, хэрэгцээ шаардлагаас хамааран ихээхэн ялгаатай байдаг.

Канад

Дэмжлэг

Farm Credit Canada нь анхдагч үйлдвэрлэгчид, хүнсний үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн бизнесүүдэд зээл, зээлийн баталгаа, бизнесийн удирдлагын зөвлөгөө, сургалт, даатгал, венчур хөрөнгө, удирдлагын нягтлан бодох бүртгэлийн программ хангамж зэрэг үйлчилгээ үзүүлдэг.

Хөдөө аж ахуйн зээлийн корпораци нь ашгийн бус корпораци бөгөөд Канад даяар тариаланчдад хямд өртөгтэй үйл ажиллагааны зээл олгодог. Түүхий эдийн зээлийн хөтөлбөрөөр үр тариа, тосны ургамал, хүнсний ногоо боловсруулахад 22 хүртэлх сарын орцын санхүүжилт олгож байна. Урьдчилгаа төлбөрийн хөтөлбөр нь баталгаа гаргаж, тодорхой зээлийн хүүгийн төлбөрийг нөхөх замаар Канад даяар үйлдвэрлэгчдэд бэлэн мөнгөний урьдчилгаа олгодог.

Канад улсад хөдөө аж ахуйг дэмждэг олон төрийн бус болон ашгийн бус байгууллагууд байдаг. Олон байгууллага дундаас тохирох байгууллагыг олох нь тариаланчдад бэрхшээлтэй байх талтай. AgPal зэрэг вэбд суурилсан төрөл бүрийн хэрэгслүүд Канадын фермерүүд болон хөдөө аж ахуйн бизнесүүдийг ижил төстэй түншүүд болон байгууллагуудын удирддаг хөтөлбөр, үйлчилгээтэй холбодог.

Удирдлага

Канадын хөдөө аж ахуйг холбооны болон мужийн засгийн газар удирддаг. Холбооны засгийн газар банк, худалдаа, худалдаа, дампуурал, төлбөрийн чадваргүй байдлын асуудлыг шийдвэрлэх эрх мэдэлтэй. Мужийн засаг захиргаа нь аймагтаа эд хөрөнгө, газартай холбоотой эрх мэдэлтэй байдаг.

1867 оны Үндсэн хуулийн хуулийн 91-р хэсэг нь улсын хэмжээнд импорт, үйлдвэрлэлийн төлөвлөлтөд онцгой хяналтыг холбооны засгийн газарт олгодог боловч хөдөө аж ахуй нь ерөнхийдөө мужуудаар зохицуулагддаг. Муж бүр байгаль орчны хууль, хортон шавьжтай тэмцэх дүрэм, ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хууль, цагаач ажилчдын дүрэм, хүнсний бүтээгдэхүүний баталгаажуулалтын стандарт, орон нутгийн засаг захиргааны бүсчлэл, газар ашиглалтын хязгаарлалт зэргээр дамжуулан хөдөө аж ахуйн газрыг өмчлөх, ашиглахад хязгаарлалт тавьдаг.

Холбооны засгийн газар нь тариалан тарьсан, мал өсгөсний дараах процессод илүү оролцоотой. Канадын Хүнсний хяналтын агентлаг (CFIA) нь мужаас

гадуур худалдаалагдах бүх бүтээгдэхүүнийг хянаж, зөвшөөрнө. Холбооны засгийн газар мөн хэл, агуулга, гэрчилгээ зэрэг бүтээгдэхүүний сав баглаа боодлыг зохицуулдаг.

НАЙМ.ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу хийсэн энэхүү судалгаагаар хийсэн дүгнэлтүүдийг үндэслэн дараах зөвлөмжийг хууль санаачлагчид хүргүүлж байна.Үүнд:

1. Монгол Улсын мал аж ахуйн салбарт үүссэн нөхцөл байдал, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зохицуулалтын хувилбаруудад хийсэн харьцуулалтын үр дүнд хамгийн оновчтой хувилбар нь шинээр “хуулийн төсөл боловсруулах” гэж тодорхойлж байна.
2. Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааны төрөл, хэлбэрийг тодорхой болгож, тухайлсан төрөл, ангилалд нь чиглэгдсэн төрийн дэмжлэг, зохицуулалтыг тодорхой болгон тогтоосноор мал аж ахуйн үйлдвэрлэл дэх нөөцийг бүрэн ашиглах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, үнэлэмжийн өрсөлдөөний системийг нэмүү өртгийн сүлжээнд хөгжүүлэх, улмаар улс орны эдийн засгийн төрөлжилт, өсөлтийг бий болгох, хөгжүүлэх асуудлыг хуулийн төсөл боловсруулах аргаар шийдвэрлэх нь оновчтой хувилбар гэж дүгнэлээ.
3. Уг асуудлын хүрээнд хуулиар зайлшгүй зохицуулах шаардлагатай доорх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгахыг зөвлөж байна. Үүнд:
 - Хөдөө аж ахуйн салбарын оролцогч талуудыг оновчтой тодорхойлох, улмаар төрөөс үзүүлэх дэмжлэг, урамшууллыг тэдгээрийн зохистой оролцоонд тулгуурлах
 - Хөдөө аж ахуйн салбарын газар зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх замаар замаар салбарт үйл ажиллагаа явуулж буй иргэд, бизнесийнхэнд урт хугацаанд үйл ажиллагаа эрхлэх, улмаар хөрөнгө оруулалт татах, хамтарч ажиллах нөхцөл боломжийг дээшлүүлэх;
 - Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоонд оролцогч талуудад зориулсан даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, татварын хөнгөлөлт урамшууллыг нэвтрүүлэх
 - Төрийн хяналт, удирдлагын тогтолцоог тодорхой болгох
4. Тухайн асуудлын зохицуулалтыг манай улсын болон бусад олон улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулахад шинээр боловсруулах хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон улсын гэрээ конвенцийн үзэл баримтлалд заасан хүний эрх, эдийн засгийн эрх чөлөөг хангах, бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулсан харилцаа, төрийн болон салбарын урт, дунд хугацааны бодлого, зорилттой уялдаж байгаа тул сөрөг үр дагавар авчрахгүй гэж үзэж байна.
5. Судалж байгаа асуудал, зохицуулалтын хувилбарын зардлыг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу нарийвчлан тооцох шаардлагатай.
6. Харин тухайн хуулиар зохицуулах харилцаатай холбогдон бусад хууль тогтоомжид давхардал, хийдэл, зөрчил үүсгэхгүйн тулд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай, Хөдөлмөр

эрхлэлтийг дэмжих тухай, Тариалангийн тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд тус тус холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслүүдийг дагаж боловсруулах шаардлагатай гэж үзлээ.

Ийнхүү энэхүү судалгаанд дурдсан дээрх үндэслэлүүдийг харгалзан үзэж Хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлага байгааг тодорхойлсон тул тус хуулийн төслийг боловсруулж, шат шатанд хэлэлцүүлэн, батлан гаргах хувилбарыг сонгох нь зүйтэй гэж үүгээр зөвлөж байна.

---o0o---

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

I. Судалсан хууль, тогтгомж:

1. Хууль тогтоомжийн тухай хууль
2. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”
3. Газрын тухай хууль
4. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль
5. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
6. Зөрчлийн тухай хууль
7. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд
8. Малын генетик нөөцийн тухай хууль
9. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль
10. Малын тоо толгойн албан татварын тухай хууль
11. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
12. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
13. Тариалангийн тухай хууль
14. Төсвийн тухай хууль
15. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
16. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
17. Федеральный закон о развития сельского хозяйства
18. Livestock law of the PEOPLE'S REPUBLIC OF CHINA

II. Ашигласан судалгаа, мэдээ, мэдээллийн жагсаалт:

1. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1992, №01
2. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2015, №25
3. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2020, №25
4. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2020, №36
5. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2020, №38
6. Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2021, №11
7. Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2022, №09
8. Андреас Женет ба бусад. Бэлчээрийн мал аж ахуй дэлхийн хуурай уур амьсгалтай бүс нутгийн хөгжлийн тулгуур болох нь техник арга зүйн хураангуй, 2016 он
9. Бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан, 2015 ба 2018 он
10. Газрын нэгдмэл сангийн тайлан, БХЯ, ГХГЗЗГ, 2007-2020 он
11. Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн суурь судалгаа, “Эс Ай Си Эй” ХХК, 2021 он
12. Малчдын аж байдлын судалгаа, ХНХЯ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, 2018 он
13. “Мал аж ахуйг дэмжих бодлого” уулзалтын дүгнэлт, зөвлөмж, НҮБ-ийн ХАА-г Хөгжүүлэх Олон Улсын Сан /IFAD/, Фермерүүдийн Форумын консорциум, “Хил хязгааргүй малын эмч нар ба агрономчид” ашгийн бус байгууллага, “Бүсийн Бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид, иргэний нийгмийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага, 2015 он

14. “Мал аж ахуйн хөгжлийн гарц, шийдэл” уулзалт, зөвлөгөөний зөвлөмж, ХХААХҮЯ, Монгол Улсын бэлчээрийн тогтвортой байдал. Малчдын амьжиргаа ба уур амьсгалын өөрчлөлт АХБ, БОНХЯам, 2014 он
15. Мал сүргийн тоог бэлчээрийн даац, нөхцөлтэй уялдуулж тогтоох нь, ҮСХ, 2018 он
16. Монгол Улсын малын генетик нөөцийн үндэсний тайлан, ХХААХҮЯ, НҮБ-ын ХХААБ, 2021 он
17. Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, Үндэсний Статистикийн Хорооны танилцуулга, 2020 он
18. Food and agriculture organization of the united nations. The legal framework for the management of animal genetic resources. 2005. НҮБ-ийн хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын “Амьтны генетик нөөцийн хууль эрх зүйн орчин” тайлан
19. Монгол Улсын ХАА-н салбарын суурь судалгаа. Эцсийн тайлан, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (JICA), 2017 он
20. Монгол Улсын хөгжлийн бодлогын тогтвортой байдал, залгамж чанар, уялдаанд хийсэн шинжилгээ (Тайлан I), ҮХГ, 2018
21. ХАА-н салбарын статистик танилцуулга, ҮСХ, 2000-2024 он
22. <https://www.1212.mn/>
23. <https://www.fao.org/>
24. <https://www.wto.org/>
25. <https://www.eeas.europa.eu/>
26. Бусад эх сурвалж

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН
ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2025**

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	3
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ	3
ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ	4
ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ	10
ДӨРӨВ. ҮР ДҮН, ЗӨВЛӨМЖ	30

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

“Хөдөө аж ахуйн тухай хууль”-ийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1-т заасан хуулийн төслийн анхдагч хуулийн төслийн төрлөөр боловсруулагдсан бөгөөд мөн хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах зорилгоор хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг хийж гүйцэтгэлээ.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”¹-д заасны дагуу дараах үе шаттайгаар бэлтгэсэн болно.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгийг тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Энэхүү үр нөлөөг үнэлэх судалгааны хүрээг “Хөдөө аж ахуйн тухай” хуулийн 2 болон 3 дугаар бүлгээр тогтоов.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

Үнэлгээний судалгааг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудлуудтай уялдуулан, аргачлалд заасны дагуу дараах шалгуур үзүүлэлтүүдийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Ойлгомжтой байдал
3. Хүлээн зөвшөөрөх байдал
4. Харилцан уялдаа

Эдгээр шалгуур үзүүлэлтийг тухайлан сонгох болсон үндэслэл нь уг хуулийн төслийн зорилт болон зохицуулах харилцааны онцлогтой холбоотой. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хүний нөөц, тэдгээрийн тогтвортой байдлыг хангах, хөгжлийг дэмжих, үйл ажиллагааг хэрэгжүүлэх тогтолцоо, эрх хэмжээ, чиг үүрэг, бүртгэл, хяналттай холбогдох харилцааг харилцааг зохицуулахад хуулийн төслийн үндсэн зорилго чиглэсэн байна. Иймд, Монгол Улсын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртгийн сүлжээтэй холбоотой эрх зүйн шинэлэг зохицуулалтыг тусгасан байдалд болон хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийн төлөвлөлт, тогтвортой хөдөө аж ахуй, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаанд оролцогч төрийн болон бусад байгууллагын эрх зүйн статус, хүний нөөцийг бэлтгэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжихтэй холбоотой харилцааны эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх нь зүйтэй гэсэн үндэслэлээр эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

¹Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

“Зорилгод хүрэх байдал” бүхий шалгуур үзүүлэлтийн хүрээнд “Хөдөө аж ахуйн тухай хууль”-ийн төсөл (Цаашид “Хуулийн төсөл” гэх)-ийн холбогдох зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлалд туссан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн хуулийн төсөлд тусгасан зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой эсэхэд үнэлгээ хийхийг зорьсон.

Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан болно.

“Практикт хэрэгжих боломж” бүхий шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд тусгасан зохицуулалтууд нь практикт хэрэгжих боломжийг шалгахаар сонгож авна.

“Ойлгомжтой байдал” бүхий шалгуур үзүүлэлтийг дараах шалтгаанаар сонгов. Тус хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл тул хуулийг хэрэглэх; хэрэгжүүлэх субъектэд ойлгомжтой, салаа утгагүй байх, хуулийн төсөлд тусгасан зүйл, заалтууд нь найруулгын хувьд ойлгомжтой, логик дараалалтай боловсруулсан эсэхийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 35, 36 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах байдлаар хуулийн төслийг бүхэлд үнэлнэ.

“Хүлээн зөвшөөрөх байдал” бүхий шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүний оролцогч талууд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгана. Өөрөөр хэлбэл, тухайн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэхийг шалгана.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх, тухайн чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг шалгасан. Энэ хүрээнд тус хуулийн төсөл нь бүхэлдээ Үндсэн хууль болон холбогдох бусад хуулийн зохицуулалтад нийцэж байгаа эсэхийг Аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийнэ.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын гуравдугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийн тодорхой зохицуулалтыг сонгон авч үр нөлөөг нь үнэлнэ. Тухайн зохицуулалтыг сонгохдоо мөн зүйлийн 3.2-т заасны дагуу “гол ач холбогдолтой зохицуулалтыг олж тогтоох нь зүйтэй бөгөөд тухайн зохицуулалт бодитой судалгаа хийж болохуйц байх шаардлагатай” гэснийг урьдчилсан нөхцөл болголоо.

Иймд хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхойлсон хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зохицуулалт нь хуулийн төслөөр тавьсан зорилгод хүрэхэд нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс Хуулийн төслийн хэрэгцээ,

шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан², хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөлтэй танилцаж үнэлгээ хийв

“Хөдөө аж ахуйн тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан”-гийн үр дүнгээр Тариалангийн тухай, Таримал ургамлын үр сортын тухай, Үрийн тариалангийн даатгалын тухай, Малын генетик нөөцийн тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Малын индексжүүлсэн даатгалын тухай, Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай зэрэг мал аж ахуй, тариалангийн салбарын хуульд тухайн чиглэлийн үйл ажиллагаанд тариаланч, малчны хүлээх эрх, үүргийг тодорхойлсон байдаг боловч хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нэгдмэл эрх зүйн байдал, уг үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх, хамгаалах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн хөгжил, бүтээмж, хариуцлагатай байдал, хамтын санаачилга, өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалтыг дэмжин хөгжүүлэх боломж нөхцөлөөр хангах талаар зохицуулалт нэгдмэл зохицуулалт байдаггүй. Иймд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, түүний дотох мал аж ахуйн үйлдвэрлэл, түүний хөгжлийг дэмжихтэй холбоотой асуудлуудыг зохицуулахад хууль тогтоомж батлан гаргах хувилбар нь хамгийн сайн хувилбар мөн гэж дүгнэсэн.

Иймд Монгол Улс нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нийтлэг асуудлыг нэгдмэл байдлаар бүхэлд нь хамарсан эрх зүйн орчныг бий болгохоор Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг дараахь асуудалтай холбогдсон харилцааг зохицуулахаар шинээр боловсруулжээ. Үүнд:

- хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, түүний төрөл тодорхойлж, хөдөө аж ахуйн бүс нутгийг тогтоох, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний өртгийн сүлжээ;
- хөдөө аж ахуй тогтвортой үйлдвэрлэл, хүний нөөц, хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлд нөлөөлөх эрсдэлийг үнэлэх, түүний удирдлага, зохицуулалт, үйлдвэрлэл эрхлэгчийн эрх, үүрэг;
- хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжлэг, түүний төрөл;
- хөдөө аж ахуйн салбар дахь төрийн удирдлага, зохицуулалт, хөдөө аж ахуйн салбарын бүртгэл, мэдээллийн сан.

Тиймээс энэ хэсэгт дээрх шалгуурын дагуу “Хөдөө аж ахуйн тухай хууль”-ийн төслийн дор дурдсан агуулга бүхий зохицуулалтыг тус тус сонгон авч үнэлнэ. Үүнд:

- Хоёрдугаар бүлгийн түүхий эд, бүтээгдэхүүнийг хүлээн авах төв, төвлөрсөн цэг, төвлөрсөн агуулах (цаашид “төв, цэг, агуулах” гэх)-тай холбогдсон 8 дугаар зүйлийн 8.6-8.9 дүгээр хэсэг;
- Гуравдугаар бүлгийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дунд хугацааны бодлого, аймаг, нийслэл, сум, дүүрэг дунд хугацааны төлөвлөгөөтэй холбоотой 9 дүгээр зүйл, хүний нөөцийн асуудлыг тусгасан 10 дугаар зүйл, хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлд нөлөөлөх эрсдэлийг үнэлэх, түүний удирдлага, зохицуулалт бүхий 11 дүгээр зүйл,
- Дөрөвдүгээр бүлгийн хөдөө аж ахуйн хөгжлийн дэмжлэг, түүний төрөлтэй холбоотой 13 дугаар зүйл.

Хүснэгт 1. “Хөдөө аж ахуйн тухай хууль”-ийн төслөөс түүний үр нөлөөг үнэлэхээр сонгон авсан зохицуулалт тусгагдсан байдал.

№	Зүйлийн дугаар, нэр	Зохицуулалт
---	---------------------	-------------

² Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан, 2022 он

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ӨРТГИЙН СҮЛЖЭЭ		
1	7 дугаар зүйл. Хөдөө аж ахуйн бүс нутаг тогтоох	7.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу газар зүйн байршил, экологийн онцлог, хөдөө аж ахуйн үржил шим, дэд бүтцийн хөгжил, боловсруулах үйлдвэрлэлийн байгуул уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн даац, усан хангамж, мал, ахуйн ургамлын эрүүл мэндийн төлөв байдал, зах зээлтэй уялдуулан бүс тогтоон хөгжүүлж болно. 7.2.Аймаг, нийслэл болон сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нутаг дэвсгэртээ хөдөө аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх бүс нутаг заагийг тогтооно. 7.3.Хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан хөдөө аж ахуйн төрөлжсөн үйлдвэрлэлийн бүсийн хилийн заагийг тухайн бүс нутгийг хөгжүүлэх байгаа аймгуудын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санхүүг үндэслэн Засгийн газар тогтооно. 7.4.Тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагууд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагууд тухай хуульд зааснаас гадна хөдөө аж ахуйг бүс нутаг тогтоон, төрөлжүүлэн хөгжүүлэх талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ: 7.4.1.мал, амьтан, таримал ургамлын эрүүл мэндийн төлөв байдал, экосистемийн зээлтэй орон зайг бий болгох нөхцөлийг бүрдүүлэх, хамт уялдааг хангах; 7.4.2.дэд бүтцийг сайжруулах; 7.4.3.хөдөө аж ахуйн эрчимжсэн, өрхийн арилжааны аж ахуйн эрхлэгчийн хорших, хамтран ажиллахыг дэмжих; 7.4.4.өрхийн арилжааны аж ахуйг эрсдэлд суурь төлөвлөлттэй болгох; 7.4.5.өрхийн арилжааны аж ахуйн үйлдвэрлэсэн түүхийн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтыг захиалгат, зорилт зээлтэй холбох зохицуулалт хийх, зах зээлийн тогтолцоонд нийцүүлэн шинэчлэн өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; 7.4.6.хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчийн эдийн засагч чадамж, бүтээмж, үр ашгийг сайжруулах, өртгийн сүлжээг хөгжүүлэн дэмжлэг үзүүлэх. 7.5.Тариалангийн бүс нутаг, үүлдэр, омгийн малыг үржүүлэн байршил, мал, амьтны эрүүл мэндийн бүс тогтоохтой холбогдсон харилцаа салбарын холбогдох хуулиар зохицуулна.
1	8 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн гаралтай	8.6.Түүхий эд, бүтээгдэхүүний анхдагч шинж чанар, технологийн онцлогоос хамааран хүлээн авах төв, төвлөрсөн цэг, төвлөрсөн агуулах (цаашид “төв, цэг, агуулах” гэх), мал бордох аж ахуй, бөөний

	түүхий эд, бүтээгдэхүүний нэмэгдсэн өртгийн сүлжээ	худалдааны төвийн байршлыг сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн тогтооно.
		8.7.Энэ хуулийн 8.6-д заасан төв, цэг, агуулах, мал бордох аж ахуй, бөөний худалдааны үйл ажиллагааг хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч, эсхүл энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг хариуцан гүйцэтгэх ба боловсруулах үйлдвэрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гэрээний үндсэн дээр гүйцэтгэж болно.
		8.8.Энэ хуулийн 8.6-д заасан төв, цэг, агуулах, бөөний худалдааны үйл ажиллагааг сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасагт бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээд гэрээний үндсэн дээр хэрэгжүүлнэ.
		8.9.Энэ хуулийн 8.8-д заасан иргэн, хуулийн этгээдийг бүртгэх, гэрээ байгуулах журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ		
3	9 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэл	9.1.Тогтвортой хөдөө аж ахуйн хөгжлийн зорилтыг хангах зорилгоор улсын хэмжээнд дунд хугацааны бодлого, аймаг, нийслэл, сум, дүүрэг дунд хугацааны төлөвлөгөөтэй байна.
		9.2.Энэ хуулийн 9.1-д заасан бодлого, төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулж, батлуулан хэрэгжүүлнэ.
		9.3.Тогтвортой хөдөө аж ахуйн бодлого, төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгана:
		9.3.1.тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх зорилго, зорилтыг улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг бүр өөрийн онцлогт нийцүүлэн тодорхойлох;
		9.3.2.хөдөө аж ахуйг төрөлжүүлэх, бүс нутаг тогтоох болон бэлчээр хамгаалах төлөвлөгөө, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах, нийлүүлэх өртгийн сүлжээ, зах зээл, бөөний худалдааны сүлжээ, хөдөө аж ахуйн кластер хөгжүүлэх зэрэг асуудлыг өөрийн нутаг дэвсгэрийн онцлог, малын тэжээлийн хүртээмж, аж ахуй эрхлэх боломж, ажиллах хүчний хүрэлцээ, хүн амын хүнсний хангамж, эрэлт, хөрөнгө оруулалтын боломж зэрэгтэй уялдуулан тодорхойлох;
		9.3.3.тухайн нутаг дэвсгэрт өсгөн үржүүлж байгаа үүлдэр, омгийн малын нэгжээс авах ашиг шим болон нэгж талбайгаас хураан авч байгаа таримал бүрийн ургацыг сүүлийн 3 жилийн дунджаас нэмэгдүүлэх боломж, хүрэх түвшинг тооцох;

		9.4.Аймаг, сумын дунд хугацааны төлөвлөгөөнд энэ хуулийн 10.3-т заасан зорилтыг өөрийн онцлогт тохируулан сонгон авч тусгана.
		9.5.Аймаг, сумын тогтвортой хөдөө аж ахуйн хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн шатны Засаг дарга хариуцан зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу тайлагнана.
4	10 дугаар зүйл. Хөдөө аж ахуйн салбарын Хүний нөөц	10.1.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь салбарын хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.
		10.2.Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн зорилтыг шийдвэрлэхэд шаардагдах мэргэшсэн хүний нөөцийн хэрэгцээг мэргэжил, мэргэшлийн түвшнээр урт, дунд хугацаанд тодорхойлж, хэрэгцээг хангах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлнэ.
		10.3.Тогтвортой хөдөө аж ахуйн зорилтыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой мэргэжлээр их, дээд сургууль, мэргэжлийн боловсролын байгууллагад шинээр анги нээх, гадаад оронд сургаж бэлтгэх ажлыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулна.
		10.4.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь албан боловсрол эзэмшсэн хөдөө аж ахуйн ажилтан, мэргэжилтнийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран 5 жил тутам мэргэжил дээшлүүлэх сургалтад системтэйгээр хамруулах ба мэргэжлийн ур чадварын түвшнээр үнэлж, мэргэшлийн зэрэг олгоно.
		10.5.Энэ хуулийн 10.4-т заасан хөдөө аж ахуйн салбарын ажилтан, мэргэжилтний мэргэжлийн ур чадварын түвшинг үнэлэх, мэргэшлийн зэрэг олгох асуудлыг тухайн салбарын нарийвчилсан хуулиар зохицуулна.
3	11 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн тогтвортой нөлөөлөх эрсдэл, түүний удирдлага, зогсоол	11.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хангах, хөгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах, удирдах явцад учирч болзошгүй хүчин зүйлсийн нөлөөллийн эрсдэлийг тогтооно.
		11.2.Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлд учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээг ердийн нөхцөлд 5 жил тутам, аль нэг эрсдэлт нөхцөл байдал үүссэн болон үүсэх магадлал өндөрссөн үед Засгийн газрын шийдвэрээр тухай бүр хийнэ.
		11.3.Энэ хуулийн 11.2-т заасан эрсдэлийн үнэлгээг эрсдэл үүсгэгч аюул болон хүчин зүйлсийн чиглэлээр мэргэшсэн, хараат бус

		судлаач, шинжээчдээс бүрдсэн эрсдэлийн үнэлгээний баг гүйцэтгэнэ.
		11.4.Энэ хуулийн 11.3-т заасан эрсдэлийн үнэлгээний багийг Засгийн газраас 5 жилийн хугацаатай байгуулж ажиллуулна. Үнэлгээний багийн ажиллах журмыг Засгийн газар батална.
		11.5.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд нөлөөлөх эрсдэлийг тогтоох, үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалыг хөдөө аж ахуйн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран батална.
		11.6.Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлд учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээ хийх зардлыг Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлнэ.
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙН ДЭМЖЛЭГ		
4	13 дугаар зүйл. хөдөө аж ахуйн хөгжлийн дэмжлэг, түүний үндэсний үйлдвэрлэлд нийлүүлсэн байх;	13.1.Хөдөө аж ахуйн дэмжлэг нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх байгальд ээлтэй, үр ашигтай үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх, орлоо нэмэгдүүлэх талаарх сонирхол, хариуцлагыг нь дээшлүүлэхэд чиглэсэн байна.
		13.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр төсвөөс дэмжлэг, урамшуулал нь дор дурдсан шалгуурыг хангасан байна: 13.2.1.уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чиглэгдсэн дэвшил технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байх; 13.2.2.бэлчээрийн болон тариалангийн газрын хөрс, үржил цогцол хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх арга хэмжээнд хувийн зүгээс хамруулалт хийсэн байх; 13.2.3.бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийн бүтээмжээ дээшлүүлсэн байх; 13.2.4.стандартын шаардлага хангасан түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэлд үндэсний үйлдвэрлэлд нийлүүлсэн байх; 13.2.5.малын чанар болон эдийн засгийн эргэлтийг сайжруулах зорилго бүхий бэлчээрийн даацад малын тоог нийцүүлсэн байх; 13.2.6.бэлтгэн нийлүүлэлтийн хоршоогоор дамжуулан арьс шир, ноос, ноолуур, сүү зэрэг түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлсэн байх.
		13.3.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд үзүүлэх урамшуулал олгохдоо дараах тэргүүлэх чиглэлийг баримтлана: 13.3.1.бэлчээрийг хамгаалан сайжруулж, даацад нь малын тоог нийцүүлэх; 13.3.2.боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн сүүний хэмжээг нэмэгдүүлэх; 13.3.3.мах, сүүний эрчимжсэн аж ахуйн өндөр ашиг шимт мал, тэжээл хангамжийг сайжруулах; 13.3.4.хоршооны зохион байгуулалтад орж мал аж ахуйн гаралтай түүхий бүтээгдэхүүний бэлтгэл, анхан шатны боловсруулалт хийх жижиглэлийг үйлдвэрийг хөгжүүлэх;

		13.3.5.хоршин ажиллаж буй жижиг тариалан эрхлэгчдэд хорш дамжуулан үйлдвэрлэлийн орц, техник, тоног төхөөрөмжийн ханга сайжруулах; 13.3.6.дэвшилтэт технологи бүхий нарийн ногооны хүлэмжийн аж технологийн стандартын шаардлага хангасан зоорь, агуулахын аж хөгжүүлэх; 13.3.7.хөрсний үржил, шимийг сайжруулан хамгаалахад чиглэсэн б үрийн хангамж, ойн зурвас байгуулах.
		13.4.Хөрөнгө оруулалтын багтаамж ихтэй, үйлдвэрлэгчийн зүгээс дан санхүүжилт хийхэд хүндрэлтэй хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэ дараах чиглэлийн төсөл, хөтөлбөрийг банкны хөнгөлөлттэй, урт хуга зээлээр дэмжинэ: 13.4.1.малын үүлдэр, угсааг сайжруулах үүднээс өндөр ашиг шим худалдан авах; 13.4.1.эрчимжсэн мал аж ахуйн барилга байгууламж барих; 13.4.2.таримал тэжээл үйлдвэрлэл, бүсийн, аймаг дундын, аймги тэжээлийн нөөцийн сан бүхий бөөний худалдааны төв байгуулах; 13.4.3.эрчимжсэн сүүний аж ахуйн тоног төхөөрөмж худалдан авах; 13.4.4.усалгаатай газар тариалангийн барилга байгууламж барих; 13.4.5.тариалангийн талбайн ойн зурвас, хашаа барих; 13.4.6.таримал жимс, жимсгэнэ, цай, эмийн ургамлын үйлдвэрлэл эр 13.4.7.өндөр бүтээмжтэй, орчин үеийн ухаалаг технологи бүхий т комбайн, тоног төхөөрөмж худалдан авах; 13.4.8.эрчим хүчний хэмнэлттэй ухаалаг технологи, тохируулга хүнсний ногооны зоорь, агуулахын аж ахуй, хүлэмж барих; 13.4.9.ногоон хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх; 13.4.10.дотоодод үйлдвэрлэсэн бренд бүтээгдэхүүнийг түгээн дэлгэр сурталчлах арга хэмжээ авах; 13.4.10.хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний тээвэр, ложис хөгжүүлэх.

ДӨРӨВ. УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
----------	-----------------------------	-------------------------------	--------------------------------

1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 8, 10,11,12,13, 18, 19 дүгээр зүйл	Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын судалгаанд дэвшүүлсэн асуудлыг шийдвэрлэж чадах эсэхэд дүн шинжилгээ хийх, сонгосон зохицуулалт, арга хэмжээ зорилгод хүрэх боломжтой эсэхийг тодорхойлох.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 8, 10,11,12,13, 18, 19 дүгээр зүйл	Хуулийг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц) эсэхийг судалж тодорхойлох.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн 8, 10,11,12,13, 18, 19 дүгээр зүйл	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах
4	Хүлээн зөвшөөрөх байдал	Хуулийн төслийн 8, 10,11,12,13, 18, 19 дүгээр зүйл	Тус хуулийн төсөл батлагдсантай холбоотойгоор эрх ашиг, сонирхол нь хөндөгдөх этгээдүүдийн байр суурийг тодорхойлох.
5	Харилцан уялдаа	Хуулийн төслийн 8, 10,11,12,13, 18, 19 дүгээр зүйл	Тус хуулийн төсөл нь Малын генетик нөөцийн тухай хууль, Малчны тухай хууль, Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль, Малын тоо толгойн албан татварын тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль, Тариалангийн тухай хууль, Таримал ургамлын үр, сортын тухай хууль, Үрийн тариалангийн даатгалын тухай хууль, Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Органик бүтээгдэхүүний тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй эсэхийг үнэлэх.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

1.“ЗОРИЛГОД ХҮРЭХ БАЙДАЛ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ:

Энэ хэсэгт дээрх сонгож авсан зохицуулалтууд нь хуулийн төслийн боловсруулагдах үндэслэл, хэрэгцээ шаардлагад тусгагдсан асуудлыг шийдвэрлэж чадах эсэхийг үнэлэх байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Нэг. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг бүсчлэн төрөлжүүлэх хөгжүүлэх талаар:

Хэрэгцээ, шаардлага, зорилт	Нийцэж буй эсэх
Малын генетик нөөцийн хуулийн 17.5.1-д “17.5.1.бэлчээ уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуйн бүсчлэн хөгжүүлэх талаар боловсруулах” гэж заасан ч тус хэрэгжүүлэх зохицуулалт тодорхой байгаа. Тариалангийн тухай хуулийн дугаар зүйлийн 17.1 дэх “Тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, төрөлжүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлэх зорилгоор тариалангийн бүс нутгийн хуульд заасны дагуу тогтоож болно” мөн зүйлийн 17.5 дахь “Тариалангийн бүс нутагт суурин хагас суурин эрчимжсэн мал аж ахуйн тусгайлсан бэлчээрт эрхэлнэ” гэж заасан. “Тариалангийн зарим бүс нутагт тогтоох тухай” Монгол Улсын Засаг захиргаа 2018 оны 131 дүгээр тогтоол 2.1-т “орон нутгийн хөгжлийн бодлого, зорилтыг ямар байгуулах, шаардагдах хэрэгсэл, орнуудыг хэрхэн шийдвэрлэх, нутгийн удирдлага, зохицуулалтыг хэрхэн шийдвэрлэх, хуульчлагдаагүйгээс уг бүс нутаг дээр л байгуулагдснаас өөр бодит хэрэг болоогүй байна.	7 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн бүс нутаг тогтоох 7.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг Монгол Улсын бүс нутгийн үзэл баримтлалын дагуу газар зүйн байршил, эколог, хөрсний үржил шим, дэд бүтцийн хөгжил, боловсруулалтын байршил, уур амьсгалын өөрчлөлт, бэлчээ, усан хангамж, мал, амьтан, ургамлын эрүүл мэндийн байдал, зах зээлтэй уялдуулан бүс нутаг тогтоон хөгжүүлж болно. 7.2.Аймаг, нийслэл болон сум, дүүргийн иргэд Төлөөлөгчдийн Хурал нутаг дэвсгэртээ хөдөө аж ахуйг төрөлжүүлэх бүс нутгийн заагийг тогтооно. 7.3.Хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан хөдөө аж ахуйн төрөлжсөн үйлдвэрлэлийн бүсийн хилийн заагийг тухайн нутгийг хамарч байгаа аймгуудын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэр, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргаа байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно. 7.4.Тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нийслэл, удирдлага нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хуульд зааснаас гадна хөдөө аж ахуйн бүс нутаг тогтоон, төрөлжүүлэн хөгжүүлэх талаар дараах арга хэрэгжүүлнэ: 7.4.1.мал, амьтан, таримал ургамлын эрүүл мэндийн экосистемийн зэлтэй орон зайг бий болгох нөхцөлийг бүрдүүлж хамгаалах, уялдааг хангах; 7.4.2.дэд бүтцийг сайжруулах; 7.4.3.хөдөө аж ахуйн эрчимжсэн, өрхийн арилжааны аж ахуй эрхлэгчийн хорших, хамтран ажиллахыг дэмжих; 7.4.4.өрхийн арилжааны аж ахуйг эрсдэлд суурь төлөвлөлттэй болгох; 7.4.5.өрхийн арилжааны аж ахуйн үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, борлуулалт, захиалгат, зорилтот зах зээлтэй холбох зохицуулалт хийх зээлийн тогтолцоонд нийцүүлэн шинэчлэн өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; 7.4.6.хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчийн засгийн чадамж, бүтээмж, үр ашгийг сайжруулах, өртгийн сөрөг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

	7.5.Тариалангийн бүс нутаг, үүлдэр, омгийн малыг үржүүлж, бүс, байршил, мал, амьтны эрүүл мэндийн бүс тогтмол холбогдсон харилцааг салбарын холбогдох хуулиар зохицуул
--	--

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын зорилт 8.3-т “Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ” гэж, тус “Тогтвортой хөдөө аж ахуй” зорилтын I үе шат (2021-2030): Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжих үеийн 2-т “Нүүдлийн уламжлалт өв соёлыг хадгалсан, экологид ээлтэй, органик ма аж ахуйг тогтвортой эрхлэх, хөдөө аж ахуйн эрчимжсэн үйлдвэрлэлийг төрөлжүүлж, кластер, логистик, санхүүгийн түрээсийн үйлчилгээг хөгжүүлж, төлөвшүүлнэ” гэж тус тус заасан.

Малын генетик нөөцийн тухай³ хуулийн 17.5.1-д “17.5.1.Бэлчээрийн уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх талаар санал боловсруулах” гэж заасан ч түүнийг хэрэгжүүлэх зохицуулалт тодорхой бус байгаа.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.3 дахь зорилт “Бүсийн төрөлжсөн хөгжил” бүлэгт Монгол Улсын нутаг дэвсгэрийг 6 бүсээр хувааж хэрэгжүүлэх зорилтод хөдөө аж ахуйн хөгжлийг бүсчилэн тогтоосон, тус хөтөлбөрийн 3.3.4 дэх зорилт “Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хэсэгт хөдөө аж ахуйн хөгжлийн чиглэлээр шинэчлэлийн 35 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тус тус заасан.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлээр Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу газар зүйн байршил, экологийн онцлог, хөрсний үржил шим, дэд бүтцийн хөгжил, боловсруулах үйлдвэрлэлийн байршил, уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн даац, усан хангамж, мал, амьтан, ургамлын эрүүл мэндийн төлөв байдал, зах зээлтэй уялдуулан бүс нутаг тогтоон хөгжүүлэхээр заасан нь дээр дурдсан Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг болон холбогдох хуульд заасныг хэрэгжүүлэх харилцааг тодорхой болгосон байна. Түүнчлэн бүс нутгийн заагийг тогтоох албан тушаалтан, төрийн байгууллагыг хуульчилж, тухайн бүс нутаг харъяалагдах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь хөдөө аж ахуйг бүс нутаг тогтоон, төрөлжүүлэн хөгжүүлэх талаар хэрэгжүүлэх арга хэмжээг тодоройлон тусгасан нь хуулийг хэрэгжүүлэх хүрээ хязгаарыг тогтоосон. Ингэхдээ Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал⁴ын дагуу хөдөө аж ахуйн бүс нутгийг тогтоохоор байгаа нь тодорхой хүрээг тогтоосон зохицуулалт болжээ. Нөгөө талаас хөдөө аж ахуйн бүс нутгийг тухайн нутаг дэвсгэрийн газар зүйн байршил, экологийн онцлог, хөрсний үржил шим, дэд бүтцийн хөгжил, боловсруулах үйлдвэрлэлийн байршил, уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн даац, усан хангамж, мал, амьтан, ургамлын эрүүл мэндийн төлөв байдал, зах зээлтэй уялдуулан тогтоох хөгжүүлж болно гэж хуульчилах нь эдгээр нөхцөл байдлыг судалж шинжилсний үндсэн дээр тогтоох гуулгыг багтаажээ. Өөрөөр хэлбэл, дурдсан нөхцөл байдал бүрдээгүй бол заавал хөдөө аж ахуйн бүс нутаг тогтоохгүй гэсэн зарчмыг баримталсан байна. Иймээс хөдөө аж ахуйн бүс нутаг тогтоох хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг хамарсан энэхүү зохицуулалт нь Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны

³ Малын генетик нөөцийн тухай хууль, 2012 он, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=13051>

⁴ Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, УИХ-ын 2024 оны 64-р тогтоол, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140840374051&showType=1>

бодлогын зорилт, холбогдох хууль тогтоомжид заасныг хэрэгжүүлэх болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд тулгамдаад байгаа асуудлыг оновчтой зохицуулах талаарх хуулийн төслийн үзэл баримтлалд туссан хэрэгцээ, шаардлага, зорилгод нийцсэн гэж дүгнэв.

Гэхдээ хөдөө аж ахуйн бүс нутгийг тогтоох албан тушаалтан байгууллагыг тусгайлан зааж оруулбал эрх зүйн орчин бүрэн бий болохоор харагдаж байна.

Хоёр.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэмэгдсэн өртгийн сүлжээний талаар:

Хэрэгцээ, шаардлага , зорилго	Нийцэж байгаа эсэх
““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааг хөгжлийн бодлого”-ын “Тогтвортой хөдөө аж ахуйн зорилтын I үе шат (2021-2030): Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжих үе шат “Нүүдлийн уламжлалт өв соёлыг хадгалсан, эхлээд ээлтэй, органик ма аж ахуйг тогтвортой эрхлэх, хөдөө аж ахуйн эрчимжсэн үйлдвэрлэлийг төрөлжүүлж, калорийн, логистик, санхүүгийн түрээсийн үйлчилгээг хөгжүүлж, төлөвшүүлнэ” гэж тус тус заасан. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоол 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 4.2.2-т “хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ” гэж, 8.3-т “хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ” гэж, 8.3.1-д “гол нэрийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангана.” гэж, 8.3.4-т “малын чанар, ашиг цогцолыг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын чанарыг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлж, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжих” гэж, 8.3.7-д “хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тээвэр, борлуулалтын ложистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарыг хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтоол бүрдүүлнэ.” гэж, 8.3.13-т “хөдөө орон нутагт жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр бий болгох, үүлдэр, угсааг сайжруулах, малын гаралтай түүхийн үйлдвэрлэгчдийг дэмжих “Шинэ хөдөө” хөтөлбөр хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн Замбур 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.1.1-д “Бүсийн төрөлжсөн хөгжил” бүлэгт Монгол Улсын нутаг дэвсгэрийг 6 бүсээр хувааж хэрэгжүүлэх зорилгоор хөдөө аж ахуйн хөгжлийг бүсчилэн тогтоосон. Хөдөө аж ахуйгаас зах зээлд нийлүүлж байгаа түүхийн бүтээгдэхүүнд чанараас хамаарсан үнийн тогтвортой байхгүй, төрөөс олгож байгаа мөнгөн урамшуулал, шалгуурт чанарын голлох шаардлага тавьдаггүй үйлдвэрлэл эрхлэгчид бэлтгэн нийлүүлж байгаа	8 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий бүтээгдэхүүний нэмэгдсэн өртгийн сүлжээ 8.6.Түүхий эд, бүтээгдэхүүний анхдагч шинж чанар, технологийн онцлогоос хамааран хүлээн авах төв, төв, цэг, төвлөрсөн агуулах (цаашид “төв, цэг, агуулах” гэж хэлнэ) бордох аж ахуй, бөөний худалдааны төвийн байршлыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн тогтооно. 8.7.Энэ хуулийн 8.6-д заасан төв, цэг, агуулах бордох аж ахуй, бөөний худалдааны үйл ажиллагааг хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч, эсхүл энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд бүхэлд нь, эсхүл тодорхой хэсэг хариуцан гүйцэтгэх ба боловсруулах үйлдвэрлэл итгэмжлэгдсэн төлөөлөгч гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ. 8.8.Энэ хуулийн 8.6-д заасан төв, цэг, агуулах, бөөний худалдааны үйл ажиллагааг сум, дүүргийн хөдөө аж ахуй тасагт бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээд гэрээний үндсэн дээр хэрэгжүүлнэ. 8.9.Энэ хуулийн 8.8-д заасан иргэн, хуулийн этгээд бүртгэх, гэрээ байгуулах журмыг хөдөө аж ахуйн ажиллагаа эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

эд, бүтээгдэхүүний чанарт төдийлөн анхаарахгүй Мөн сум бүрт хөдөө аж ахуйн гаралтай түүхий хүлээн авах, чанарын ангилалт, тордолт хийх тогт бүрдүүлж чадахгүй байгаагийн улмаас түүхий үнэгүйдэл үүсэхэд нөлөөлж байна.	
--	--

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртгийн сүлжээний бэлтгэл нийлүүлэлтийн шатанд түүхий эд, бүтээгдэхүүний анхдагч шинж чанарыг алдагдуулахгүй байх, технологийн шаардлагыг хангахад зайлшгүй шаардлагатай түүхий эд, бүтээгдэхүүн хүлээн авах төв, төвлөрсөн цэг, төвлөрсөн агуулах (цаашид “төв, цэг, агуулах” гэх), мал бордох аж ахуй, бөөний худалдааны төвийн байршлыг сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн тогтоохоор хуульчихаар байна. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн шатанд чанар, технологийн онцлогыг алдагдуулахгүй байх нь тухай бүтээгдэхүүний дараагийн шатны үйлдвэрлэл буюу өртөг шингэсэн бүтээгдэхүүнд үйлдвэрлэлд чухал ач холбогдолтой. Ингэснээр бүтээгдэхүүний үнэ цэнэ нэмэгдэж, өрсөлдөх чадвар сайжрах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн гадаад зах зээлд гарах боломж бий болно. Тогтвортой хөдөө аж ахуйн талаар “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого баримт бичгийн 8.3-д тусгагдсан “Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ” гэсэн зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүнг дараах байдлаар бодлого болгосон. Үүнд: I үе шат (2021-2030): Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжих үе, II үе шат (2031-2040): Хөдөө аж ахуйг нөөцийг бүрэн ашиглах, тогтвортой үйлдвэрлэл, үр ашиг, бүтээмжээр өрсөлдөх үе тус тус багтсан. УИХ-ын 2023 оны 36 дугаар тогтоолоор 1/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлийн в/-д “... экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэхэрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж, 2022 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосонтой зарчмын хувьд нийцэж байна. УИХ-ын 36 дугаар тогтоолоор ирэх таван жилийн бодлого, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө, санхүүжилтыг хамтатган батлуулсан. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 1.7 их наяд төгрөг шаардлагатай. Түүнчлэн “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”⁵-ыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 4 жилийн хугацаатай өрнүүлэхээр баталжээ. “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд жил бүр 120 тэрбум төгрөг шаардлагатай⁶ аж.

2024 оны байдлаар ХАА-н салбар нийт ДНБ-ий ердөө 10%-ийг эзэлсэн бөгөөд эдийн засаг 7% өсөж байхад тус салбар 8.9% унасан байдаг. Түүнчлэн тус салбарын 2023 оны гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ маш бага буюу \$1.2 сая. Нэмээд ХАА-н салбарын экспортод эзлэх хэмжээ энэ сарын байдлаар 7% орчим байгаагийн 95% нь ноолуур аж. Ер нь бол манайх ноолуурынхаа 25%-ийг дотооддоо гүн боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн болгодог бол үлдсэн 75%-ийг нь угааж экспортолдог. Уг нь бол шууд түүхийгээр нь угааж гаргахаас илүүтэй боловсруулалтыг дэмжиж, самнасан ноолуураа ээрэх, эцсийн бүтээгдэхүүн болговол \$1.5 тэрбумыг олох боломжтой. Тиймээс Монгол Улсын Ерөнхийлөгчйн санаачилгээр Цагаан алт хөтөлбөрийг 2025 оноос эхлэн 3 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр болсон ба уг үндэсний хөтөлбөрийн хүрээнд нийт ₮2.2 их наядын санхүүжилтийг бүрдүүлж, 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэх аж. Энэ хөтөлбөрийн зорилго нь хөнгөн үйлдвэрийн салбарыг дэмжих. Тэгвэл эдгээр хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд анхан шатанд түүхий эдийн чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан байхыг заасан зохицуулалтууд нь хөдөө

⁶ <https://www.mnb.mn/i/326665>

аж ахуйн нэмэгдсэн өртгийн сүлжээг цогцоор нь зах зээлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэхэд ач холбогдол бүхий байгаа ба хуулийн төслийн зорилгод нийсэн байна.

Гурав. Тогтвортой хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн талаар:

Хэрэгцээ, шаардлага, зорилго	Нийцсэн эсэх
Уур амьсгалын өөрчлөлт нөлөөгөөр манай улсад агаарын нэмэгдэн хур тундасны хэмжээ болсон нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл илүү эрсдэлд өртөх нөхцөлийг болгож байна. Тухайлбал, газар зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн давтамжийн тоо 1.5-нэмэгдэж, хохирлын хэмжээ сүүлийн 10 жилд өмнөх 10 жилээс 10-14 хувиар ихэссэн байна. Сүүлийн 30 жилд хугацаанд нийт 21.1 сая толгоогой хорогдсоныг мөнгөн дүнгээр илэрхийлбэл 860 тэрбум төгрөг хохирол учирчээ. Байгалийн хохирлын үндсээ барих чадамж суларч хохиролыг гулгалт, шилжилт нэмэгдүүлж, туйран салхи, шороон шуурга давамгайлсан тохиох болов. ургамалжилтын бүх бүс бүс бүс тохиолдох зудын индекс өсч, тухайн даван туулах чадавх сул байна.	9 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэл 9.1.Тогтвортой хөдөө аж ахуйн хөгжлийн зорилтыг хангах зорилго, улсын хэмжээнд дунд хугацааны бодлого, аймаг, нийслэл, сум, дунд хугацааны төлөвлөгөөтэй байна. 9.2.Энэ хуулийн 9.1-д заасан бодлого, төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулан батлуулан хэрэгжүүлнэ. 9.3.Тогтвортой хөдөө аж ахуйн бодлого, төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгана: 9.3.1.тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх зорилго, зорилт бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг бүр өөрийн онцлогт нийцэх тодорхойлох; 9.3.2.хөдөө аж ахуйг төрөлжүүлэх, бүс нутаг тогтоох бэлчээр хамгаалах төлөвлөгөө, хөдөө аж ахуйн гаралтай түүхийг бүтээгдэхүүнийг боловсруулах, нийлүүлэх өртгийн сүлжээ, зах зээлийн худалдааны сүлжээ, хөдөө аж ахуйн кластер хөгжүүлэх асуудлыг өөрийн нутаг дэвсгэрийн онцлог, малын тэжээлийн хүрээ, аж ахуй эрхлэх боломж, ажиллах хүчний хүрэлцээ, хүн амын хангамж, эрэлт, хөрөнгө оруулалтын боломж зэрэгтэй уялдуулан тодорхойлох; 9.3.3.тухайн нутаг дэвсгэрт өсгөн үржүүлж байгаа үүлдэр, малын нэгжээс авах ашиг шим болон нэгж талбайгаас хураан авч таримал бүрийн ургацыг сүүлийн 3 жилийн дунджаас нэмэгдүүлж боломж, хүрэх түвшинг тооцох; 9.4.Аймаг, сумын дунд хугацааны төлөвлөгөөнд энэ хуулийн заасан зорилтыг өөрийн онцлогт тохируулан сонгон авч тусгана. 9.5.Аймаг, сумын тогтвортой хөдөө аж ахуйн хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн шатны Засаг хариуцан зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу тайлагнаж тусгана.
	10 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хүний нөөц 10.1.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь салбарын хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх стратегийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. 10.2.Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн зорилтыг шийдвэрлэх шаардагдах мэргэшсэн хүний нөөцийн хэрэгцээг мэргэжил, мэргэжлээр урт, дунд хугацаанд тодорхойлж, хэрэгцээг хангах арга хэрэгсэл төлөвлөж хэрэгжүүлнэ.

	10.3.Тогтвортой хөдөө аж ахуйн зорилтыг шийдвэрлэхэд чухолбогдолтой мэргэжлээр их, дээд сургууль, мэргэжлийн боловсролтой байгууллагад шинээр анги нээх, гадаад оронд сургаж бэлтгэх хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран зохион байгуулна. 10.4.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь албан боловсрол эзэмшсэн хөдөө аж ахуйн аж ахуйн мэргэжилтнийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран 5 жил тутам мэргэжил дээшлүүлэх сургалтын системтэйгээр хамруулах ба мэргэжлийн ур чадварын түвшнээр мэргэжлийн зэрэг олгоно. 10.5.Энэ хуулийн 10.4-т заасан хөдөө аж ахуйн салбарын ажилтан, мэргэжилтний мэргэжлийн ур чадварын түвшинг үргэлжлүүлэх мэргэжлийн зэрэг олгох асуудлыг тухайн салбарын нарийвчлал хуулиар зохицуулна.
	11 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлд нөлөөлөх эрсдэлийг үнэлэх, түүний удирдлага, зохицуулалт 11.1.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хангах хөгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах, удирдах явцад учирч болзошгүй хүчин зүйлсийн нөлөөллийн эрсдэлийг тогтооно. 11.2.Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлд учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээг ердийн нөхцөлд 5 жил тутам, аль нэг эрсдэлт нөхцөлд байдал үүссэн болон үүсэх магадлал өндөрссөн үед Засгийн газрын шийдвэрээр тухай бүр хийнэ. 11.3.Энэ хуулийн 11.2-т заасан эрсдэлийн үнэлгээг зохион байгуулах үүсгэгч аюул болон хүчин зүйлсийн чиглэлээр мэргэшсэн, хараагч судлаач, шинжээчдээс бүрдсэн эрсдэлийн үнэлгээний баг гүйцэтгэнэ. 11.4.Энэ хуулийн 11.3-т заасан эрсдэлийн үнэлгээний багийн Засгийн газраас 5 жилийн хугацаатай байгуулж ажиллуулна. Үнэлгээний багийн ажиллах журмыг Засгийн газар батална. 11.5.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд нөлөөлөх эрсдэлийг тогтоонох үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалыг хөдөө аж ахуйн болон бусад орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран батална. 11.6.Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлд учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээ хийх зардлыг Засгийн газрын нөөц санхүүжүүлнэ.

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (UNEP)-ийн мэдээллээр⁷ Монгол Улсын агаарын жилийн дундаж температур 1940 оноос 2.14 хэмээр халуун байгаа нь дэлхийн агаарын дундаж температураас хоёр дахин хурдтай нэмэгдсэн үзүүлэлт ажээ. Мэдээж үүний нөлөөнд хөдөө аж ахуйн салбар илүү их өртсөн. Нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг малчдын хувьд хахир хатуу цаг агаар нь гэнэтийн зүйл биш хэдий ч өнгөрсөн жилүүдийн зуд, хуурайшилт, аадар бороо, их хэмжээний цас, элсэн шуурга, зэрэг байгалийн гамшгийн давтамж нь малчдын ахуй амьдрал, амьжиргаа, эдийн засагт ихээхэн хүндрэл бэрхшээл учруулсан юм. Тариалангийн үйлдвэрлэл мөн байгаль, цаг уур, түүний өөрчлөлтөөс ихээхэн хараат. Цаашид уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуй, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тооноос чанарт шилжих, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд төлөвлөлт чухал байна. Тиймээс тогтвортой хөдөө аж ахуйн хөгжлийн зорилтыг хангах зорилгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлсэн улсын хэмжээнд дунд хугацааны бодлого, аймаг, нийслэл, сум, дүүрэг дунд хугацааны төлөвлөгөөтэй байхыг хуульчлах нь дээрх нөхцөл байдлыг нөлөөллийг бууруулах, сааруулах, хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг эрхлэхэд суурь нөхцөл болж өгнө. Хуулийн төсөлд дээр дурдсан төлөвлөгөөг хөдөө аж ахуйг төрөлжүүлэх, бүс нутаг тогтоох болон бэлчээр хамгаалах төлөвлөгөө, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах, нийлүүлэх өртгийн сүлжээ, зах зээл, бөөний худалдааны сүлжээ, хөдөө аж ахуйн кластер хөгжүүлэх зэрэг асуудлыг өөрийн нутаг дэвсгэрийн онцлог, малын тэжээлийн хүртээмж, аж ахуй эрхлэх боломж, ажиллах хүчний хүрэлцээ, хүн амын хүнсний хангамж, эрэлт, хөрөнгө оруулалтын боломж зэрэгтэй уялдуулан тодорхойлохыг чухалчилж, хариуцах байгууллага, албан тушаалтныг зааж, тайлагнаж байхыг үүрэгжүүлсэн хэм хэмжээ тогтоосон нь хуулийн төслийн хэрэгцээ, шаардлага, зорилгод нийцсэн гэж дүгнэв.

Түүнчлэн Хөдөө аж ахуйн тогтвортой байдлыг хангахад хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, тэдгээрийн тогтвор суурьшилтай ажиллаж, ая тухтай амьдрах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх чиглэлээр албан ба албан бус боловсрол олгох замаар хөгжүүлэх асуудлыг тусгажээ. Мөн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хангах, хөгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах, удирдах явцад байгаль орчны, нийгмийн, эдийн засгийн нөлөөллийн эрсдэлийг тогтоож, тогтвортой хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд нөлөөлөх эрсдэлийг үнэлэх асуудлыг чухалчилсан нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлэхээр байна гэж дүгнэв. Эдгээр зохицуулалттай уялдуулж тогтвортой хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэл, чанарын удирдлага, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн даатгал, тогтвортой хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэлгээ, баталгаажуулалт, тогтвортой хөдөө аж ахуйн судалгаа ба хөгжүүлэлтийн харилцааг хуульчлан баталгаажуулахаар тусгасан нь хууль хэрэгжилтэд түлхэц болох боломжтой байна.

Дөрөв. Төрийн дэмжлэгийн талаар:

Хэрэгцээ, шаардлага, зорилго	Нийцсэн эсэх
Хөдөө аж ахуйгаас зах зээлд нийлүүлж түүхий эд, бүтээгдэхүүнд чанараас хам ялгавартай үнийн тогтолцоо байхгүй, ча хамаарсан ямар нэгэн шалгуургүйгээр бүтээгдэ зөвхөн тоон хэмжээг харгалзан төрөөс урамшуулал олгож байгаагаас үйлдвэрлэл эрх бэлтгэн нийлүүлэгчид бүтээгдэхүүний анхаарахгүй байна. Мөн хөдөө аж ахуйн түүхий чанарын ангилалт, анхан шатны тордолт	13 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн үйлдвэрл дэмжлэг, түүний төрөл 13.1.Хөдөө аж ахуйн хөгжлийн дэмж хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн ба ээлтэй, үр ашигтай үйлдвэрлэлийг тогтвортой э орлогыг нь нэмэгдүүлэх талаарх сонирхол, хариу нь дээшлүүлэхэд чиглэгдсэн байна.

⁷ <https://mongolianeconomy.mn/%D1%82%D0%BE%D0%B3%D1%82%D0%B2%D0%BE%D1%80%D1%82%D0%BE%D0%B9-%D0%BC%D0%B0%D0%BB-%D0%B0%D0%B6-%D0%B0%D1%85%D1%83%D0%B9-%D0%B1%D0%BE%D0%BB-%D0%BC%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB-%D1%83%D0%BB%D1%81%D1%8B/>

тогтолцоо байхгүйгээс шалтгаалан түүхийг үнэгүйдэж, хаягдаж байна. Түүнчлэн, мал аж ахуй, газар тариалалтын үйлдвэрлэлийн уялдаа, холбоо дутмагаас биеэ тэтгэн хөгжүүлэх талаар дорвитой үйл ажиллагаа явагдахгүй, төрийн дэмжлэгийн зааг ялгааас байгаагаас бие биенээ үгүйсгэн шахах, маргаан асуудал улам бүр хурцадмал болж байна.	13.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр төсвөөс олгох дэмжлэг, урамшуулал дурдсан шалгуурыг хангасан байна: 13.2.1.уур амьсгалын өөрчлөлтөд зохицоход чиглэгдсэн дэвшилтэт технологийн үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байх; 13.2.2.бэлчээрийн болон тариалан газрын хөрс, үржил шимийг хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх арга хэмжээнд хувийн зүгээс хамруулалт хийсэн байх; 13.2.3.бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн бүтээмжээ дээшлүүлсэн байх; 13.2.4.стандартын шаардлага хангасан түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэн үнэгүйдэх үйлдвэрлэлд нийлүүлсэн байх; 13.2.5.малын чанар болон засгийн эргэлтийг сайжруулах замаар бэлчээд даацад малын тоог нийцүүлсэн байх; 13.2.6.бэлтгэн нийлүүлэх хоршоогоор дамжуулан арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлсэн байх. 13.3.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд урамшуулал олгохдоо дараах тэргүүлэх чиг баримтлана: 13.3.1.бэлчээрийг хамгааж сайжруулж, даацад нь малын тоог нийцүүлэх; 13.3.2.боловсруулах үйлдвэрлэлд нийлүүлсэн сүүний хэмжээг нэмэгдүүлэх; 13.3.3.мах, сүүний эрчимжсэн ажлаа өндөр ашиг шимт мал, тэжээлийн хангамж сайжруулах; 13.3.4.хоршооны зохион байгуулалт орж мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэл, анхан шатны боловсруулалт хийх жижигн үйлдвэрийг хөгжүүлэх; 13.3.5.хоршин ажиллаж буй тариалан эрхлэгчдэд хоршоогоор дамжуулан үйлдвэрлэлийн орц, техник, тоног төхөөрөмж хангамжийг сайжруулах; 13.3.6.дэвшилтэт технологи нарийн ногооны хүлэмжийн аж ахуй, технологийн стандартын шаардлага хангасан зоорь, агууламж ахуйг хөгжүүлэх;
--	--

	13.3.7.хөрсний үржил, сайжруулан хамгаалахад чиглэсэн бордоо, хангамж, ойн зурвас байгуулах. 13.4.Хөрөнгө оруулалтын багтаамж үйлдвэрлэгчийн зүгээс дангаараа санхүүжилт хүндрэлтэй хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх дараах чиглэлийн төсөл, хөтөлбөрийг хөнгөлөлттэй, урт хугацаатай зээлээр дэмжинэ: 13.4.1.малын үүлдэр, угсааг сайжруулах үүднээс өндөр ашиг шимт мал худалдан авах; 13.4.1.эрчимжсэн мал аж ахуйн байгууламж барих; 13.4.2.таримал тэжээл үйлдвэрлэл бүсийн, аймаг дундын, аймгийн өвс тэжээлийн нийслэл, хот, сум, дүүргийн төв байгуулах; 13.4.3.эрчимжсэн сүүний аж ахуйн төхөөрөмж худалдан авах; 13.4.4.усалгаатай газар тариалан барилга байгууламж барих; 13.4.5.тариалангийн талбайн зурвас, хашаа барих; 13.4.6.таримал жимс, жимсгэнэ эмийн ургамлын үйлдвэрлэл эрхлэх; 13.4.7.өндөр бүтээмжтэй, орчин ухаалаг технологи бүхий трактор, комбайн, төхөөрөмж худалдан авах; 13.4.8.эрчим хүчний хэмнэлттэй ургамал, технологи, тохируулга бүхий хүнсний ногооны агуулахын аж ахуй, хүлэмж барих; 13.4.9.ногоон хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх; 13.4.10.дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах хэмжээ авах; 13.4.10.хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний тээвэр, ложистикийг хөгжүүлэх.
--	---

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх дэмжлэгийг салбарын ерөнхий дэмжлэг, үйлдвэрлэгчид болон хэрэглэгчид үзүүлэх дэмжлэг гэсэн төрлүүдэд ангилсан нь олон улсын жишиг хандлагат нийцсэн эрх зүйн орчинг бүрдүүлэхийг зорьсон ач холбогдол бүхий зохицуулалт болжээ гэж үзэв. Хөдөө аж ахуйн хөгжлийг мөнгөн 11 ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ болон мөнгөн бус хэлбэрээр дэмжих бөгөөд хөдөө аж ахуйг дэмжих бодлогын үр өгөөжийг нийт дэмжлэгийн хэмжээгээр илэрхийлж, тооцоолно гэсэн тодорхой зохицуулалтыг тусгасан байна.

Салбарын зарим хуулиар тухайлбал Тариалангийн тухай хуулиар тариалангийн үйлдвэрлэлд төрөөс үзүүлэх дэмжлэг, урамшуулал, шалгуур үзүүлэлт, Хүнсний тухай хуулиар хүнсний сүлжээнд оролцогчдод үзүүлэх дэмжлэг, урамшуулал олгохоор хуульчлан, татварын хуулиудаар татвараас хөнгөлөх, чөлөөлөх зэргээр хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжиж иржээ. Мөн Хүнсний хувьсгал, Атар 4 аян, Цагаан алт зэрэг хөтөлбөрүүд болон бусад баримт бичгийн хүрээнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, түүнээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр эцсийн бүтээгдэхүүн үйлдэрлэхэд хөнгөлттэй зээлийг бодлогоор дэмжиж байгаа. Гэсэн хэдий ч хөдөө аж ахуйгаас зах зээлд нийлүүлж байгаа түүхий эд, бүтээгдэхүүнд чанараас хамаарсан ялгавартай үнийн тогтолцоо байхгүй, чанараас хамаарсан ямар нэгэн шалгуургүйгээр бүтээгдэхүүний зөвхөн тоон хэмжээг харгалзан төрөөс мөнгөн урамшуулал олгож байгаагаас үйлдвэрлэл эрхлэгчид, бэлтгэн нийлүүлэгчид бүтээгдэхүүний чанарт анхаарахгүй байна. Мөн хөдөө аж ахуйн түүхий эдийн чанарын ангилалт, анхан шатны тордолт хийх тогтолцоо байхгүйгээс шалтгаалан түүхий эд үнэгүйдэж, хаягдаж байна.

Түүнчлэн, мал аж ахуй, тариалангийн үйлдвэрлэлийн уялдаа, холбоо дутмагаас бие биеэ тэтгэн хөгжүүлэх талаар дорвитой үйл ажиллагаа явагдахгүй, төрийн дэмжлэгийн зааг ялгаа асар их байгаагаас бие биенээ үгүйсгэн шахах, маргаан үүсгэх асуудал улам бүр хурцадмал болж байна. Энэ нөхцөл байдал нь Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2.1.2-т “Хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой эрдэс баялаг, хүнс, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, санхүүгийн салбарыг олон улс, Европын Холбооны стандартад нийцүүлэн хөгжүүлнэ.” Гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын зорилт 8.3-т “Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.4.1-д “мал аж ахуйн гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалтын түвшнийг сайжруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” гэж, Зорилт 4.4-т “эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж, хүнсний дотоодын хэрэгцээг ханган, экспортын хувь хэмжээг нэмэгдүүлнэ” гэж дэвшүүлсэн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгийн зорилтууд, төлөвлөсөн үр дүнд хүрч чадахгүй байдалд хүргэж байгаа. Тиймээс, хуулийн төсөлд төрийн дэмжлэгийн төрлийг ялган зааж, үзүүлэх шалгуурыг байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи, инноваци нэвтрүүлсэн, чанар, эрүүл ахуй, хөрсний үржил шим, бэлчээрийн даацыг чухалчлан, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлсэн байхаар тогтоож, дэмжлэг, урамшуулал олгох тэргүүлэх чиглэлийг тусгайлан заасан. Энэ нь төрийн дэмжлэг, урамшуулал нь хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлж, үнэ цэн бий болгох, өрсөлдөх чадварыг сайжруулах хуулийн зорилгыг хангахад чиглэгдсэн гэж үзэв. Түүнчлэн төрөөс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхдээ УИХ-ын болон ЗГ-ын тогтоол батлах замаар тухайлсан салбар луу чиглэсэн бодлого гаргаж дэмжиж байгаа ба энэ богино, дунд хугацаатай, тэргүүлэх чиглэл, шалгуур үзүүлэлт нь тус тусдаа байгааг урт хугацаанд заавал мөрдөхөөр тэргүүлэх чиглэл, дэмжлэгийн төрөл, шалгуур үзүүлэлтийг хуульчилж багаа нь урт хугацаанд тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн үзэл санаа, зорилт, үр дүнд хүрэх механизм бүрдэх боломжтой зохицуулалт болжээ гэж үнэлэв.

Тав. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, оролцогч субъектын талаар

Хэрэгцээ, шаардлага, зорилт	Нийцэж буй эсэх
-----------------------------	-----------------

Монгол Улсад хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрхлэл, төгсгөлийн зааг, хэлбэр, төрлийг нарийвчлан тодорхойлоогүй, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч субъектуудын ялгааг тогтоогдоогүй, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн сүлжээнд оролцогч талуудын чиг үүрэг, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн зарчим, хяналт, хариуцлагын механизм тодорхойгүйгээс үүдэлтэйгээр төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээ, дэмжлэг үр дүн муутай, дотоодын зах зээлийн үнэ тогтворгүй, нөөцийн ашиглалт хангалтгүй зэргээр хөдөө аж ахуйг хөгжүүлэх үйл ажиллагааг нэгдмэл байдлаар удирдан зохион байгуулах, чиглүүлэхэд зарим хүндрэлүүд үүсдэг.	18 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн салбар дахь удирдлага, зохицуулалт 18.1.Хөдөө аж ахуйн салбарын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, байгуулах, үр дүнг үнэлэх чиг үүргийг улсын хэмжээнд хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ. 18.2.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд мал, болон ургамлын эрүүл мэндийн асуудал хариуцаж, төрийн захиргааны байгууллага, хөдөө аж ахуйн захиргааны байгууллага, хөдөө аж ахуйн инноваци, технологи нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх төрийн байгууллага, хөдөө аж ахуйн чиг үүрэг, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой ажиллагааг эгтгээд тус тус ажиллана. 18.3.Аймаг, нийслэл, сум, дүүрэгт хөдөө аж ахуйн салбарын мал, амьтны болон ургамлын эрүүл мэндийн асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллага, нэгдмэл байдлаар хөдөө аж ахуйн салбарын бодлогын хэрэгжилтийг зохион байгуулна.
--	--

Өмнө нь ийм байдлаар нэгтгэсэн зохицуулалт байхгүй байсан ба салбарын хуулиудад тухайн чиглэлд хэрэгжүүлэх чиг үүргийг тусгасан байдаг. Энэ байдал нь чиг үүрэг давхардах, орхигдох зэрэг асуудал үүсгэдэг байсан. Харин хуулийн төслийн Зургаадугаар бүлгээр Хөдөө аж ахуйн салбар дахь төрийн удирдлага, зохицуулалтыг тусгасан байна. Ингэснээр төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудыг хөдөө аж ахуйн салбарыг удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг тодорхой болж, хууль батлагдсаны дараа хуулийг хэрэгжүүлэхэд дөхөмтэй байх нөхцлийг бүрдүүлсэн байна гэж үзэв.

Зургаа. Хөдөө аж ахуйн салбарын бүртгэл, мэдээллийн талаар:

Хэрэгцээ, шаардлага, зорилт	Нийцэж буй эсэх
Хөдөө аж ахуйн салбарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэхдээ хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн өвөрмөц онцлогийг харгалзан цогц байдлаар үзэхгүйгээр зөвхөн нэг талаас нь харж шийдвэр эдийн засгийн зарим арга, хөшүүргийг буруу хэрэглэж, төрөөс дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах бодлого, тууштай хэрэгжүүлэхгүй байх, гадаадын тусламжийн төслийн хөрөнгө оруулалтыг о	19 дүгээр зүйл. Хөдөө аж ахуйн салбарын бодлогын мэдээллийн сан 19.1.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай байна.

ашиглахгүй байгаа талаар эрдэмтэд, судлаачид онцлон тэмдэглэсээр байна.	19.2.Нэгдсэн цахим санд хүнсний ба усны болон аюулгүй байдлын, мал аж ахуйн, малын генетикийн, мал, амьтны эрүүл мэндийн тариалангийн үйлдвэрлэлийн, ургамал хамгааллын, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн, худалдаа, үйлчилгээний, үйлдвэрлэлд нэвтрүүлж байгаа зохистой дадал, технологийн зөвлөмжийн, биологийн аюулгүй байдлын, нэг эрүүл мэндийн, бүтээгдэхүүний үнийн, хөдөө аж ахуйн экспорт, импортын, зөвшөөрлийн зэрэг мэдээллийн дэд сан ажиллана. 19.3.Нэгдсэн цахим сан нь цахим хөдөө аж ахуйн төрийн бодлого, хөтөлбөрт нийцсэн байх бөгөөд хугацаа, орон зайнаас үл шалтгаалан хэрэгсэл төрийн үйлчилгээг хурдан шуурхай, ил тод, хялбар чирэгдэлгүй авах бололцоог бүрдүүлнэ. 19.4.Хөдөө аж ахуйн нэгдсэн цахим сан бүрдүүлэх, хөтлөх, мэдээллийн дүн шинжилгээ өгөгдөл боловсруулах, мэдээлэл дамжуулах, хэрэгсэл үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бичиг журмаар зохицуулна. 19.5.Хөдөө аж ахуйн цахим мэдээллийн санг урт хугацааны мэдээллийн архивтай байна.
--	---

Хөдөө аж ахуйн салбарын бүртгэл, мэдээллийн сан, хөдөө аж ахуйн салбарын хяналттай холбогдох харилцааг зохицуулахаар заана. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн мэдээллийн сан нь мал аж ахуйн; малын генетик нөөцийн; мал, амьтны эрүүл мэндийн; газар тариалангийн; ургамал хамгааллын; хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний; үйлдвэрлэлд нэвтрүүлж байгаа зохистой дадал, технологийн зөвлөмжийн; биологийн аюулгүй байдлын; нэг эрүүл мэндийн; бүтээгдэхүүний үнийн; хөдөө аж ахуйн экспорт, импортын зэрэг төрөлжсөн тоо бүртгэл, зах зээлийн талаарх бүртгэл, мэдээллийн дэд цахим сантай байх, уг санг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан ажиллуулахаар тусгасан. Ингэснээр хөдөө аж ахуйн дэд салбар, чиглэл бүрээр нэгдсэн мэдээлэлтэй болж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэд салбар бүрийн өвөрмөц онцлогийг харгалзан, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээ, зах зээлтэй уялдуулсан цогц бодлого боловсруулах, хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой тодорхойлох таатай нөхцөлийг бүрдүүлэх боломжийг үүсгэж байгаа хэм хэмжээ гэж дүгнэв. Мөн зөвхөн олон талаас нь харж шийдвэрлэх, эдийн засгийн зарим арга, хөшүүргийг оновчтой хэрэглэх, төрөөс дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах бодлого, гадаадын зээл, тусламжийн төслийн хөрөнгийг оновчтой хуваарилах, ашиглах нөхцөлд

дэм болох төдийгүй цаг хугацаа, байршил үл харгалзан мэдээллийг хурдан шуурхай цуглуулах, Алсын хараа 2050-д дэвшүүлсэн цахим засаглалд хувь нэмэр оруулах хөдөө аж ахуйг цахимжуулахад чухал зохицуулалт тул хуулийн төслийн зорилго, үзэл баримтлалд нийцсэн байна гэж дүгнэв.

3.“ОЙЛГОМЖТОЙ БАЙДЛЫГ СУДЛАХ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ:

Ойлгомжтой байдал Хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд тус тус нийцсэн байдал, мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийн Хөдөө аж ахуйн салбар дахь төрийн удирдлага, зохицуулалт гэсэн зургаадугаар бүлгийн зохицуулалтыг бүлгээр нь сонгон авч хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд оролцогч субъектүүдийн эрх зүйн статусыг хэрхэн хуульчлахаар заасныг үндэслэл болгов. Энэ нь хөдөө аж ахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн болон бусад хамаарал бүхий этгээдүүдийн эрх, үүргийг нарийвчлан зохицуулан хуульчлахаар боловсруулсан байдлыг шалгаж үнэлэх нь хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хэрхэн ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулсан эсэхийг шалгах хууль зүйн үндэслэл гэж үзэв. Хуулийн төслийн сонгож авсан тавдугаар бүлэгт дараах хөдөө аж ахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, төлөвлөх, хэрэгжүүлэх чиг үүргийг улс, аймаг, нийслэл, сум, дүүрэгт төрийн эрх бүхий байгууллагуудын бүтцийн нэгж эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцан гүйцэтгэхээр тусгасан нь хуулийн зохицуулалт ойлгомжтой байх нөхцлийг бүрдүүлсэн байна. Түүнчлэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд мэргэжлийн байгууллагын оролцоо зайлшгүй шаардлагатай байгаа өнөө үед төрийн захиргааны төв байгууллагын дэргэд Хөдөө аж ахуйг хөгжүүлэх орон тооны бус зөвлөл, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрдэм шинжилгээ, судалгаа, инноваци, технологи нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллага, хөдөө аж ахуйн чиглэлийн төрийн өмчит байгууллагатай байх асуудлыг тусгаж, эдгээр байгууллагын бүтэц, зохион байгуулалт, эрх хэмжээ, чиг үүргийг тогтоохоор заасан нь цаашид хөдөө аж ахуйн хөгжилд зохих хувь нэмэр оруулах боломжтой болохоор давуу талтай гэж үнэлэв. Мөн орон нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүргийг хуулиар тодорхой болгох, тухайлбал, мал аж ахуйн болон тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлэх замаар тухайн нутаг дэвсгэрийн хөдөө аж ахуйн хөгжлийн бодлого, төлөвлөлт хийх асуудлыг чухалчилсан ач холбогдолтой байна. Төрийн өмчит байгууллагын чиг үүргийг тогтооход байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээ авах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж импортыг орлох экспортын чиглэлийн үйлдвэрлэл, хоршоо, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлэх болон хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүний үнийн зохицуулалтын талаар арга хэмжээ авах, урт хугацааны хөрөнгө оруулалт, санхүү, зээлийн уян бодлого хэрэгжүүлэх гэх мэт хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд эдийн засгийн чиглэлийн өргөн цар хүрээтэй бодлого бүхий зохицуулалтыг бий болгох агуулгатай зохицуулалт байгааг дэмжив. Энэ бүлэгт буй онцлог зохицуулалт бол хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд орон тооны бус Хөдөө аж ахуйг хөгжүүлэх мэргэжлийн Зөвлөл ажиллуулах асуудлыг багтаасан нь хөдөө аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх, холбогдох судалгаа, дүн шинжилгээ хийх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлийн санал боловсруулах, зөвлөмж өгөх, гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах гэх зэрэг эрх хэмжээг тогтоохын зэрэгцээ уг зөвлөл хариуцлагатай ажиллах чиг үүргийг тусгасан байна.

Түүнчлэн төрийн байгууллагын дурдсан асуудлыг тусгасны зэрэгцээ иргэний нийгмийн байгууллага, хөдөө аж ахуйн үйлдвэрлэгч, хөрөнгө оруулагч гэх зэрэг хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд оролцогч субъектүүдийн эрх зүйн байдлыг хуульчлах үзэл баримтлалтай зохицуулалтууд энэ бүлэгт багтжээ. Энэ нь Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэвшилттэй алхам болох шийдэл болсон байна.

4.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДӨХ БАЙДАЛ

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээдүүд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгахдаа хүчин төгөлдөр үйлчилж буй хамаарал бүхий хуулийн зохицуулалттай харьцуулан шалгав. Өөрөөр хэлбэл, тухайн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд нийцэх эсэхийг шалгах тухай Аргачлалын шаардлагын дагуу үнэлж үзэхэд хуулийн үйлчлэх хүрээг Монгол Улсын нутаг дэвсгэрт хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагаатай холбогдох ерөнхий харилцаанд хамаарах байдлаар зааглан, малын генетик нөөц, мал, амьтны эрүүл мэнд, малын индексжүүлсэн даатгал, малын тоо толгойн албан татвар, тариалан, таримал ургамлын үр сорт, үрийн тариалангийн даатгал, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж, хүнсний, органик хүнс, болон хүнсний аюулгүй байдалтай холбоотой харилцааг холбогдох хуулиар тус тус зохицуулахаар боловсруулсан байна.

Малын генетик нөөцийн тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль, Малын тоо толгойн албан татварын тухай хууль, тариалан, таримал ургамлын үр сортын тухай хууль, үрийн тариалангийн даатгалын тухай хууль, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, хүнсний тухай хууль, органик хүнс, болон хүнсний аюулгүй байдлын тухай хуулийн зохицуулалттай хуулийн төслийг харьцуулан судалж үнэлэхэд эдгээр төрөлжсөн хуулийн зохицуулалттай давхардсан, зөрчилдсөн зохицуулалт байхгүй байна гэж үнэлсэн. Харин дурдсан хуулиудад хуульчлагдаагүй харилцааг хөдөө аж ахуйн ерөнхий хуулиар зохицуулах үзэл баримтлалаар уг хуулийн төслийг боловсруулсан дэвшилтэт агуулгатай байна гэсэн үнэлгээ хийв.

ТАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН НЬ

Аргачлалын 4.1-д “энэ үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлнэ.” гэж, мөн аргачлалын 4.4-д “Шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийн үр нөлөөг яаж үнэлэхийг тогтооно” гэж тус тус заасныг хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний энэ хэсэгт мөрдөж ажиллав.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлгээний өмнөх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлт, түүнд ашиглахаар тогтоосон шалгах хэрэгсэлийн дагуу дараах байдлаар үнэлж байна.

5.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:

Зорилгод хүргэх байдал шалгуур үзүүлэлтээр үр нөлөөг үнэлэхдээ “хуулийн төслийн зохицуулалтыг бүлгээр нь авч үзэх” гэж сонгосон тул хуулийн төсөлд тусгасан зохицуулалт, арга хэмжээ нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэхэд болон зорилгод хүргэх байдлыг үнэлэхдээ “зорилгод дүн шинжилгээ хийх” шалгах хэрэгслийг ашиглалаа.

Мөн тус үнэлгээг хийх хүрээнд хөдөө аж ахуйн салбарын холбоотой ном, гарын авлага, хамаарал бүхий хууль тогтоомж, олон улсын гэрээ, төрийн бодлогын баримт бичиг, төрийн албан ёсны байгууллагын цахим тайлан, мэдээлэл, өгүүлэл, нийтлэл зэргийг цуглуулж, судалж, боловсруулалт, дүн шинжилгээ хийж, энэхүү үнэлэх ажлыг гүйцэтгэсэн болно. Хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн төсөл боловсруулах болсон зорилго, түүнийг батлан гаргах хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон байдлыг хуулийн төсөлд тусгасан байдалтай харьцуулж, дүн шинжилгээг хийв.

НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилт, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын6 , Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050”7 , УИХ-ын 2021 оны 106

дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг, Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоол, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” 11, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн заалтуудыг хуулийн төслийн үзэл баримтлалын нэг дэх хэсэг буюу хуулийн төсөл боловсруулах эрх зүйн үндэслэл болгосон нь хөдөө аж ахуйн бие даасан хууль батлан гаргах хууль зүйн хэрэгцээг оновчтой илэрхийлжээ гэж дүгнэв.

Хуулийн төслийн үзэл баримтлал боловсруулах үндэслэлийн практик шаардлага хэсэгт эрдэмтэд, судлаачдын үзэл хандлага, холбогдох төрийн болон мэргэжлийн байгууллагын судалгаа, баримт, статистик тоо мэдээнд үндэслэн Монгол Улсын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарт үүсээд байгаа өнөөгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийг зорьсон байна. Тухайлбал,

- АНУ-д дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 1,0 хувь, Европын холбоонд 1,3 хувь, Японд 1,4 хувьтай тэнцэх санхүүжилтийн дэмжлэгийг улсын төсвөөс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд зарцуулдаг, Европын Холбооны орнуудад аж ахуйн төрөлжилтөөр, АНУ-д үйлдвэрлэлийн үйл ажиллагааны төрөлжит, үйл ажиллагааны зардлаар бүлэглэх, мөн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өөрийн өртгийн болон боловсруулалтын дараах үнийн тэнцвэрт байдал, аж ахуйн болон тухайн салбарын үйлдвэрлэлийн ашигт ажиллагаа зэргийг харгалздаг гадаадын орнуудын жишээг,

- Сүүлийн 3 жилийн дундажаар Монгол Улсын ДНБ үйлдвэрлэлийн 19.7 хувь, ХХААХҮ-ийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 66.1 хувийг хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл бүрдүүлж байна, 2024 оны байдлаар ДНБ-д 7,4 хувийг, экспортын орлогод 5 хувийг, орон нутгийн эдийн засагт 83 хувийг тус тус эзэлж, нийт ажиллах хүчний 23,7 хувь нь ажиллаж байгаа талаарх статистик тоо мэдээг,

- Мал аж ахуйн үйлдвэрлэлийн өвөрмөц онцлогийг харгалзан цогц байдлаар авч үзэхгүйгээр зөвхөн нэг талаас нь харж шийдвэрлэх, зарим эдийн засгийн арга, хөшүүргийг буруу хэрэглэх, төрөөс дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах бодлогыг тууштай хэрэгжүүлэхгүй байх, гадаадын зээл, төслийн хөрөнгө оруулалтыг оновчтой ашиглахгүй байгаа талаарх эрдэмтэд, судлаачдын үзэл баримтлалыг,

- Хүн амын хэрэглээнээс үзэхэд сүүлийн 10 жилийн үзүүлэлэлтээр нэг хүнд жилд ногдох махны хэмжээ 1.7 дахин, сүү 1.9 дахин, өндөг 5.0 дахин өсч, өндөгний дотоод зах зээлийн багтаамж жилд 86.5 тэрбум төгрөг, импортоор авч буй өндөгийг дотоодын үйлдвэрлэлээр хангахад 23.2 тэрбум төгрөгийн нэмэлт зах зээл нээлттэй байна. Мөн импортоор авч байгаа гахайн мах, өөхний хэмжээгээр тооцооход гахайн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлснээр жилд 75.5 орчим тэрбум төгрөгийн бүтээгдэхүүний дотоодын эрэлт хэрэгцээ, зах зээлийн боломж байна.

Сүүлийн 10 жилийн дундажаар мал аж ахуйн үйлдвэрлэлд нэгжээс авах ашиг шимийн гарцад өөрчлөлт төдийлөн гараагүй байна гэсэн төрийн байгууллагын тайлан мэдээг тус тус судлан багтааж хөдөө аж ахуйн бие даасан хууль боловсруулан батлах практикийн хэрэгцээг илэрхийлсэн нь онол, практикийн үндэслэлтэй болжээ. Хуулийн төслийн үзэл баримтлалд туссан хуулийн төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна. Хуулийн төслийн үзэл баримтлалын 2 дахь буюу “Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ” хэсэгт “Хуулийн төслийн зорилт нь хөдөө аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлогын суурь зарчмуудыг тодорхойлж, бүсчлэл, төрөлжилт, тогтвортой хөгжил, түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хэлхээ, өртгийн сүлжээ, хүний нөөц, эдэлбэр газрын зохистой ашиглалт, хамгаалал, салбарын бүртгэл, мэдээлэл, хяналт, эрсдэлийн шинжилгээ, үнэлгээ, удирдлага, оролцогч талуудын эрх, чиг үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зарим харилцаа, тулгамдсан асуудлыг зохицуулсан, хууль, тогтоомж, шийдвэрийг Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас гаргаж, хэрэгжүүлж байна.

салбарын үйлдвэрлэлийн тулгамдсан асуудлуудыг цогц байдлаар нь авч үзэхгүйгээр ихэнхдээ зөвхөн нэг талыг харж асуудлыг шийдвэрлэдэг. Салбараас хүн амын гол нэрийн хүнсийг, үндэсний боловсруулах үйлдвэрийн түүхий эдийг бүрэн хангах, тэдгээрт нэмэгдсэн өртөг шингээх, улмаар экспортлох замаар улс орны эдийн засагт тогтвортой өсөлт бий болгох асуудал нь чухал бөгөөд үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн асуудалд хамаарч байгаа тул хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, түүний нөөцийг бүрэн, оновчтой ашиглахад чиглэгдсэн эрх зүйн орчинг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Хуулийн төсөл нь 7 бүлэг, 21 зүйлээс бүрдэх ерөнхий бүтэцтэй байна” гэж тодорхойлжээ. Бие даасан хуулийн төсөл боловсруулах болсон үзэл баримтлалын үндсэн агуулга нь уг хуулийн төслийн зорилготой нийцсэн байна гэж үзэв.

Шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийн үр нөлөөг яаж үнэлэхийг тогтоохдоо хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал (зорилгод хүрэх байдал, ойлгомжтой байдал, харилцан уялдаа)-д үндэслэн үнэлгээ хийв.

№	Шалгуур үзүүлэлт	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах
3	Харилцан уялдаа	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

5.2. "Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр үр нөлөөг үнэлэхдээ “хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь авч үзэх” гэж сонгосон тул хуулийн төсөлд тусгасан зохицуулалтыг “ойлгомжтой байдлыг шалгах” хэрэгслийг ашиглаж үнэлэв. Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэх, хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хууль, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэх, хуулийн төсөлд хамаарах этгээдүүдээс санал авч, хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг тогтоох, хуулийн төслийн ойлгомжтой байдлыг Аргачлалд заасны дагуу шалгаж, дараах байдлаар дүн шинжилгээ хийсэн болно.

Хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хүснэгт.Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу үнэлгээ хийсэн байдал

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Шаардлага хангасан эсэх

29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлага хангасан..
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулсан байна.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлага хангасан
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавигдах нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан

30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

5.4.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд дурдсан асуултуудад хариулт өгөх зорилгоор хуулийн төслийг бүхэлд нь үнэлж, хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах байдлаар зохицуулалт хоорондын уялдаа холбооны үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

Асуулт	Хариулт
1. Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилготой нийцэж буй эсэх	Тийм.
2. Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм. Хөдөө аж ахуйн салбарт дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийг хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан байгаа ба эдгээр нь Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслөөр зохицуулах харилцаанд хамаарч байна.
3. Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хууль тогтоомжийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	Тийм. Хуулийн төслийн нэр томьёоны тодорхойлолтууд нь төсөл болон төсөлд тусгасан бүлэг, зүйл, заалтын нэр томьёотой нийцсэн байна.
4. Хуулийн төслийн хэсэг, заалт тухайн хуулийн төслийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм. Хуулийн төслийн зохицуулалт хоорондоо агуулгын хувьд зөрчилгүй байна.
5. Хуулийн төслийн хэсэг, заалт тухайн хуулийн төслийн заалттай давхардсан эсэх	Үгүй. Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтын агуулгыг давхардаагүй байна.
6. Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм. Хуулийн төслийн Зургаадугаар бүлэгт хуулийг хэрэгжүүлэх этгээдүүдийг тодорхойлсон байна.
7. Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Үгүй. Хуулийн төслийн зорилгод хүрэх хэмжээний зохицуулалт тусгагдсан гэж үзэж байна. Иймд төсөлд орхигдуулсан шаардлагатай зохицуулалт байхгүй.
8. Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй. Хуулийн төслийн Зургаадугаар бүлэгт төрийн болон орон нутгийн захиргааны болон бусад холбогдох байгууллагын чиг үүргийг тодорхойлсон байх бөгөөд чиг үүргийн давхцал үүсээгүй байна.
9. Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломж байгаа эсэх	Үгүй.
10. Татварынхаас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Үгүй. Тус хуулиар татвар, төлбөр, хураамжтай холбоотой харилцааг зохицуулаагүй байна.

11. Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Үгүй. Тус хуулийн төслөөр тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулаагүй тул Зөвшөөрлийн тухай хууль тусгах шаардлагагүй байна.
12. Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдсан эсэх	Үгүй. Хуулийн төсөлд хүний эрхийг аливаа хэлбэрээр хязгаарласан, хориглосон зохицуулалт тусгагдаагүй байна.
13. Хуулийн төслийг зохицуулалт нь жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Тийм. Хуулийн төсөл бүхэлдээ жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн байна.
14. Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй. Хуулийн төслийн зохицуулах харилцаанд шударга бус өрсөлдөөнтэй холбоотой харилцаа хамаарахгүй.
15. Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй. Хуулийн төслийн зохицуулалтууд нь хуулийн зорилго болон зарчмыг хангахад чиглэсэн байх бөгөөд зохицуулалтууд нь аливаа хэлбэрээр авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдээгүй байна.
16. Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тусгасан эсэх	Тийм. Тус хуулийн төслийн хамт Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлж байх бөгөөд дээрх хуулийн төсөлд хариуцлагын талаар зохицуулсан байна.

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт хоорондоо болон бусад хуулиудтай зөрчилдөж буй эсэх, агуулгын хувьд давхцал үүссэн эсэхэд дүн шинжилгээ хийж үзэхэд, эрх зүйн зохицуулалтын давхардал, зөрчилгүй байна.

ЗУРГАА. ҮР ДҮНГ ҮНЭЛСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралт “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д үндэслэн Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааны тайланг хийж гүйцэтгэлээ. Тус хуулийн төслөөс түүний үр нөлөөг үнэлэхэд ач холбогдол бүхий зохицуулалтыг сонгон авч зорилгод хүрэх байдал, практикт хэрэгжих боломж, ойлгомжтой байдал, хүлээн зөвшөөрөгдөх байдал, харилцан уялдаа гэсэн шалгуураар үнэллээ.

ДҮГНЭЛТ:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д хуульчилсан “Хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулна” гэсэн хэм хэмжээг зөрчөөгүй байна гэсэн нэгдсэн дүгнэлт хийв.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих чиглэлээр хангалттай түвшинд хүргэх зорилготойгоор боловсруулсан байна.

Хуулийн төслийн үр нөлөөг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэхэд Хөдөө аж ахуйн ерөнхий хуулийн төсөл нь хуулийн төсөлд тавьсан зорилтод хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байдлаар боловсруулагдсан байна.

Хуулийн төслийн зорилт нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагын үндэслэлийг бүрэн илэрхийлэх түвшинд томъёологдсон байна.

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөлд тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлжээ гэж үзэв.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр хуулийн хоёрдугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан хуулийн төсөл боловсруулахад тавигдах шаардлагад нийцсэн байдлаар боловсруулагдсан байна.

Хуулийн төслийн бүлэг, зүйл, заалт, дэд заалт хооронд зөрчилгүй, Монгол Улсын Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой харилцан уялдсан байна.

ЗӨВЛӨМЖ

Хөдөө аж ахуйн ерөнхий хуулийн төслийг дагалдаж, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОХ ГАРАХ ЗАРДЛЫН
ТООЦООЛОЛ**

Улаанбаатар хот
2025

АГУУЛГА

УДИРТГАЛ

- I. ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО
 - Иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох
 - Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох
 - Тоон үзүүлэлтийг тооцох
 - Нийт дүнг тооцож гаргах
 - Хялбарчлах боломжийг шалгах.
- II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО
 - Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох
 - Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох
 - Гарах зардлыг урьдчилан тооцох
 - Зардлыг нэгтгэн тооцох
 - Хувилбарыг шалгаж, үр дүнг танилцуулах
- III. НИЙТ ЗАРДЛЫН ДҮНГ ТООЦОХ
- IV. ДҮГНЭЛТ

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2.1.2-т “Хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад стратегийн ач холбогдолтой эрдэс баялаг, хүнс, хөдөө аж ахуй, эрчим хүч, зам, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, санхүүгийн салбарыг олон улс, Европын Холбооны стандартад нийцүүлэн хөгжүүлнэ.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 8.3-т “Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.” гэсэн зорилт, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.4.1-д “Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалтын түвшнийг сайжруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” гэж, Зорилт 4.4-т “Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж, хүнсний дотоодын хэрэгцээг ханган, экспортын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.” гэж тус тус заасан нь Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл болсон.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчилэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд болон төрийн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдох гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу зардлын тооцооллыг хийсэн болно.

Зорилго: “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдох гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын 1.4.1-т заасан хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах явцад Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, тэдгээр субьектэд ногдох зардлыг бууруулах боломжит хувилбарыг боловсруулахад энэхүү зардлын тооцооллыг хийх судалгааны зорилго оршино.

Аргачлалд заасны дагуу төрийн байгууллагын зардлыг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээнд, хуулийн этгээдийн зардлыг хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах мөнгөн зардалд, иргэнд үүсэх зардлыг иргэнд хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан зарцуулах цаг хугацаа, гарах мөнгөн зардалд тус тус үндэслэн тооцоолсон болно.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог гаргахдаа дараах нийтлэг зарчмыг баримтлав. Үүнд:

- аргачлал заасны дагуу иргэн, хуулийн этгээд болон төрийн байгууллагын зардлыг тооцох ажлыг гүйцэтгэх үе шатыг баримтлах;
- бодит тоо баримт, мэдээлэлд үндэслэх;
- хуулийн төсөлд тусгасан төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэний гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тогтоох;
- үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- хүний нөөцийн хэрэгцээг оновчтой тогтоож, гарах зардлыг урьдчилан тооцох;
- материаллаг болон бусад зардлыг урьдчилан тооцож, нэгтгэх;
- хувилбарыг нягтлах, хялбарчлах боломжийг шалгах.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлд туссан хуулийн этгээдийн хариуцан гүйцэтгэх үүрэг буюу хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан үүсэх зардлыг дараах этгээд тус бүрээр тооцохоор тодорхойлов:

- хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн байгууллага;
- хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээд;
- хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч хувь хүн буюу иргэн.

Хуулийн төслөөс төрийн байгууллага, хуулийн этгээд болон иргэний гүйцэтгэх үүргийг тодорхойлохдоо шинээр буюу өмнө нь гүйцэтгэж байгаагагүй үүрэг, мөн өмнө гүйцэтгэж байсан боловч тухайн үүргийг хуулийн төслөөр өргөжүүлсэн бол үүнтэй холбоотой гарч болох зардлын тооцоог хийхийг зорьсон.

Хуулийн төслийн зардлын тооцооллыг гаргахдаа Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл боловсруулах хүрээнд хийгдсэн хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан судалгаа, хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөлтэй нийцүүлэн боловсруулсан.

Аргачлалд заасан журмыг үндэслэн зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн төрлөөр тооцож, гаргасан зардлын тооцоолол нь дараах хэсгээс бүрдэнэ:

- I. Иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо;
- II. Төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо;

I. ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Аргачлалд заасны дагуу Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг тооцох ажлыг дараах 5 үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- Цаг хугацаа болон гарч болох давтамжийг тооцох;
- Тоон үзүүлэлт болон зардлыг тооцох;
- Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах;

1) Иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох

Энэ хэсэгт Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн зохицуулалтыг судалж, тус хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээд тодорхой үүрэг хүлээж байгаа эсэхийг тодорхойлж, иргэн, хуулийн этгээд нь ямар чиг үүрэг буюу ажил үйлчилгээг шинээр гүйцэтгэх эсхүл одоо гүйцэтгэж байгаа чиг үүрэг, ажил үйлчилгээг хуулийн төслийн дагуу өргөжсөн эсэхийг тогтоох юм.

Хуулийн төслийн зохицуулалтыг сонгохдоо хуулийн төсөлд улсын төсвөөс болон иргэн, хуулийн этгээдээс тодорхой зардал гарахыг шаардаж байгаа, эсхүл ямар нэгэн эрх, үүрэг, шинэ чиг үүрэг бий болгож байгаа, эсхүл иргэн, хуулийн этгээдэд ачаалал үүсгэж байгаа зохицуулалтуудыг сонголоо.

Тус хуулийн төслийг хэрэгжүүлэхэд хөдөө аж ахуйн дараах чиглэлийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, хуулийн этгээдэд үүсч болох зардлыг тооцох шаардлагатай гэж үзсэн. Үүнд:

- мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, хуулийн этгээд;
- тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, хуулийн этгээд;
- мал аж ахуй, тариалан хосолсон үйлдвэрлэл эрхлэгч иргэн, хуулийн этгээд.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлд дээр дурьдсан хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч иргэнд үүрэг хүлээлгэсэн дараах зохицуулалт байна.

Хүснэгт 1. Иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох нь

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт	Гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ
8.1. Түүхий эд, бүтээгдэхүүнийг эрх бүхий байгууллагаас баталсан техникийн зохицуулалт, стандарт, мал эмнэлэг, ургамлын ариун цэвэр, хорио цээрийн шаардлага (цаашид “ариун цэвэр, хорио цээрийн шаардлага” гэх), хөдөө аж ахуйн өртгийн сүлжээний дараагийн шатны хүлээн авагчтай байгуулсан гэрээний нөхцөлийн дагуу бэлтгэж, хадгална.	Холбогдох шаардлагын дагуу түүхий эд бэлтгэн нийлүүлэх гэрээг байгуулж, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах
8.2.Түүхий эд, бүтээгдэхүүнийг техникийн зохицуулалт, стандарт, ариун цэвэр, хорио цээрийн шаардлагыг хангаж, хөдөө аж ахуйн өртгийн сүлжээний дараагийн шатны хүлээн авагчтай байгуулсан гэрээний нөхцөлийн дагуу тээвэрлэнэ.	Холбогдох шаардлагын дагуу түүхий эд нийлүүлэх, тээвэрлэх гэрээг байгуулж, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах
8.3.Түүхий эд бүтээгдэхүүний анхдагч шинж чанар, технологийн онцлогоос хамааран тэдгээрийг түүхий эд хүлээн авах төв, төвлөрсөн цэг, агуулах, мал бордох аж ахуй, бөөний худалдааны төв, боловсруулах үйлдвэрт нийлүүлнэ.	Холбогдох шаардлагыг хангасан түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, борлуулах

8.4.Хөдөө аж ахуйн нэмэгдсэн өртгийн сүлжээ (цаашид “өртгийн сүлжээ” гэх)-ний оролцогч нь “нэг алхам урагш, нэг алхам хойш” зарчмыг баримтлан тухайн шатны өртгийн сүлжээнд хүлээн авсан, нийлүүлсэн түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, тоо хэмжээ, чанар, аюулгүй байдлын талаарх шаардлагатай үзүүлэлтүүдийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэгдсэн цахим системд бүртгэнэ.	Нэмэгдсэн өртгийн сүлжээнд оролцогчоор бүртгүүлж, холбогдох мэдээллийг нэгдсэн цахим системд хүргүүлэх, олон нийтэд нийтлэх
8.5.Өртгийн сүлжээний оролцогч нь өөрт хамаарах үе шат бүрт түүхий эд, бүтээгдэхүүний чанар, ариун цэвэр, хорио цээрийн шаардлага, аюулгүй байдлын баталгааг хангуулах ажлыг хариуцна.	Холбогдох шаардлагын хэрэгжилтийг хангах
8.7.Энэ хуулийн 8.6-д заасан төв, цэг, агуулах, мал бордох аж ахуй, бөөний худалдааны үйл ажиллагааг хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч, эсхүл энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг хариуцан гүйцэтгэх ба боловсруулах үйлдвэрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гэрээний үндсэн дээр гүйцэтгэж болно.	Холбогдох иргэн, хуулийн этгээд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах
8.8.Энэ хуулийн 8.6-д заасан төв, цэг, агуулах, бөөний худалдааны үйл ажиллагааг сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасагт бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээд гэрээний үндсэн дээр хэрэгжүүлнэ.	Холбогдох иргэн, хуулийн этгээд холбогдох бүртгэл, гэрээг байгуулж, тайлагнах
12.1.1.хуульд заасны дагуу хөдөө аж ахуйн газрыг зориулалтаар нь эзэмших, ашиглах	Тогтвортой хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх
12.1.2.энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан бүс нутагт эрхлэхийг зөвшөөрсөн аж ахуйн төрлөөс сонгон аж ахуйгаа хөгжүүлэх	Тогтвортой хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх
12.1.3.үйлдвэрлэлээ өргөтгөх, хөгжүүлэх, бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулах зорилгоор төсөл боловсруулж, зээл, санхүүгийн дэмжлэг авах	Тогтвортой хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай дэмжлэг авах
12.1.4.үйлдвэрлэлийн үр ашиг,бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор шинэ техник, технологи, тоног төхөөрөмжийг ашиглах, түүнтэй холбоотой сургалтад хамрагдах, зөвлөгөө авах	Тогтвортой хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай зөвлөх үйлчилгээ авах
12.1.5.үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулах	Бараа, бүтээгдэхүүнээ борлуулах
12.2.1.эзэмшиж, ашиглаж буй хөдөө аж ахуйн газрыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах, сэргээн сайжруулах	Холбогдох шаардлагын хэрэгжилтийг хангах
12.2.2.үйлдвэрлэсэн түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн баталгааг хангах	Холбогдох шаардлагын хэрэгжилтийг хангах, үр дүнг баталгаажуулах
12.2.3.өөрийн үйлдвэрлэсэн, зах зээлд нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо, хэмжээг холбогдох цахим системд мэдээлэх	Холбогдох бүртгэлийг хийж тайлагнах
13.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр төсвөөс олгох дэмжлэг, урамшуулал нь дор дурдсан шалгуурыг хангасан байна: 13.2.1.уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чиглэгдсэн дэвшилтэт технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байх; 13.2.2.бэлчээрийн болон тариалангийн газрын хөрс, үржил шимийг хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх арга	Холбогдох шаардлагын хэрэгжилтийг хангах

хэмжээнд хувийн зүгээс хөрөнгө оруулалт хийсэн байх; 13.2.3.бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийн бүтээмжээ дээшлүүлсэн байх; 13.2.4.стандартын шаардлага хангасан түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэн үндэсний үйлдвэрлэлд нийлүүлсэн байх; 13.2.5.малын чанар болон эдийн засгийн эргэлтийг сайжруулах замаар бэлчээрийн даацад малын тоог нийцүүлсэн байх; 13.2.6.бэлтгэн нийлүүлэлтийн хоршоогоор дамжуулан арьс шир, ноос, ноолуур, сүү зэрэг түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлсэн байх.	
---	--

2) Цаг хугацаа болон давтамжийг тооцох

Хүснэгт 2. Иргэн, хуулийн этгээдийн зарцуулах хугацаа, давтамжийн тооцоолол

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт	Гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ	Зарцуулах хугацаа /мин/	Давтамж
8.1. Түүхий эд, бүтээгдэхүүнийг эрх бүхий байгууллагаас баталсан техникийн зохицуулалт, стандарт, мал эмнэлэг, ургамлын ариун цэвэр, хорио цээрийн шаардлага (цаашид “ариун цэвэр, хорио цээрийн шаардлага” гэх), хөдөө аж ахуйн өртгийн сүлжээний дараагийн шатны хүлээн авагчтай байгуулсан гэрээний нөхцөлийн дагуу бэлтгэж, хадгална.	Холбогдох шаардлагын дагуу түүхий эд бэлтгэн нийлүүлэх гэрээг байгуулж, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах	60	1
8.2.Түүхий эд, бүтээгдэхүүнийг техникийн зохицуулалт, стандарт, ариун цэвэр, хорио цээрийн шаардлагыг хангаж, хөдөө аж ахуйн өртгийн сүлжээний дараагийн шатны хүлээн авагчтай байгуулсан гэрээний нөхцөлийн дагуу тээвэрлэнэ.	Холбогдох шаардлагын дагуу түүхий эд нийлүүлэх, тээвэрлэх гэрээг байгуулж, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах	60	6000
8.3.Түүхий эд бүтээгдэхүүний анхдагч шинж чанар, технологийн онцлогоос хамааран тэдгээрийг түүхий эд хүлээн авах төв, төвлөрсөн цэг, агуулах, мал бордох аж ахуй, бөөний худалдааны төв, боловсруулах үйлдвэрт нийлүүлнэ.	Холбогдох шаардлагыг хангасан түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, борлуулах	60	6000
8.4.Хөдөө аж ахуйн нэмэгдсэн өртгийн сүлжээ (цаашид “өртгийн сүлжээ” гэх)-ний оролцогч нь “нэг алхам урагш, нэг алхам хойш” зарчмыг баримтлан тухайн шатны өртгийн сүлжээнд хүлээн авсан, нийлүүлсэн түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, тоо хэмжээ, чанар, аюулгүй байдлын талаарх шаардлагатай үзүүлэлтүүдийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэгдсэн цахим системд бүртгэнэ.	Нэмэгдсэн өртгийн сүлжээнд оролцогчоор бүртгүүлж, холбогдох мэдээллийг нэгдсэн цахим системд хүргүүлэх, олон нийтэд нийтлэх	60	12

8.5.Өртгийн сүлжээний оролцогч нь өөрт хамаарах үе шат бүрт түүхий эд, бүтээгдэхүүний чанар, ариун цэвэр, хорио цээрийн шаардлага, аюулгүй байдлын баталгааг хангуулах ажлыг хариуцна.	Холбогдох шаардлагын хэрэгжилтийг хангах	60	12
8.7.Энэ хуулийн 8.6-д заасан төв, цэг, агуулах, мал бордох аж ахуй, бөөний худалдааны үйл ажиллагааг хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч, эсхүл энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг хариуцан гүйцэтгэх ба боловсруулах үйлдвэрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гэрээний үндсэн дээр гүйцэтгэж болно.	Холбогдох иргэн, хуулийн этгээд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах	60	12
8.8.Энэ хуулийн 8.6-д заасан төв, цэг, агуулах, бөөний худалдааны үйл ажиллагааг сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасагт бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээд гэрээний үндсэн дээр хэрэгжүүлнэ.	Холбогдох иргэн, хуулийн этгээд холбогдох бүртгэл, гэрээг байгуулж, тайлагнах	60	120
12.1.1.хуульд заасны дагуу хөдөө аж ахуйн газрыг зориулалтаар нь эзэмших, ашиглах	Тогтвортой хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх	60	12
12.1.2.энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан бүс нутагт эрхлэхийг зөвшөөрсөн аж ахуйн төрлөөс сонгон аж ахуйгаа хөгжүүлэх	Тогтвортой хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх	60	12
12.1.3.үйлдвэрлэлээ өргөтгөх, хөгжүүлэх, бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулах зорилгоор төсөл боловсруулж, зээл, санхүүгийн дэмжлэг авах	Тогтвортой хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай дэмжлэг авах	120	12
12.1.4.үйлдвэрлэлийн үр ашиг,бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор шинэ техник, технологи, тоног төхөөрөмжийг ашиглах, түүнтэй холбоотой сургалтад хамрагдах, зөвлөгөө авах	Тогтвортой хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай зөвлөх үйлчилгээ авах	120	4
12.1.5.үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулах	Бараа, бүтээгдэхүүнээ борлуулах	120	12
12.2.1.эзэмшиж, ашиглаж буй хөдөө аж ахуйн газрыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах, сэргээн сайжруулах	Холбогдох шаардлагын хэрэгжилтийг хангах	60	12
12.2.2.үйлдвэрлэсэн түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн баталгааг хангах	Холбогдох шаардлагын хэрэгжилтийг хангах, үр дүнг баталгаажуулах	60	12
12.2.3.өөрийн үйлдвэрлэсэн, зах зээлд нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо, хэмжээг холбогдох цахим системд мэдээлэх	Холбогдох бүртгэлийг хийж тайлагнах	60	12
13.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр төсвөөс олгох дэмжлэг, урамшуулал нь дор дурдсан шалгуурыг хангасан байна: 13.2.1.уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чиглэгдсэн дэвшилтэт технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байх;	Холбогдох шаардлагын хэрэгжилтийг хангах	120	12

13.2.2.бэлчээрийн болон тариалангийн газрын хөрс, үржил шимийг хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх арга хэмжээнд хувийн зүгээс хөрөнгө оруулалт хийсэн байх;			
13.2.3.бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийн бүтээмжээ дээшлүүлсэн байх;			
13.2.4.стандартын шаардлага хангасан түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэн үндэсний үйлдвэрлэлд нийлүүлсэн байх;			
13.2.5.малын чанар болон эдийн засгийн эргэлтийг сайжруулах замаар бэлчээрийн даацад малын тоог нийцүүлсэн байх;			
13.2.6.бэлтгэн нийлүүлэлтийн хоршоогоор дамжуулан арьс шир, ноос, ноолуур, сүү зэрэг түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлсэн байх.			

3) Тоон үзүүлэлт болон зардлыг тооцох

Хүснэгт 3. Иргэн, хуулийн этгээдийн ачаалал

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт	Гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ	Зарцуулах хугацаа /мин/	Тоон үзүүлэлт	Ачаалал /мин/
8.1. Түүхий эд, бүтээгдэхүүнийг эрх бүхий байгууллагаас баталсан техникийн зохицуулалт, стандарт, мал эмнэлэг, ургамлын ариун цэвэр, хорио цээрийн шаардлага (цаашид “ариун цэвэр, хорио цээрийн шаардлага” гэх), хөдөө аж ахуйн өртгийн сүлжээний дараагийн шатны хүлээн авагчтай байгуулсан гэрээний нөхцөлийн дагуу бэлтгэж, хадгална.	Холбогдох шаардлагын дагуу түүхий эд бэлтгэн нийлүүлэх гэрээг байгуулж, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах	60	1	60
8.2.Түүхий эд, бүтээгдэхүүнийг техникийн зохицуулалт, стандарт, ариун цэвэр, хорио цээрийн шаардлагыг хангаж, хөдөө аж ахуйн өртгийн сүлжээний дараагийн шатны хүлээн авагчтай байгуулсан гэрээний нөхцөлийн дагуу тээвэрлэнэ.	Холбогдох шаардлагын дагуу түүхий эд нийлүүлэх, тээвэрлэх гэрээг байгуулж, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах	60	6000	360000
8.3.Түүхий эд бүтээгдэхүүний анхдагч шинж чанар, технологийн онцлогоос хамааран тэдгээрийг түүхий эд хүлээн авах төв, төвлөрсөн цэг, агуулах, мал бордох аж ахуй, бөөний худалдааны төв, боловсруулах үйлдвэрт нийлүүлнэ.	Холбогдох шаардлагыг хангасан түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, борлуулах	60	6000	360000
8.4.Хөдөө аж ахуйн нэмэгдсэн өртгийн сүлжээ (цаашид “өртгийн сүлжээ” гэх)-ний оролцогч нь “нэг алхам урагш, нэг алхам хойш” зарчмыг баримтлан тухайн шатны өртгийн сүлжээнд хүлээн авсан, нийлүүлсэн түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, тоо хэмжээ, чанар,	Нэмэгдсэн өртгийн сүлжээнд оролцогчоор бүртгүүлж, холбогдох мэдээллийг	60	12	720

аюулгүй байдлын талаарх шаардлагатай үзүүлэлтүүдийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэгдсэн цахим системд бүртгэнэ.	нэгдсэн цахим системд хүргүүлэх, олон нийтэд нийтлэх			
8.5.Өртгийн сүлжээний оролцогч нь өөрт хамаарах үе шат бүрт түүхий эд, бүтээгдэхүүний чанар, ариун цэвэр, хорио цээрийн шаардлага, аюулгүй байдлын баталгааг хангуулах ажлыг хариуцна.	Холбогдох шаардлагын хэрэгжилтийг хангах	60	12	720
8.7.Энэ хуулийн 8.6-д заасан төв, цэг, агуулах, мал бордох аж ахуй, бөөний худалдааны үйл ажиллагааг хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч, эсхүл энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг хариуцан гүйцэтгэх ба боловсруулах үйлдвэрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гэрээний үндсэн дээр гүйцэтгэж болно.	Холбогдох иргэн, хуулийн этгээд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах	60	12	720
8.8.Энэ хуулийн 8.6-д заасан төв, цэг, агуулах, бөөний худалдааны үйл ажиллагааг сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасагт бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээд гэрээний үндсэн дээр хэрэгжүүлнэ.	Холбогдох иргэн, хуулийн этгээд холбогдох бүртгэл, гэрээг байгуулж, тайлагнах	60	120	7200
12.1.1.хуульд заасны дагуу хөдөө аж ахуйн газрыг зориулалтаар нь эзэмших, ашиглах	Тогтвортой хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх	60	12	720
12.1.2.энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан бүс нутагт эрхлэхийг зөвшөөрсөн аж ахуйн төрлөөс сонгон аж ахуйгаа хөгжүүлэх	Тогтвортой хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх	60	12	720
12.1.3.үйлдвэрлэлээ өргөтгөх, хөгжүүлэх, бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулах зорилгоор төсөл боловсруулж, зээл, санхүүгийн дэмжлэг авах	Тогтвортой хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай дэмжлэг авах	120	12	720
12.1.4.үйлдвэрлэлийн үр ашиг,бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор шинэ техник, технологи, тоног төхөөрөмжийг ашиглах, түүнтэй холбоотой сургалтад хамрагдах, зөвлөгөө авах	Тогтвортой хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай зөвлөл үйлчилгээ авах	120	4	480
12.1.5.үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулах	Бараа, бүтээгдэхүүнээ борлуулах	120	12	1440
12.2.1.эзэмшиж, ашиглаж буй хөдөө аж ахуйн газрыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах, сэргээн сайжруулах	Холбогдох шаардлагын хэрэгжилтийг хангах	60	12	720
12.2.2.үйлдвэрлэсэн түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн баталгааг хангах	Холбогдох шаардлагын хэрэгжилтийг хангах, үр дүнг баталгаажуулах	60	12	720

12.2.3.өөрийн үйлдвэрлэсэн, зах зээлд нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо, хэмжээг холбогдох цахим системд мэдээлэх	Холбогдох бүртгэлийг хийж тайлагнах	60	12	720
13.2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр төсвөөс олгох дэмжлэг, урамшуулал нь дор дурдсан шалгуурыг хангасан байна: 13.2.1.уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чиглэгдсэн дэвшилтэт технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байх; 13.2.2.бэлчээрийн болон тариалангийн газрын хөрс, үржил шимийг хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх арга хэмжээнд хувийн зүгээс хөрөнгө оруулалт хийсэн байх; 13.2.3.бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийн бүтээмжээ дээшлүүлсэн байх; 13.2.4.стандартын шаардлага хангасан түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэн үндэсний үйлдвэрлэлд нийлүүлсэн байх; 13.2.5.малын чанар болон эдийн засгийн эргэлтийг сайжруулах замаар бэлчээрийн даацад малын тоог нийцүүлсэн байх; 13.2.6.бэлтгэн нийлүүлэлтийн хоршоогоор дамжуулан арьс шир, ноос, ноолуур, сүү зэрэг түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлсэн байх.	Холбогдох шаардлагын хэрэгжилтийг хангах	120	12	1440

4) Нийт дүнг тооцож гаргах

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчийн хувьд хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан бүртгэлтэй холбоотой зардлыг гаргах үүрэгтэй бөгөөд энэхүү үүрэгтэй холбоотой мэдээллийг тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлэх 1 ажилтантай байх тохиолдолд уг ажилтны тоогоор зардал нэмэгдэж гарахаар байна. Ажилтны цалинг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн дундаж доод цалингийн хэмжээ буюу сард 1,000,000 төгрөг гэж тооцоход жилд 12 000 000 төгрөгийн зардал гарах, бусад үйл ажиллагаанд нэмэлт зардал гарахааргүй байна. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээд нь энэ чиг үүргийг одоо байгаа хүний нөөцийн хүрээнд ачааллыг тэнцүүлэн хуваарилах тохиолдолд энэ нэмэлт зардал гарахгүй.

Хуулийн этгээдэд үүсэх нийт зардлын дүнг тооцоход нэг ажилтны ажиллах нөхцөлөөр хангахад зарцуулж буй зардал буюу ажлын байр, өрөө тасалгаа, техник хэрэгсэл, халаалт, цэвэр, бохир ус, цахилгаан, урсгал засвар зэрэг урсгал зардлыг гаргахад хүндрэлтэй байсан тул материаллаг зардлыг нарийвчлан тооцох боломжгүй байсан тул жишиг зардлаар тооцсон. Хууль тогтоомжийн зохицуулалтад

хамааралтай хуулийн этгээдийн үйл ажиллагаанд нэмэлт ачаалал үүсгэж болзошгүй зардлыг бусад зардлын ангилалд оруулж тооцоог хийлээ. Тус хуулийн төслийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээдээс дараах буюу нийт 500.000 төгрөгийн зардал гарах магадлалтай гэж үзэв.

Бусад зардлын тооцоо

Зардлын нэр	Зардлын хэмжээ, төгрөг
Гарал үүсэл, чанарын баталгаажуулалтыг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх зардал	500,000.0
Нийт дүн	500,000.0

Нийт зардлын тооцоо

Зардлын төрөл	Нийт зардал, төгрөг
Хүний нөөцийн зардал	12,000,000
Материаллаг зардал	31,041,840.3
Бусад зардал	500,000.0
НИЙТ ДҮН	43,541,840.3

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээдээс **43,541,840.3** төгрөгийн зардал гарахаар байна. Гэхдээ хөдөө аж ахуйн салбарт мөрдөгдөж буй бусад хууль, тогтоомжоор зохицуулсан харилцаа нь хэвээр байгаа тул Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлд хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан чиг үүрэг, үйл ажиллагаанаас үүдэлтэйгээр хуулийн этгээдэд зардлын нэмэлт нь ачаалал, нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзэв.

5) Хялбарчлах боломжийг шалгах.

Энэ үе шатанд зардлын хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгахдаа хуулийн этгээдийн зардлыг багасгах боломж бий эсэх, эдийн засагт дарамт багатай зохицуулах өөр хувилбар, боломж байгаа эсэх, ачаалал бууруулах боломжтой эсэхийг авч үзсэн. Хуулийн төсөлд заасан хуулийн этгээдэд холбогдох үйл ажиллагааг дээрх байгууллагууд одоо байгаа хүний нөөцөөр гүйцэтгэх боломжтой гэж үзсэн тул энэ харилцаанд хамаарах нэмэлт зардал гарахгүй гэж үзлээ. Хялбарчлах боломжийг шалгахдаа өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах, дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг дараах асуулгаар тодруулж, тодотгов.

Хүснэгт Зардлыг бууруулах, ачааллыг багасгах боломжийг шалгасан асуулга

	Асуулга	Тайлбар
1.	Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор салбарт үйл ажиллагаа явуулах этгээдийг тодорхойлох, бүртгэлд хамруулах, шаардлагатай мэдээллийг нэгтгэн мэдээллийн нэг санд төвлөрүүлэх зорилгоор хэрэгжүүлэх тул хуулийн төсөлд тусгасан хувь хүн, хуулийн этгээдийн тоог багасгах шаардлага байхгүй гэж үзэж байна.
2.	Бүртгэл, мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;	Мэдээллийг ирүүлснээр дэмжлэгийн зорилт хэрэгжих тул давтамжийг багасгах шаардлагагүй гэж үзлээ.
3.	Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор уг салбарын үйл ажиллагааг нарийвчлан бүртгэх, дэмжлэгийг тооцох шаардлагатай боловч нөгөө талаас хувь хүн, хуулийн этгээдийн болон тухайн бизнесийн нууцтай холбоотой “эмзэг” мэдээллийг тайлагнах нь эрсдэл үүсгэх эсэхэд анхаарах шаардлагатай.

4.	Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх;	Энэ хуулийн төсөл нь хөдөө аж ахуйн тухай хууль байхаар байгаа тул шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэх бүрэн боломжтой.
5.	Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;	Мэдээллийг цахимаар хүргүүлэх бүрэн боломжтой.
6.	Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх;	Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах шаардлага байхгүй гэж үзэж байна.
7.	Нэг цэгийн үйлчилгээ бий болгох боломжтой эсэх	Мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарын мэдээллийг нэгтгэн, дэмжлэгийг хэрэгжүүлэх боломж улам нэмэгдүүлэх.

II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлд туссан төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг тооцоохдоо тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардлагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг аргачлалд заасны дагуу дараах үе шатны хүрээнд боловсрууллаа. Үүнд:

1. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох
3. Гарах зардлыг урьдчилан тооцох
4. Зардлыг нэгтгэн тооцох
5. Хувилбарыг шалгаж, үр дүнг танилцуулах

1) Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох

Энэ хэсэгт хуулийн төслийн зохицуулалтаар тодорхой үүрэг хүлээж буй байгууллага байгаа эсэхийг тодорхойлж, уг байгууллага нь ямар чиг үүрэг буюу ажил үйлчилгээ шинээр гүйцэтгэх, эсхүл одоо гүйцэтгэж байгаа чиг үүрэг, ажил үйлчилгээ хуулийн төслийн дагуу өргөжиж байгаа эсэхийг хуулийн төслөөс тогтоосон.

Хууль тогтоомжийн төсөлтэй холбогдуулан гаргахад төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг аргачлал заасны дагуу зардлын тооцоо хийхэд оруулаагүй болно. Хуулийн төслийн зохицуулалтыг сонгохдоо хуулийн төсөлд улсын төсвөөс болон иргэн, хуулийн этгээдээс тодорхой зардал гарахыг шаардаж байгаа, эсхүл ямар нэгэн эрх, үүрэг, шинэ чиг үүрэг бий болгож байгаа, эсхүл иргэн, хуулийн этгээдэд ачаалал үүсгэж байгаа зохицуулалтуудыг сонгосон.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлд тусгасан төрийн байгууллагын хариуцах чиг үүргийг дараах байгууллагууд гүйцэтгэж, хэрэгжүүлэхээр байна.

- Засгийн газар;
- Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн байгууллага;
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд чиглэсэн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит үйлдвэрийн газар, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага;
- бусад мэргэжлийн ажил, үйлчилгээ хариуцсан төрийн үйлчилгээний байгууллага;

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал;
- Аймаг, нийслэл дэх хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;
- Сум, дүүрэг дэх хөдөө аж ахуйн болон мал эмнэлгийн асуудал хариуцсан төрийн байгууллагын бүтцийн нэгж.

Хуулийн төсөлд төрийн байгууллагууд нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хангах, дэмжих, бүртгэх, төрийн хяналт тавих үйл ажиллагаанд өргөн хүрээтэй чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгагдсан байна. Иймд хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг буюу үйл ажиллагааг түүвэрлэж, хэмжих боломжтой ажлыг хамааруулахаар авсан.

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт	Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ
7.3.Хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан хөдөө аж ахуйн төрөлжсөн үйлдвэрлэлийн бүсийн хилийн заагийг тухайн бүс нутгийг хамарч байгаа аймгуудын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.	Засгийн газар	Орон нутгийн саналыг хүлээн авах, шийдвэрийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх
7.4.Тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаас гадна хөдөө аж ахуйг бүс нутаг тогтоон, төрөлжүүлэн хөгжүүлэх талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ: 7.4.1.мал, амьтан, таримал ургамлын эрүүл ахуй, экосистемийн ээлтэй орон зайг бий болгох нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах, уялдааг хангах; 7.4.2.дэд бүтцийг сайжруулах; 7.4.3.хөдөө аж ахуйн эрчимжсэн, өрхийн арилжааны аж ахуй эрхлэгчийн хорших, хамтран ажиллахыг дэмжих; 7.4.4.өрхийн арилжааны аж ахуйг эрсдэлд суурилсан төлөвлөлттэй болгох; 7.4.5.өрхийн арилжааны аж ахуйн үйлдвэрлэсэн түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтыг захиалгат, зорилтот зах зээлтэй холбох зохицуулалт хийх, зах зээлийн тогтолцоонд нийцүүлэн шинэчлэн өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; 7.4.6.хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчийн эдийн засгийн чадамж, бүтээмж, үр ашгийг сайжруулах, өртгийн сүлжээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Аймаг, сумын Засаг дарга	Бодлого, тэргүүлэх чиглэл, бүс нутгийн асуудлаар холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах, эрх зүйгээр баталгаажуулах, хэрэгжүүлэх
8.9.Энэ хуулийн 8.8-д заасан иргэн, хуулийн этгээдийг бүртгэх, гэрээ байгуулах журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Журмын төсөл боловсруулах, батлах
8.12.Түүхий эд, бүтээгдэхүүний өртгийн сүлжээнд блокчейн технологийг өгөгдлийн дүн шинжилгээний програмтай хослуулан нэвтрүүлэх ажлыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны	Бүтцийн нэгжийн чиг үүрэгт ажлыг гүйцэтгэх

	төв байгууллага	
8.10.Түүхий эд бэлтгэлийн төв, цэг, агуулахыг хариуцан ажиллах этгээдтэй сум, дүүргийн Засаг дарга гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд тухайн орон нутгийн хөдөө аж ахуйн тасаг хяналт тавина.	Сум, дүүргийн засаг дарга	Гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих
8.11.Түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн үе шатуудад ажиллах мэргэжлийн боловсон хүчин, ажилтныг бэлтгэх, сургах, чадавхижуулах арга хэмжээг орон нутгийн удирдлага хариуцна.	Сум, дүүргийн засаг дарга	Стратеги, бодлогын төсөл боловсруулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах
9.1.Тогтвортой хөдөө аж ахуйн хөгжлийн зорилтыг хангах зорилгоор улсын хэмжээнд дунд хугацааны бодлого, аймаг, нийслэл, сум, дүүрэг дунд хугацааны төлөвлөгөөтэй байна.	Засгийн газар, тухайн шатны Засаг дарга	Улсын бодлогод нийцүүлэн бодлого, төлөвлөгөөний төсөл боловсруулах, батлах
9.5.Аймаг, сумын тогтвортой хөдөө аж ахуйн хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн шатны Засаг дарга хариуцан зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу тайлагнана.	Тухайн шатны Засаг дарга	Дүн шинжилгээ хийх, үр дүнг дүгнэх, хариу арга хэмжээ авах
10.1. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь салбарын хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Стратеги, төлөвлөгөөний төсөл боловсруулах, батлах, хэрэгжүүлэх
10.3.Тогтвортой хөдөө аж ахуйн зорилтыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой мэргэжлээр их, дээд сургууль, мэргэжлийн боловсролын байгууллагад шинээр анги нээх, гадаад оронд сургаж бэлтгэх ажлыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулна.	Хөдөө аж ахуй болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран	Хамтын ажиллагааг уялдуулах, хамтарсан төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх
10.4.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь албан боловсрол эзэмшсэн хөдөө аж ахуйн ажилтан, мэргэжилтнийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран 5 жил тутам мэргэжил дээшлүүлэх сургалтад системтэйгээр хамруулах ба мэргэжлийн ур чадварын түвшнээр үнэлж, мэргэшлийн зэрэг олгоно.	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Дүн шинжилгээ хийх, үр дүнг дүгнэх, хариу арга хэмжээ авах
11.2.Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлд учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээг ердийн нөхцөлд 5 жил тутам, аль нэг эрсдэлт нөхцөл байдал үүссэн болон үүсэх магадлал өндөрссөн үед Засгийн газрын шийдвэрээр тухай бүр хийнэ.	Засгийн газар	Дүн шинжилгээ хийх, үр дүнг дүгнэх, Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл гаргах
11.3.Энэ хуулийн 11.2-т заасан эрсдэлийн үнэлгээг эрсдэл үүсгэгч аюул болон хүчин зүйлсийн чиглэлээр мэргэшсэн, хараат бус судлаач, шинжээчдээс бүрдсэн эрсдэлийн үнэлгээний баг гүйцэтгэнэ.	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Судалгаа, сургалтын хүрээнд хамтын ажиллагааг нэмэгдүүлэх
11.6.Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлд учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээ хийх зардлыг Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлнэ.	Засгийн газар	Эрсдлийг бууруулах арга хэмжээ авах

14.2.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний төрөл тус бүрээр ангилал, зэрэглэлийн стандартын төсөл боловсруулах, эрх бүхий байгууллагаар батлуулах, батлагдсан стандартын хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, үр дүнг дүгнэх, шаардлагатай хариу арга хэмжээг авах
14.3.Аймаг бүр хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг шинжлэн судалдаг зориулалтын тоног төхөөрөмж, мэргэшсэн шинжээч бүхий лабораторитай байна.	Аймаг дахь хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	Холбогдох тооцооллыг хийж, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх
15.5.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран салбарын их сургууль болон эрдэм шинжилгээний хүрээлэн, судалгааны төвүүдийг туршилт, судалгааны орчин үеийн техник, хэрэгсэл, лабораторийн тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлж ажиллана.	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх
15.6.Малчин, тариаланчид шинэ мэдлэг, инновац, технологи эзэмшүүлэхэд чиглэгдсэн зөвлөн туслах тогтвортой үйлчилгээг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага салбарын сургалт, эрдэм шинжилгээний байгууллага болон хувийн хэвшлийн хуулийн этгээдтэй хамтран зохион байгуулна.	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх
17.3.2.гадаад улс, олон улсын байгууллагатай байгуулсан мал эмнэлэг, ургамлын ариун цэвэр, хорио цээрийн гэрээ, хэлэлцээрийн цахим сан үүсгэж, олон нийтэд нээлттэй хүргэх боломжоор хангах.	Засгийн газар, холбогдох төрийн байгууллага	Мэдээллийн цахим санг хөгжүүлэх
19.1.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим сантай байна.	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, Бүтцийн нэгжийн чиг үүрэгт ажлыг гүйцэтгэх
18.4.Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн хүрээнд дараах тодорхой чиг үүргийг хэрэгжүүлнэ: 18.4.1.тогтвортой хөдөө аж ахуйн хөгжлийн тэргүүлэх чиглэл, төрөлжилт, бүсчлэл, кластерыг тодорхойлж, бодлого, төлөвлөгөөнд тусгах, хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах; 18.4.2.энэ хуулийн хэрэгжилтэд хоёр жил тутам аудит хийлгэж, түүний дүгнэлт, саналын дагуу хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авах;	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, Бүтцийн нэгжийн чиг үүрэгт ажлыг гүйцэтгэх, дүн шинжилгээ хийх, хяналт тавих
18.5.Хөдөө аж ахуйн кластер байгуулах, хөгжүүлэх талаар төрийн захиргааны төв, орон нутгийн захиргааны байгууллага дараах үйл ажиллагаа явуулна: 18.5.1.кластер байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг судлах, боловсруулахад дэмжлэг үзүүлэх, үйлдвэрлэл эрхлэгчид сурталчлах;	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн	Хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, бүтцийн нэгжийн чиг үүрэгт ажлыг гүйцэтгэх

18.5.2.хөдөө аж ахуйн кластер үүсгэн хөгжүүлэх чиглэлээр үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулсан судалгаа явуулах, дүнг мэдээлэх; 18.5.3.кластер байгуулахад оролцогч талуудын хамтын ажиллагааны чиглэл, зураглалыг гаргах, үйлчилгээний дэд бүтцийг бий болгох, үйл ажиллагааг дэмжих арга замыг тодорхойлох; 18.5.4.кластер үүсгэн байгуулах ажлыг манлайлан зохион байгуулах, кластерийн төлөвлөгөө боловсруулах чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгөх, төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж, удирдахад дэмжлэг үзүүлэх; 18.5.5.гадаад, дотоодод туршлага судлах, үндэсний болон гадаад зөвлөхийн үйлчилгээ авахад туслах; 18.5.6.кластер байгуулах чиглэлээр сургалт явуулах, зөвлөгөө өгөх; 18.5.7.кластерийг дэмжих нэгжийг үүсгэн байгуулж ажиллуулах; 18.5.8.хөдөө аж ахуйн кластерийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэх; 18.5.9.хөдөө аж ахуйн кластерийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад байнгын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.	захиргааны байгууллага	
18.7.Хөдөө аж ахуйг хөгжүүлэх мэргэжлийн Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Журмын төсөл боловсруулах, батлах, хэрэгжүүлэх
19.4.Хөдөө аж ахуйн нэгдсэн цахим санг бүрдүүлэх, хөтлөх, мэдээллийн дүн шинжилгээ хийх, их өгөгдөл боловсруулах, мэдээлэл дамжуулах, хадгалах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна.	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Журмын төсөл боловсруулах, батлах, хэрэгжүүлэх

2) Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Хуулийн төсөлд тусгасан төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулах хугацааг тооцохдоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасны дагуу захиргааны хэм хэмжээний акт боловсруулан батлаж байгаа хугацааг жишиг болгон дээр дурдсан чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүнд зарцуулах хугацааг тооцлоо.

Хүснэгт 4. Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын зардалд нөлөөлөх зүйл заалт

Төрийн байгууллага	Хэрэгжүүлэх чиг үүрэг (хуулийн төсөлд хамаарах зүйл)	Хийгдэх ажиллагаа (хамаарах хэсэг, заалт)	Тохиолдол тоогоор /өдрөөр жилд хийх давтамж/	зарцуулах хугацаа /минут/	нийт зарцуулах хугацаа /минут/
Хөдөө аж ахуйн асуудал	Хуулийн төслийн 8 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	8.9.	15	180	2700
		8.12.	15	180	2700
		10.1.	15	180	2700

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Хуулийн төслийн 10 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	10.3.	15	180	2700
		10.4.	10	180	1800
	Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	11.3.	15	60	900
	Хуулийн төслийн 14 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	14.2.	10	120	1200
	Хуулийн төслийн 15 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	15.5.	120	100	12000
		15.6.	12	60	720
	Хуулийн төслийн 17 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	17.3.2.	12	180	2160
	Хуулийн төслийн 18 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	18.4.	5	60	300
		18.4.1.	12	60	720
		18.4.2.	12	120	1440
		18.7	12	60	720
	Хуулийн төслийн 19 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	19.1.	12	180	2160
19.4.		120	60	7200	
Аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	Хуулийн төслийн 7 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	7.4.1.	220	60	13200
		7.4.2.	220	60	13200
		7.4.3.	60	60	3600
		7.4.4.	60	60	3600
		7.4.5.	12	120	1440
		7.4.6.	12	120	1440
	Хуулийн төслийн 14, 18 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	14.3.	30	480	14400
		18.5.1.	12	120	1440
		18.5.2.	12	60	720
		18.5.3.	12	60	720
		18.5.4.	12	120	1440
		18.5.5.	12	120	1440
		18.5.6.	12	180	2160
		18.5.7.	10	480	4800
	18.5.8.	12	60	720	
	Сум, дүүргийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан тасаг	Хуулийн төслийн 8 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	8.10.	12	120
8.11.			12	180	2160
Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх		9.1.	12	120	1440
		9.5.	10	60	600
Нийт хугацаа				112080 минут	

Тодорхой чиг үүрэг хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгасан төрийн байгууллагуудын зүгээс нийт 112080 минут буюу 1868 цаг зарцуулахаар байгаа ч хуулийн төсөлд туссан шинэ чиг үүргийг хариуцах төрийн захиргааны төв болон

төрийн захиргааны байгууллага нь тухайн чиг үүргийг одоо байгаа хүний нөөцийн ачааллыг оновчтой хуваарилан зохицуулах замаар гүйцэтгэх боломжтой бөгөөд хүний нөөцийн хангамж, хүртээмж хангалтгүй тохиолдолд шинээр 2 ажилтан авч ажиллуулах эсэхийг байгууллагын хүрээнд шийдвэрлэх боломжтой асуудал гэж үзэж байна.

3). Гарах зардлыг урьдчилан тооцох

Аргачлалын 4.2-д заасны дагуу тус үе шатны тооцоог хийхдээ хуулийн зохицуулалтад хамааралтай гэж тодорхойлсон төрийн байгууллагуудын үйл ажиллагаа хоорондын уялдааг хангахыг зорьсон. Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн захиргааны байгууллагад гарах зардлын урьдчилан тооцоог дараах байдлаар хийлээ. Үүнд:

- 1. Хүний нөөцийн зардал (төрийн албан хаагчтай холбоотой шууд болон шууд бусаар үүсэх зардал)
- 2. Материаллаг зардал (төрийн албан хаагчийн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардал)
- 3. Бусад зардал (тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардал)

3.1. Хүний нөөцийн зардал:

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг Тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцсоноор тооцов.

Хүний нөөцийн зардлыг тооцохдоо тухайн ажил үйлчилгээ буюу үүргийг гүйцэтгэх төрийн захиргааны байгууллагын албан хаагчид зарцуулах цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал зэрэг төрөөс хариуцдаг бүх зардлыг нэгтгэж, тэдгээрийн дундаж хэмжээгээр тооцов.

Тус хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалтан нь албан тушаалын ТЗ-6, ТЗ-7, ТЗ-8 зэрэглэлийн аль нэгд хамаарахаар байгаа тул Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор баталсан төрийн албаны зарим аобан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг үндэслэн цалингийн зардлын тооцоог гаргав.

Төрийн захиргааны байгууллагын үүрэг хүлээсэн албан хаагчийн цалингийн зардал

Албан тушаалын зэрэглэл	ТЗ-6	ТЗ-7	ТЗ-8
Төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ	1,933,000	1,757,000	1,597,000
Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ	1,597,000	1,452,000	1,320,000

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын 2, 3 дугаар хавсралт

Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж ¹	160.000
	Тавилга, эд хогшил ²	100.000
	Барилга, байгууламж ³	65.670
	Нийт	325.670
Дүн		1.952.317

Эх сурвалж: Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 4, 5-д заасны дагуу нэг албан хаагчийн “ажлын байрны дундаж материаллаг зардал”-аар тооцоход нэг төрийн албан хаагчид гарах материаллаг зардлын хэмжээ дунджаар 1.952.317 /нэг сая есөн зуун тавин хоёр мянга гурван зуун арван долоо/ төгрөг, нийт албан хаагчид 3,904.634.0 төгрөг болж байна.

3.3.3. Бусад зардал:

Аргачлалын 4.2-т заасны дагуу хууль тогтоомжийн зохицуулалтад хамааралтай төрийн байгууллагын үйл ажиллагааны хоорондын уялдаа холбоог ханган ажиллана гэж үзээд зөвхөн төсөвт нэмэлт ачаалал үүсгэж болзошгүй зардлыг бусад зардлын ангилалд оруулж тооцоог хийлээ.

Тус хуулийн төслийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагаас дараах буюу нийт 250.000.000 төгрөгийн зардал гарах магадлалтай гэж үзэв.

Бусад зардлын тооцоо

Зардлын нэр	Зардлын хэмжээ, төгрөг
Хөдөө аж ахуйн нэгдсэн цахим мэдээллийн систем, цахим хуудсыг хөгжүүлэх, дэд системийн холболтыг хийх, хэвийн үйл ажиллагааг хангах	250.000.000
Нийт дүн	250.000.000

Хөдөө аж ахуйн тухай хуулийн зарим заалтыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны бүртгэлийг цахим горимд шилжүүлэх шаардлагатай. Иймд одоогийн системийн үйл ажиллагааны хөгжүүлэлтийн програм хангамжид зах зээлийн дундаж үнээр 150,0 сая төгрөг, бусад техник хэрэгсэл авахад 100,0 сая төгрөг, нийт 250,0 сая төгрөг шаардагдана гэж тооцлоо.

3.4. Зардлын нэгтгэл

Энд хүний нөөцийн зардал, материаллаг зардал, бусад зардлын нийлбэрээр нийт зардлын дүнг тооцон гаргав. Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны байгууллагад үүсэх нийт зардлын дүнг хүний нөөцийн зардал, материаллаг зардал, бусад зардлын нийлбэрээр тооцов.

¹Нэг албан хаагчид хэрэглэгдэж буй техник, тоног төхөөрөмжийн үнийг дунджаар 800,000 төгрөгөөр тооцож, түүний элэгдэл хорогдлын хэмжээг ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолоор баталсан “Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол тооцох журам, Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлыг тооцоход баримтлах хугацаа”-нд тусгаснаар 20%-иар тооцов.

²“Тавилга, эд хогшлын үнийг дунджаар 1,000,000 төгрөгөөр тооцож, түүний элэгдэл, хорогдлыг ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад тусгаснаар 10%-иар тооцов.

³2013 онд ХЗДХЯ-наас хийсэн “Хөдлөх эд хөрөнгийн болон түүнтэй холбоотой эрхийн барьцааны тухай хуулийн төслийн үр нөлөөг тооцох судалгааны тайлан”-д дурьдсан мэдээллийг ашиглав.

Нийт зардлын тооцоо

Зардлын төрөл	Нийт зардал, төгрөг
Хүний нөөцийн зардал	59,687,400.0
Материаллаг зардал	3,904,634.0
Бусад зардал	250,000,000.0
НИЙТ ДҮН	313,592,034.0

3.5.Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгасан үр дүн

Энэ үе шатанд зардлын хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгахдаа төсвийн зардлыг багасгах боломж бий эсэх, эдийн засагт дарамт багатай зохицуулах өөр хувилбар, боломж байгаа эсэх, ачаалал бууруулах боломжтой эсэхийг авч үзсэн. Хуулийн төсөлд заасан төрийн байгууллагад холбогдох үйл ажиллагааг дээрх байгууллагууд одоо байгаа хүний нөөцөөр гүйцэтгэх боломжтой гэж үзсэн тул энэ харилцаанд хамаарах нэмэлт зардал гарахгүй гэж үзлээ.

ДҮГНЭЛТ

Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог урьдчилсан байдлаар хийв. Тус хуулийн төсөл дэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад зардал үүсгэхэд нөлөөлөх зүйл, заалтыг бүхэлд нь авч үзэн хуулийн зохицуулалтын улмаас үүсэх ачаалал, зардлыг стандарт загвараар тооцоолж гаргав.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг баталж хэрэгжүүлэхэд шинээр 2 төрийн захиргааны орон тоо бий болгохоор тооцоолол гарч байна. Иймд тус хуулийн төсөлд туссан төрийн байгууллага нь хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нэмэлт зардал төрийн байгууллагад үүсэхгүй гэж үзэж байна.

Энэхүү хуулийн төслийн хэрэгжүүлэхэд үүсэх зардлын урьдчилсан тооцоогоор иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагаас тус хуулийг хэрэгжүүлэхэд нийт 313.6 сая төгрөгийн зардал гарах төлөвтэй гэж дүгнэж болохоор байна. Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагуудад үүсч болох зардал нь улсын төсөвт ачаалал бараг үүсгэхгүй хуулийн үр өгөөжтэй харьцуулахад үүсэх зардлын нөлөөлөл үлэмж бага байна гэж үзлээ. Түүнчлэн Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлд хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан чиг үүрэг, үйл ажиллагаанаас үүдэлтэйгээр иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад зардлын нэмэлт нь ачаалал, нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзэж байгаагийн үндэслэл нь хөдөө аж ахуйн салбарт мөрдөгдөж байгаа бусад хууль, тогтоомжоор зохицуулсан харилцаа хэвээр байгаа бөгөөд энэхүү хуулийн төсөл нь суурь харилцааг зохицуулсан ерөнхий хуулийн төсөл юм.

Хуулийн төслийн хүрээнд иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагаас гарах зардал нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хангах, дэмжих, эрсдлийг удирдах, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх үйл ажиллагааны цар хүрээг тодорхой болгох, хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлого, төлөвлөлтийг сайжруулах, салбарыг дэмжих, түүнээс бий болох орлого, үр өгөөж, эдийн засгийн хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцааны үр өгөөжийг хангах ач холбогдолтой байх нь зардлын тооцооны судалгааг хийх явцад ажиглагдав.

Харин хуулийн төсөлд улс, аймаг, нийслэл, сум, дүүрэг нь тогтвортой хөдөө аж ахуйн хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй байх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой байдалд нөлөөлөх эрсдлийг үнэлж, эрсдэл ба чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх, сум бүрт хөдөө аж ахуйн түүхий эд бэлтгэлийн төв, төвлөрсөн цэгийг шинэчлэх, шинээр байгуулах, хөдөө аж ахуйг хөгжүүлэх бүс нутгийг тогтоох, тус бүсэд боловсруулах үйлдвэрийн цогцолбор байгуулж болох зэрэг зарчмын шинжтэй хэд хэдэн зохицуулалт оруулахаар тусгасан байгаа тул энэ чиглэлийн техник эдийн засгийн үндэслэл, төсөв, зардлын тооцоог нарийвчлан гаргах зөвлөмжийг өгч байна. Ялангуяа сум бүрийн хөдөө аж ахуйн түүхий эд бэлтгэлийн төв, төвлөрсөн цэгийн техник, тоног төхөөрөмж барилга байгууламжийн хөрөнгө оруулалтыг улсын төсөвт тусгаж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн төвийг зах зээлийн таталцалын байршилтай нь уялдуулан эрэмбэлэх, нэг төвийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг нэг жилд бүхлээр нь шийдвэрлэх замаар бүх бүх суманд байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлэх шаардлагатай байна. Үүнийг улсын болон орон нутгийн төсөв, түншлэгч байгууллагууд, хувийн хэвшлийн хамтын хөрөнгө оруулалтаар бодлогын түвшинд шийдвэрлэх нь зүйтэй юм.

---o0o---



УИХ-ын гишүүн
Мэндбаярын МАНДХАЙ

Боловсруулж буй

Өргөн баригдсан

Хэлэлцэх эсэх

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 ОНЫ 4-Р САРЫН 15 ӨДӨР

УЛААНБААТАР

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТУХАЙ



✓ Дагах

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хөдөө аж
ахуйн талаар төрөөс баримтлах
бодлогын суурь зарчмуудыг тодорхойлж,
бүсчлэл, төрөлжилт, тогтвортой хөгжил,



d.parliament.mn



ХӨДӨӨ АЖ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГАСАН БОЛОН ТУСГААГҮЙ САНАЛЫН ТОВЬЁГ

2025.06.10.

УБ хот

Нэр	Санал	Санал тусгасан эсэх
УИХ-ын гишүүн Батгэрлэнэ:	1. Хүлэмжийн хийтэй холбоотой асуудлуудыг оруулах, карбон кредитийн асуудлыг оруулах;	Тусгасан
	2. Тогтвортой ХАА-г хөгжүүлэхдээ бизнес эрхлэгчдийг дэмжихэд чиглэсэн эрх зүйн орчны өөрчлөлтийг оруулахад чиглэх;	Тусгаагүй
	3. Оюутан сургах сургах, хүний нөөцтэй холбоотой асуудлыг хуульд заавал оруулаад байх шаардлагагүй;	Тусгаагүй
	4. Арьс шир, түүний үнэ, экспорт, өртөг, бэлчээр, хоршоотой холбоотой асуудлууд орон нутагт олон байна. /Тухайлбал, Хөвсгөл аймгийн Улаануул сум дээр жишээлбэл нэхийний жижигхэн цех байгуулах гэтэл хоршооны зээл олгоно гэсэн, гэтэл хоршооны зээл авахын тулд 9 хүний бүрэлдэхүүнтэй байх хэрэгтэй болсон./ Тэгэхээр энэ ХАА-н тухай хуулиар энэ дэмжлэгийг тодорхой болгох хэрэгтэй байна.	Тусгасан
	1. Шилжих хөдөлгөөн, эрүүл махны асуудал ярихын тулд отор нүүдэл, бэлчээрийн зохицуулалтыг гарцаагүй хуульчлах шаардлагагүй. Тариалан бэлчээрийн асуудал, отрыг ЗГ-ын тогтоолоор шийдвэрлэж байгаа учраас үүнийгээ хуульчлах ёстой. Огор нүүдлийн болзол бэлчээрийн асуудлуудыг Монгол улсын ХААЯ хариуцаж хийх ёстой. Энэ ХАА-н хуульд малын эрүүл мэнд, МАА-н бэлчээрийн бодлогыг тусгайлан чиг үүрэг хуулиар зохицуулна гэсэн өгүүлбэр оруулж өгөх;	Тусгасан, өөр хуулиар зохицуулахаар томъёолол шинээр хийсэн.
ХХААҮЯ-ны харьяа Аймаг дундын отрын бүсийн ашиглалтын захиргааны дарга Д.Түмэндэмбэрэл:	2. Хуулиар зохицуулж, оторт заавал гаргадаг болох ёстой. Зуслан, намаржаа, өвөлжөөнд хуулиар зааж, заавал буулгадаг болгох.	Тусгаагүй
	3. Өвөлжөө, хаваржааны хашаа хороогоо хуулиар барьдаг байх хэрэгтэй. Өвөлжөөндөө саравчтай хашаа дагжуур газраа бэлчээртээ чулуун хороо барьдаг, шуурвал чулуун хороондоо хийдэг. Энэ уламжлалыг бид хуульчилж өгөх ёстой.	Тусгаагүй
	4. Ургамлын бүрхэвчийн асуудлыг хуулиар зохицуулах. Олон төрлийн эмийн ургамал ургадаг боловч ургахаа байчихсан нь бэлчээрийн талхалт, саяын шилжих хөдөлгөөн, бэлчээр чөлөөлөх отор нүүдлийн бодлого, уур уурхай газар, мал аж ахуй, тариалангийн газрын зөрчилтэй холбоотой.	Хуулийн эрсдэл хэсэгт оруулсан
	5. Уур уурхайн асуудал малчдын хооронд бөөн зөрчил байдаг. Хэрвээ уур уурхай бэлчээрт хийх гэж байгаа бол малчдаас асуудаг байх, малчинд нөхөн олговор өгдөг байх зохицуулалт хэрэгтэй байна.	Тусгасан

Глобал сивик шэйринг ОУБ-ын төлөөлөл Батдорж:	6. Малын даатгалыг хийдэг байх, түүнийг зориулалтыг хуульчлах. Тухайлбал, малын ЭМД-ын хууль гэдгийг батлах. Өргөн барьсан 60%-ийг нь эрүүл мэнддээ зарцуулбал 40%-ийг нь бэлчээрийн менежменттэй мал байвал мал эрүүл байна, даатгалаа төлсөн малчин сайн малын эмчээс үйлчилгээ авна.	Тусгаагүй
	1. Малчдын үүрэг, хариуцлагын талаар хуульд тодорхой зааж өгөх; Малчид маань нэлээд үүрэг хариуцлагаа ойлгохгүй байгаагаас болоод ХАА, МАА-н үйлдвэрлэлийн анхан шатанд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанар, гарцын асуудалд анхаарах.	Тусгаагүй
	2. ХАА-д чиглэсэн салбарын хөгжлийн мастер төлөвлөгөөтэй байх талаар хуульчилж өгөх. Орон нутаг, засаг захиргааны нэгж мастер төлөвлөгөөтэй байхаар заавал хуулиар батлах, үүрэгжүүлээд өгчихвөл олон хууль тогтоомжууд хөрсөн дээрээ ажиллах боломжтой болно.	Тусгаагүй
	3. Сургалт хөгжлийн тухай 15.6-д малчин тариаланчид шинэ мэдлэг, инновац, технологи эзэмшүүлэхэд оролцох байгууллагад зөвхөн салбарын ХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбарын сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн хуулийн этгээд гээд заачихсан байгаа. Энэ дээр иргэний нийгмийн байгууллагын тухай нэг ч зүйл алга. Тэгэхлээр энэ иргэний нийгмийн байгууллага энэ салбарт ажиллаж байгаа, иргэний байгууллага, насан туршийн боловсролын байгууллагуудыг хуульдаа оруулах;	Тусгасан
	4. Малын бүртгэл мэдээлэл нэн тулгамдсан асуудал байгаа. Бүртгэл мэдээллийн нэгдсэн сан ажиллаад байдаг гэтэл олигтой тэр бүртгэл мэдээлэл цугларч өгдөггүй. Тэгэхлээр энэн дээр малчдын нөгөө хариуцлага талаасаа малын тоо төрлийг тогтмол хутацаанд үнэн зөвөөр бүртгүүлж байх талаар үүрэгжүүлэх талаар энэ хуульдаа оруулах;	Тусгаагүй
Төв аймгийн Жаргалант сумын Дэлгэрмөрөн компанийн захирал, МУ-ын гавьяат аргономич н.Болдбаатар:	5. Хөрөнгө оруулалтын талаар бас 16 дугаар зүйлд дурдсан байна. ХАА-н үйлдвэрлэлд хөрөнгө оруулалтыг дэмжих хамгаалахад чиглэсэн заалтууд ерөнхийдөө их хязгаарлагдмал хүрээнд томъёологдсон байна. Хөрөнгө оруулагчдынхаа хүрээг тэлэх.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	1. ХАА-н үйлдвэрт ажиллаж байгаа бүх хүн, хуульч өндөр мэргэжлийн хүн биш, жирийн тариаланч, малчид уншаад ойлгох энгийн хэллэгтэй заалт томъёолоттой байх.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	2. Тариалангийн бүс нутаг гэдэг бол маш чухал. Өмнө нь ийм хууль гарсан. Ялангуяа Төв, Сэлэнгэ, Булган зэрэг аймгуудад малчид тариаланчдын хоорондын зөрчил асар хүнд байдаг. Бүсчлэлийг эргэн харах. Тухайн бүс нутгийн, тухайн аймаг, сумдын явцуу эрх ашгийн үүднээс энэ чинь бүүр учир нь олдохгүй заваан юм болчихвий гэж харагдаад байна.	Тусгасан
	3. Газар тариаланд төлөвлөлт гэж огт байхгүй. Дотоодын хэрэгцээг таримлын төлөвлөлтийг хэн нь хийх, хэн нь тооцох талаар тодорхой байх	Тусгасан
	4. Тариаланчид, малчдыг сөхрүүлдэг, бүтэн жилийн хөдөлмөрийг үнэгүйдүүлдэг зүйл бол үнэ, өртөг байдаг. Монгол улсад том захын наймаачид, ченжүүд өөрийнхөө хүссэн хэмжээнд, хүссэн үнээрээ худалдан авдаг. Ченжийн дарангуйлал, үнийн дарамтыг энэ хуулиар зохицуулах	Тусгасан

Соёл шинжлэх ухаан судлалын хөгжил үндэсний төвийн тэргүү Д.Ганболд: ХХААХҮЯ-ны МААБХЗГ-ын дарга Ц.Мөнхнасан:	5. Тариаланчдын эцсийн зорилго нь ашиг олох. Биднүүд бүтэн жил үйл явдал хөдөлмөрлөхөөд тэр бүтээгдэхүүн нь бүтээгдэхүүний суурь үнэ байхгүй. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний суурь үнэ гаргаж байж энэ тариаланчид, малчдын жилийн бүтээгдэхүүнийг үнэгүйдээс хамгаалах боломжтой. Энэ бүтээгдэхүүний суурь үнэ байхгүйгээр төрийн мөнгөөр худалдан авалт хийдэг байгууллагууд одоо тендер хийдэг хуулийн хамгаалалтын дор хувилаад төрийн мөнгө угаах байна. Тийм учраас бүтээгдэхүүний суурь үнэ талаар хуульд Тусгасан.	Тусгасан, тариалангийн хуулиар зохицуулсан
	6. Гамшгийн тухай хуулиар газар тариаланд учирсан үер, ган, мөндөр, гэнэтийн байгалийн өөрчлөлтөд хохирол учирвал хохирол тооцох хууль зүйн аргачлал байдаггүй учраас эрсдэл тооцох, хянах, зохицуулах талаар Тусгасан.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	1. 2024 оны 2 сард ХААХҮЯ-наас ХАА-н хуулийн төслийг боловсруулах зөвлөх үйлчилгээнд шалгарч, оролцсон. Зарчмын хувьд нэлээн хэдэн саналууд байгаа учраас цахимаар хүргүүлэе.	Санал ирээгүй.
	1. ХАА-н тухай хууль дээр манайхаас ХХААХҮЯ-наас албан бичгээр бол тодорхой саналуудаа өгнө. Удирдлага зохион байгуулалттай холбоотой бүлэг дээр оруулаад өгөх. - ХАА-н үйлдвэрлэлийг удирдан зохион байгуулах төлөвлөх чиг үүрэг бүхий үүргийг улсын хэмжээнд ХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлд ХХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сум дүүрэгт ХАА-н тасаг хариуцан гүйцэтгэх - Аймаг нийслэлийн ХХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцсөн ХАА-н асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн томилж хууль тогтоомжийн дагуу чөлөөлнө - Сум, дүүргийн ХАА-н тасгийн даргыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тухайн шатны Засаг даргатай зөвшилцсөн аймаг нийслэлийн ХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга томилж чөлөөлнө - ХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд улсын тусгай хэрэгцээний бэлчээрийн ашиглалт хамгаалалт хариуцсан нэгж, ХАА-н эрдэм шинжилгээний болон инновац технологи нэвтрүүлэх төрийн өмчит байгууллага тус тус ажиллана 2. Бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог маш нарийн хариуцах эзэнтэй, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрхэн яаж зохицуулалттай байх юм бэ гэдэг байдлаар нь дэлгэрэнгүй нэмэлт оруулах шаардлагатай. 3. ХАА-н лаатгалын асуудлыг мөн одоо тусад нь нэмж оруулах ийм шаардлагатай	Тусгасан
		Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
		Тусгай хуулиар зохицуулахаар учраас тусгаагүй

Дархан-Уул аймгийн ХХААГ-ын дарга Т.Ганболд:	1. Газрын хуульд өөрчлөлт оруулах. Малчид, фермерүүдэд тэжээлийн ургамал тариалах зориулалтаар газар олго, шинэ хоршоодод газар олго гээд байлаг. Газрын хуулиар газар олгох гэхлээр сумдын засаг дарга бүрэн эрх байгаа ч зөвхөн дуудлага худалдаагаар газрыг олгох ийм зохицуулалт байгаа.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	2. Нэгжийн хуулиар зохицуулах зохицуулалт орхисон байна. Сумын аймаг, сумын хурал, Засаг даргын бүрэн эрх, чиг үүргийн асуудал тусаагүй байна. Тэгэхлээр энэ бас тодорхой зарим асуудлыг нэгжийн хуулиас нь тусад нь энэ хуульдаа оруулж өгөхгүй болбол аймаг сумдын Засаг даргад энэ хууль огт хамаагүй юм шиг болчих вий.	Дагалдах хуулиар зохицуулахаар тусгасан
ХХААХҮЯ-ны ГТБХЗГ-ын дарга Д.Есөнэрдэнэ:	1. ХХААГ сумдын тасгийг босоо болгох	Тусгаагүй
	2. ХАА тухай хууль батлагдсантай холбогдуулан Газрын тухай хуульд холбогдох өөрчлөлт оруулах	Тусгаагүй
Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал эмнэлгийн хяналт баталгаажуулалтын газрын дарга Батсүх:	1. Энэ хуулийг гаргахдаа бусад одоо салбарын ялангуяа оператив үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн хуулиудтай уялдуулах	Тусгасан
	2. Босоо удирдлагын тогтолцоотой байх.	Тусгасан
	3. Мал эмнэлгийн ерөнхий газар энэ дээр бас албан байдлаар саналаа өгөх байх. Мэргэжлийн байгууллагуудаас албан ёсоор санал авах, мэргэжлийн байгууллагынхаа төлөөллөөр ажлын хэсгээ өргөтгөх	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	1. Газар тариалан, мал аж ахуйн салбарыг зохицуулсан малтай хуультай болох; Энийгээ дагаад дагах хуулиадаа сайн харах.	Тусгасан
Уудам хангай сүрэг ТББ-ийн тэргүүн, судлаач Г.Удвал:	2. Бэлчээрийн доройтлын тухай, бэлчээрийн тухай хуультай болох, холбогдох хариуцлагын асуудлыг Тусгасан.	Тусгасан
	1. Энэ хуулийн хоёрдугаар зүйлийн ХАА-н хууль тогтоомж гэдэг дотор тариалангийн бүс нутгийг тогтоох тухай заалт байгаа энийг оруулж өгөх. Яагаад гэвэл ер нь тариалангийн бүс нутагт мал, малчин, тариаланч 2-ыг одоо их хооронд нь их муудалцуулдаг хууль байгаа юм. Тэгэхдээ би энийг энэ одоо энэ хууль дээр ч бас ийм юм гарна. Яагаад гэвэл энэ бол хууль дээрээ 500 метр тариа тариалсан тохиолдолд малчны нүүлгэх зардлыг нь тухайн ААН иргэнээс гарга гээд тодорхой заасан.	Тусгасан
	2. Бэлчээрийн мал аж ахуй гэдэг ойлголтыг тодорхой болгож, хуульчлах	Тусгасан
		Тусгасан
Төв аймгийн Зуунмод сумын иргэн, МУ-ын гавьяат агрономич Ж.Сүрэнхорлоо:		Тусгасан

Төв аймгийн Алтанбулаг сумын иргэн, Тээг хангай хоршооны захирал Ү.Батцэнгэл:	3. Хадлангийн талбай гэдгийг орхигдсон байна. Ялангуяа хадлангийн талбайг усжуулаад нэг олон наст ургамал тарьдаг тийм ААН эрүүл баруун аймгуудад байдаг юм шиг байна лээ. Тэд нар тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийж байна. Тэд нарт энд дэмжлэг туслахаа ч гэсэн юм алга.	Тусгасан
	4. Бэлчээр болон тариалангийн талбай гээд орчихсон байх юм. Ойн зурвас байгуулах гээд нэг үг явж байна. Ойн зурвас байгуулах зайлшгүй шаардлагатай. Тариалангийн талбай 70-80% нь элэгдэлд орчихсон, бэлчээрийн 92% нь бас элэгдэлд орчихсон, төрийн захиргааны төв байгууллагын хоорондын зохицуулалт гэж байхгүй. 100 га эзэмшиж байгаа тариалангийн талбай дотроо зурвас байгуул гээд байгаа бол тарих талбай чинь их багасна, хэрэв тариалангийн талбайнхаа гадна талд нь ойн зурвас байгуулах талаар ямар ч зохицуулалт байхгүй. Энийг зохицуулах.	Дагалдах хуулиар зохицуулахаар тусгасан
	5. Хуулийн 13.3.7 дээр хөрсний үржил шимийг сайжруулах, хамгаалах чиглэсэн бордоо, үр хангамж, ойн зурвас, үр хангамж гээд ингээд орчихсон байгаа юм. Энэ дээр ер нь техник шинэчлэл сайн явагдсан шүү дээ. Өөрөө зүтгэх 90% нь бараг шинэчлэгдсэн. Гэтэл энэ хөрс чинь ягаад элэгдэлд ороод байгаа, эвдрээд гэхлээр араас нь хуучны чирдэг тоног төхөөрөмж ашиглаж байгаа учраас энэ заалт дээр техник тоног төхөөрөмж гэсэн нэмэх.	Тусгасан
Төв аймгийн Алтанбулаг сумын иргэн, Тээг хангай хоршооны захирал Ү.Батцэнгэл:	1. ХАА-н салбарын уялдаа холбоог сайжруулах	Тусгасан
	2. Бизнесээ тогтвортой эрхэлж явуулах талаар хуульдаа Тусгасан	Эрсдлийн заалттай уялдуулан тусгасан
	3. Бэлчээрийн МАА-г эрчимжүүлж талаар Тусгасан	Хөрөнгө оруулалт, дэмжлэг хэсэгтэй уялдуулан тусгахаар хүлээн авч, агуулгын саналыг хүлээн авсан
ХААХҮЯ-ны МАА-н бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Бямбадорж:	1. Өнгөрсөн он 6 сард бол одоо малчны тухай хууль Малчин өрхийн ийн нэгдсэн эрх зүйн байдлын тухай хууль гээд 2 хууль батлагдаж одоо хэрэгжиж байгаа. Эдгээр хуультай уялдуулж, тэжээлийн ургамал асуудлыг Тусгасан.	Нэр томьёолол, дэмжлэгтэй уялдуулан агуулгын саналыг хүлээн авсан
	2. Усны талаар хуульд орхигдчихсон байна. Тэгэхээр өнөөдөр одоо бэлчээрт нөгөө бэлчээр усан хангамжийг сайжруулна гээд одоо инженерийн хийцтэй худаг ус гаргах асуудал маань энэ хуультай холбогдоно. Усны тухай хуулийг энэ хуульд тусгаж, оруулж өгөх;	Тусгасан
	3. Хуулийн төслийн 16 дугаар зүйлд ХАА-н үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт, дэмжих, хамгаалах гээд 16.1-д ХАА-н үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагааны хөрөнгө оруулагч дараах хэлбэрээр оролцож болно гээд ингээд оруулчихсан байна. Малын үржил селекцийн ажилтай холбоотой ийм асуудал байгаа. Тэгэхээр энд мах, сүү, ноосны чиглэлийн одоо үүлдрийн цөм сүргийн малыг үржүүлж байгаа ахуйн нэгж, өндөр ашиг шимтэй цэвэр үүлдрийн малыг нутагшуулж байгаа аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтыг дэмжих хамгаалах гэдэг энэ зүйлд одоо бүр нэр зааж оруулж өгөх;	Тусгасан

	4. Бэлчээрийн асуудал. Одоо малын тэжээлийн гол үндэс болсон бэлчээрийн асуудал маань одоо хуулийн төсөл дотор болбол 9.3.2 дээр бэлчээр хамгаалах төлөвлөгөө гэсэн заалт байна. Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бүс нутаг байгаа. Орон нутгийн тусгай хэрэгцээний аймаг, сум дундын отрын бүс нутаг гэсэн энэ асуудлыг хуулийн төсөлд маш тодорхой оруулж өгөх	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	5. Малын генетик нөөцийг хамгаалах, МАА-н үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх өндөр ашиг шимтэй цэвэр үүлдрийн малыг үржүүлж, мал үржүүлгийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх асуудал орхигдсон байна. Малын генетик нөөцийн тухай хуулиар энэ асуудал маань зохицуулагдаад явж байгаа боловч одоо энэ гол салбарын уялдаа холбоог хангах талаар тусгаж өгөх;	Тусгасан
	6. Арчилгаа, малагаа, тэжээллэг, үржил селекции ажлыг босоо тогтолцоотой байлгах;	Тусгасан
НҮБ-ын ХХААБ-ын хөтөлбөрийн зохицуулагч А.Амгалан	1. ХАА-н бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нэг боломж нь газар зүйн заалттай бүтээгдэхүүнийг хөгжүүлэх байгаа. Тэгэхээр газар зүйн заалттай бүтээгдэхүүнийг хөгжүүлнэ ээ гэдгийг нэмж оруулах;	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	2. Хуулийн төслийн 13.4 дээр хөрөнгө оруулалтын багтаамж сайтай тэгэхдээ үйлдвэрлэгчийн зүгээс нөгөө хөрөнгө оруула гэхээр их хэмжээний мөнгө шаарддаг асуудал бол ойжуулалт хөгжүүлэх талаар дутуу орсон байна. Зөвхөн ойн зурвас байгуулах гээд дутагдалтай оруулчихсан байна. Тэгэхээр энийг агаар ойжуулалт хөгжүүлэх гэж өргөн утгаар нь оруулж өгөх, салбар луу нэлээн хөрөнгө оруулалт оруулах боломжтой байхаар оруулах.	Тусгасан
Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайдын орон тооны бус зөвлөх Энхтуяа	1. Манайд гарч байгаа хуулиуд нь салбар дундын зохицуулалт байхгүйгээс болоод хэрэгжихгүй байдаг. Олон улсад Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрт хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ хуулийн үзэл баримтлалдаа заавал оруулах	Олон улсын гэрээ хэлэлцээрийн үүргийг тусгаж оруулсан
	2. ХАА-г хөгжүүлэхэд бүс нутгаа тогтооноо гэж ярилаа. Тэгэхлээр бусад салбар болон газар ашиглалтын ерөнхий төлөвлөгөөтэй нийцүүлсэн байгаасай. Судалгаанд суурилсан шинжлэх ухаанч байдлаар хандсан ийм орон зайн төлөвлөлтийн аргыг сүүлийн үед их хэрэглэж байгаа. Ялангуяа байгаль орчны салбарт бол одоо оролцогч талуудыг бүгдийг нь оролцуулсан үнэ цэнтэй газраа тогтоогоод, тусгай хамгаалалттай газраа тогтоосон. Байгалийн нөөцийг хамгаалах, нөгөө тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлт, нөөц баялгийн асуудал. ХАА чинь өөрөө байгалийн нөөц дээр суурилж байгаа салбар учраас нөөцөө хамгаалахгүй бол урт хугацааны бодлого тогтвортой хөгжлийн бодлого гэж байхгүй. Энэ талаар Тусгасан.	Орон зайн төлөвлөлтэй зэрэг асуудлыг агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	3. ХАА-н үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт, тагаасны бодлогоо хийхдээ бусад салбартай уялдуулаагүй учраас Уламжлалт МАА-г томьёолоход анхаарах	Нэр томьёолуудуудуулан агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан

	4. Малчид нь өөрсдөө яг уламжлалт МАА гэдэг утгаар сэлгэж нүүх, бэлчээрээ өнжүүлэх, сургийн бүтэц, уламжлалт малчин гэдгийг тодорхойлж, малчдыг хариуцагажуулах.	Нэр томъёололцуулдуулан агуулгын саналыг хүлээн авсан
	5. Дуудлага худалдаагаар газар олгох асуудлыг салбар хоорондоо уялдуулаад орон нутгийг оролцуулаад шийдэх	Тусгасан
Төв аймгийн ХХААГ-ын мал үржлийн хяналтын улсын байцаагч Х.Түвшинсанаа	1. Хадлангийн бэлчээрийг зүй зохистой ашиглах;	Тусгасан
	2. Өвс тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлэх. Сумд, аймгууд намартаа өвс тэжээлээ бэлддэг эрх зүйн зохицуулалтыг нь сайжруулах, хэн, хаанаас яаж бэлдэх тодорхой болгох, нөөцөөс хэрхэн хуваарилах,	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх Ц.Даваабаяр	1. Малчдын болон тариаланчдын хоорондын үл ойлголцох асуудал байгаад байгаа юм. Энэ зохицуулалт хууль байхгүйгээс үүдэлтэй. ХАА-н тухай хуульд тодорхой Тусгасан	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	ХАА-н хууль буюу малгайн хуулийг батлуулах тухай УИХ-ын 36 дугаар тогтоол дээр тодорхой заачихсан байгаа. МАА-н, газар тариалангийн салбар хоорондоо байнгын маргаантай явж ирсэн. Тэгвэл энэ хуулиар зохицуулагдана	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	Хөдөө аж ахуйн бирж гэдэг ойлголтыг бас хуульд оруулж өгвөл зүгээр юм болов уу гэж бодож байна. Нэгэнт эдийн засгийн асуудлуудыг энэ хуулиар зохицуулж байгаа бол биржийн асуудал дээр тодорхой арга хэмжээ тусгаад өгчхөөрэй гэж хүсэж байна.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
Монголын тариаланчид, гурил үйлдвэрлэгчдийн холбооны дэд тэргүүн Ш.Шинэбаяр:	1. Д.Насанжаргал докторын хэлсэнтэй адил нэр томъёоны хувьд бодоорой, мөн концепцийн хувьд нь бодоорой.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	2. Хуулийн төслийн 4.1.1-д өрхийн өөрийн хэрэглээний аж ахуй гэж байна. Үүнийг нэр томъёоны хувьд дахин нэг хараарай. Фермерийн аж ахуй гэдгийг эргэж хараарай. Үүнд би санал өгч болно.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	3. Хуулийн төслийн 6.2.7-д агро-ойн аж ахуй гэсэн нэр томъёо байна үүнийг бас эргэж хараарай.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	4. Хуулийн төслийн 13.4-д дэмжлэг гэж байна. Үүнд бордооны үйлдвэр, ургамал хамгааллын бодисын үйлдвэрт маш их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг. Тиймээс үүнд төрийн дэмжлэг, банк санхүүгийн дэмжлэг хэрэгтэй байх.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан

	5. Хуулийн төслийн 15 дугаар зүйлд ХАА-н судалгаа ба хөгжүүлэлт гэж байна. Хөгжлийн боллоготой холбогдон Тусгасан нь илүү зүйтэй байх.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
Монголын тариаланчдын үндэсний холбооны Ерөнхийлөгч Л.Баяртулга:	1.Энэ хуулийн төслийг ерөнхийд нь харахад хөрөнгө оруулалтыг баялгийн сантай холбох ч юм уу эсвэл бонд босгох ч юм уу иймэрхүү хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талд нь эвтэйхэн механизмуудыг нээж өгвөл зүгээр санагдаж байна.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
Монголын агрономчдын холбооны тэргүүн Б.Амарсанаа:	Хуулийн төсөлд гадаад, нэр томъёо, ойлгомжгүй, эзэн биегүй үг, өгүүлбэр, химийн бордоо гэх мэт засахаар үг, өгүүлбэрүүд байна. Зарчим гэж хуульд байх уу, үгүй юу гэсэн асуудал байна. Тариалангийн хуульд орсон асуудлууд байна. Үүнийг оруулах хэрэгтэй юу. Хуульд ороогүй асуудлаа оруулж өгвөл зүгээр баймаар байна. Тариаланчид, Агрономчдын холбоо Газар тариалангийн тухай хуульд ороогүй асуудлууд байна гээд сайдтай уулзахаар ХАА-н тухай багц хууль боловсруулагдаж байгаа түүнд саналаа өгөөрэй гэдэг. Бид саналаа ХХААХҮЯ-д өгсөн байгаа. Сум бүрийн ХАА-н газар нь мэргэжлийн агрономчтой байна гэсэн заалт Тариалангийн тухай хуульд байдаггүй. Малын удмын сангийн генетик нөөцийн тухай хуульд байдаг. Б.Одгэрэл багшийн хэлснээр төрд ажиллахад нийгмийн баталгаа байхгүй, эрх зүйн орчин бүрдээгүй. Тиймээс элсэгч бага байгаад байна. Мөн төрийн дэмжлэг цалин бага байна. ХААИС-иас ч, холбооноос ч судалгаа хийж үзэхэд цалин бага учир төгсөгч тухай ажлын байранд очиж ажиллахгүй байна гэсэн үр дүн гардаг. Тариалангийн тухай хуульд Агрономичийн нийгмийн баталгаа гэсэн нэг ч өгүүлбэр байдаггүй. Нийгмийн баталгаагаа хаячихсан хууль байдаг. Тиймээс нийгмийн баталгааг энэ хуульдаа оруулмаар байна. Анхны хэлэлцүүлэг дээр нийгмийн баталгааны 2 заалт байсан гэвч түүнийгээ хассан байна. Энэ төслийг сүүлийн байдлаар гэж бодож байна. Тиймээс тэр нийгмийн баталгааны асуудлыг оруулах шаардлагатай байна. Манай холбооноос хүргүүлж байгаа санал дээр 6 нийгмийн баталгааны асуудлыг бичсэн байгаа. Саналаа албан бичгээр хүргүүлнэ	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Т.Атарсайхан:	1.М.АА, Газар тариалангийн хууль хоорондын зохицуулалтуудыг нилээд багцалсан байдлаар хуулийн үндсэн концепци байгаа юм байна гэж ойлгож байна. Зарим заалтуудыг харахад жишээлбэл орон нутагт газар нутгийг өргөжин хөгжүүлэх ажлыг орон нутгийн захиргаа шийднэ гэсэн байгаа нь хэр оновчтой байх вэ гэдгийг би хараад байна. Өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлэхээр зорьж, газар тариалангийн төвийн бүс болгоно гээд 3 аймгийг заасан, энэ нь яг хаана хэрэгжихгүй байна гэхээр орон нутагтаа хэрэгжихгүй байгаа. Тэгэхээр тухайн орон нутгийн ИТХ-аас шинжлэх ухааны үндэслэлтэй түүнийг тогтоож чадах болов уу гэдэгт эргэлзэж байгаа юм. Тиймээс энэ заалтаа эргэж хараач гэсэн саналтай байна.	Тусгасан

ХААИС, Эдийн засаг, бизнесийн сургуулийн профессор С.Хандсүрэн:	2.Бидний боловсруулсан маш их технологи хаана очоод гацаад байна гэхээр МАА, газар тариалан 2 зэрэгцээд явах боломжгүй, зөрчилдөөд байгаа асуудал байна. Төсвөөс дэмжлэгүүд байгаа. Шинжлэх ухааны үр дүнгүүдийг нэвтрүүлж байгаа аж ахуй нэгжүүдээ дэмжиж, тэр дундаа цаг уурын өөрчлөлтөд дасан зохицож байгаа шинэ үүлдэр, сортуудыг бүтээж, нэвтрүүлж байгаа аж ахуйн нэгжүүдэд энэ дэмжлэгүүдийг өгвөл зүгээр юм болов уу гэсэн санал байна.	Тусгасан
	3.Аж ахуйн нэгжүүдэд үрийн асуудал маш их үүсэж байна. Аж ахуй нэгж дотроо үрийн аж ахуйн системийг эрхэлж байгаа аж ахуйд дэмжлэг байвал гэсэн санал байна.	Тусгасан
	4.Хүний нөөцийн асуудал яригдаад байгаа ч нөгөө талдаа ухаалаг, нарийвчлалтай газар тариалан буюу хүний үйл ажиллагаанаас хараат бус газар тариалангийн асуудлыг энэ хуульдаа тусгаад, дэвшилтэд технологийг хэрэглэх талд анхаарвал яасан юм гэсэн саналтай байна. Нэгдсэн ХАА-н цахим сан бүрдэх гэж байгаа юм байна. Таримал ургамлын генетик нөөцийн санг бас тусгаж өгөөч. Одоогоор бид НҮБ-ийн санхүүжилтээр таримал ургамлын генетик нөөцийн санг бий болгоод байгаа.	Тусгасан
	1.Хуулийн 8 дугаар зүйл дээр ХАА-н гаралтай түүхий эд бүтээгдэхүүний өртгийн сүлжээ гэдгийг сайжруулах хэрэгтэй байна. Хуулийн төслийн 8.6-аас хойших Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, орон нутгийн хөгжлийн төвүүд түүний давхцалын цэгүүдийг нөөцтэй нь уялдуулан зохицуулах шаардлага байгаа. Мөн 8.6 дотор мал бордох аж ахуй гэж орсон байгаа. Энд мал бордооны үйлдвэр байж төв бүрэн ажиллана. Тиймээс мал бордох аж ахуй гэдгээ хасах нь зүйтэй юм болов уу гэсэн санал байна. 8.7-д итгэмжлэгдсэн төлөөлөгч гэрээний үндсэн дээр гүйцэтгэж болно гэсэн байгаа. Төв байгуулахад мэдээж хөрөнгө оруулалт хэрэгтэй. Энэ хөрөнгө оруулалтыг гэрээний үндсэн дээр биш боловсруулах үйлдвэрүүд хөрөнгө оруулж байгуулах хэрэгтэй. ХАА-н гаралтай бүтээгдэхүүний үндсэн хэрэглэгч нь боловсруулах үйлдвэрүүд нь байна. Боловсруулах үйлдвэрүүд маань тодорхой хэмжээний дэмжлэг авчхаад эргээд түүхий эдийн чанарт анхаарахгүй байгаа. Тиймээс боловсруулах үйлдвэрүүдийн хөрөнгө оруулалтыг тодорхой салбар луу шингээх хэрэгтэй байна. 8.11-д түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн үе шатанд боловсон хүчин, ажилтныг бэлтгэх гэдгийг хасаад ХАА-н хүний нөөц, үйлдвэрлэл хэсэгт оруулах саналтай байна. Хүний нөөцийн асуудал нь бэлтгэн нийлүүлэлт дээрээ явах нь тохиромжгүй байна.	8.11 заалтыг сайжруулахаар хүлээн авсан. Бусад саналуудыг хүлээн аваагүй.
	2.Хуулийн төслийн 8 дугаар зүйлийг 4 дүгээр бүлэгтэй уялдуулах хэрэгтэй. Энэ хоёрын хоорондын уялдаа хангалтгүй байна. Тухайлбал 13.2.4-д үйлдвэрлэлд нийлүүлсэн байх, 13.2.6-д хоршоонд нийлүүлсэн байх гэсэн байна. Ченжийн системээр хоршоонд өгвөл яах юм. Тэгвэл одоогийн системээс ялгаагүй болно. Тиймээс энэ 2-ыг нийлээд уялдуулах хэрэгтэй.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	3.Хуулийн төслийн 16.4.2-д 8 дугаар бүлэгтэйгээ адил заалтууд орсон байна. Түүхий эд бэлтгэлийн системийг орон нутагт байгуулах гэх юм бол хөрөнгө оруулалтын асуудлыг шийдэх хэрэгтэй. Орон нутагт бол хөрөнгө оруулалт байхгүй, малчид бол дундын хоршоогоороо дамжуулж хийж болох юм. Гэхлээ тодорхой хэмжээний хөрөнгө хэрэгтэй.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан

	Багцаалсан тооцоогоор түүхий эд бэлтгэлийн цэгийг, мал нядалгааны цэг, тээвэртэй нь хамт байгуулна гээд тооцоход 1.5-2 тэрбумын санхүүжилт шаардлагатай. Малчид тэр бүтээгдэхүүнээ борлуулахад жилдээ 100-200 сая төгрөгийг зөвхөн тээврийн зардалцаа шингээдэг. Тоог нь авч үзэхээр тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай болж байгаа. Үүнийг анхаарч үзээрэй.
ХААИС, Элийн засаг бизнесийн сургууль профессор Р.Чанцалдулам:	Энэ хууль нь 6 бүлэг, 21 дэд бүлэг, 78 заалттай юм байна. Заалт нэмэх шаардлагатай юм байна гэж харж байна. Мал амьтны тавлаг байдлыг хангах замаар органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлийн заалтууд нэмэх шаардлагатай байна гэж харж байна. Тогтвортой хөгжил гэсэн 9 дүгээр заалтад орох хэрэгтэй байгаа байх. Олон улсад ч гэсэн мал амьтан тавлаг байж органик бүтээгдэхүүн үйлдвэрлэл явагдана гэж үздэг. 10 дугаар зүйл дээрх Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хүний нөөц хэсэгт яагаад хөдөө аж ахуйн салбарт ажиллах ёстой юм, ХАА-н салбарт ажилласнаар ямар үр ашиг хүртэх юм гэсэн мотивацийн идэвхжүүлэлт болох заалт оруулах хэрэгтэй байх. Боловсролын тухай хуульд бол Малчны нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс даана гэж орсон байгаа. ХАА-н салбарт ажиллаж байгаа хүний хүүхэд уламжлан хөдөө аж ахуйн салбарт ажиллах юм бол төрөөс хөнгөлөлт үзүүлнэ гэсэн заалт оруулж өгвөл ХАА-н салбарт ажиллагсдын тоо нэмэгдэнэ гэж харж байна. МАА, газар тариалангийн салбарт газар зүйн заалттай бүтээгдэхүүнийг хөгжүүлж эхлэхэд ямар урамшуулах олгох талаар ХАА-н дэмжлэг гэсэн хэсэгт оруулж өгөөч. Үүнийг үйлдвэрлээд эхлэх юм бол бидний дэлхийд гарах гарц нэмэгдэнэ, бидэнд хэрэгцээ шаардлага байна, боломж байна. Иймээс бид хуульдаа тусгаад, дэмжиж өгөх шаардлагатай байна. БНХАУ гэхэд сүүлийн жилүүдэд 3000 гаруй газар зүйн заалттай бүтээгдэхүүн олон улсад үйлдвэртэж эхэлсэн.
Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академийн гишүүн, Шинжлэх ухааны доктор, профессор Ч.Бямбадорж:	1. Хуулийн төслийн 1. 4.1.1, 4.1.2-ын алинд нь малчид хамаарах нь тодорхойгүй байна. Би бол малчдыг 4.1.1-д хамааруулах нь зөв юм уу гэж харж байна. 4.1.2 бол бизнесийн зориулалттай нэг ёсондоо бол хоршоог хэлж байна гэж үзэж байна. 4.1.1-д дотоодын хэрэгцээгээ хангах, илүү гарсан бүтээгдэхүүнийг борлуулах гэсэн үг нэмэх нь зүйтэй. 2. Хуулийн төслийн 2. 4.1.3-д фермерийн аж ахуй гэсэн тодорхойлолтыг болохгүй байна гэж үзэж байна. ОХУ-д 1924 онд Тариачны аж ахуй буюу фермерийн аж ахуйн тухай хууль батлагдсан юм байна лээ. Тэр хууль дээр байгаа тодорхойлолтыг та бүхэн хараарай. Үүнд нэг онцлог заалт нь манай хуулийн төсөл дээр бол үйлдвэрлэлт эрхлэлт гэсэн байсан энэ хуульд бол аж ахуйн үйл ажиллагаа гэсэн байна. Аж ахуйн үйл ажиллагаанд хадгалалт, тээвэрлэлтийг багтаасан байна. Бас нэг чухал заалт бол хувь хүний биет оролцоон дээр суурилсан гэсэн байгаа нь энэ зөв хэллэх юм болов уу гэж харж байна. 3. Хөдөө аж ахуйн хоршоо гэсэн тодорхойлолт баймаар байна. Ерөнхий ойлголт заавал байх хэрэгтэй. Дотроо бол салах байх. Ерөнхий тодорхойлолт нь Иргэний хуулийн 36.4 дээр байгаа юм байна лээ.
	Тусгасан

	4. Бэлчээрийн мал аж ахуй гэсэн тодорхойлолт дотор хамгийн гол зүйл нүүдлийн мал аж ахуй орхигдсон байна. Нүүдлийн гэдэг үг энд зайлшгүй орох шаардлагатай. Өнөөдөр энд байгаа маргааш нь байхгүй болох онцлог зүйл.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	5. Редакцын завсартай заалтууд байна.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	6. Эрчимжсэн МАА гэдэг 4.1.5-ын тодорхойлолт бас дулимаг. Ингээд харахад мал бордох цэгийн тухай л харагдаад байгаа. Эрчимжсэн аж ахуй, МАА гэхээрээ эрчимжсэн аж ахуй гэсэн үндсэн суурь байх ёстой. Тэгээд тэр нь МАА, газар тариалан, амьтны аж ахуй гэх мэтээр дотоод задрах ёстой. Тэгэхээр эрчимжсэн аж ахуй гэж ерөнхий тодорхойлолтыг оруулах ёстой байх. Эрчимжсэн аж ахуй гэж юуг хэлж болох вэ гэхээр шинжлэх ухаан техникийн дэвшил, өндөр бүтээмжтэй хөдөлмөр зохион байгуулалтад суурилсан таримлын ургац, мал амьтны ашиг шимийг нэмэгдүүлэх замаар үйлдвэрлэлдээ суурилуулаад хагас үйлдвэрлэл явуулах гэдэг ч юм уу энэ тодорхойлолтыг бол нэгдсэн журмаар оруулах нь зүйтэй болов уу гэж үзэж байна.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	7. Аж үйлдвэржсэн ХАА-н талаар тодорхойлолт байхгүй байна. Шувуу, гахайн том фермүүд гэх мэт ерөөсөө байхгүй байна. Тэгэхээр аж үйлдвэржсэн ХАА тэр дотроо аж үйлдвэрлэгдсэн МАА, аж үйлдвэржсэн газар тариалан гээд энэ чиглэлийн том тодорхойлолтууд байх ёстой. Эд нар бүгд нэг том цогцолборууд байна. Энэ тодорхойлолтууд байхгүй байна.	Тусгасан
	8. Тогтвортой аж ахуй дээр саяын хэлсэн зүйлтэй холбогдуулаад нарийвчилсан технологи, ухаалаг технологи, хиймэл оюун ухааны хэрэглээ, автоматажсан үйлдвэрлэл, үйлдвэржсэн аж ахуйнуудыг өргөжүүлэх асуудал зайлшгүй байх ёстой. Энэ бол тогтвортой бүтээгдэхүүн үйлдвэрлэх сүүлийн үеийн гол эх үүсвэрүүд. Үүнийг нэмж оруулахгүй бол энд байхгүй байна.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	9. Хөрөнгө оруулалтыг дэмжих гэж байна. Хөрөнгө оруулалтыг дэмжих гэхээр сая хэлсэн зүйлүүд бас байгаад байна. Хөрөнгө оруулалтыг дэмжих зүйл чинь дэвшилтэд чиглэлээр байх ёстой. Нарийвчилсан технологи нэтрүүлж байгаа газрууд ухаалаг, смарт технологийг нэвтрүүлсэн байх ёстой. МАА, газар тариалан аль ч салбартаа ухаалаг технологи байгаа. Роботжисон техник хэрэгсэл, автомат үйлдвэрүүд. Ийм чиглэлийн технологи, бүтээгдэхүүн хөгжүүлж байгаа ААН, хүмүүстээ санхүүгийн зээлийн янз бүрийн дэмжлэгүүд байх ёстой. Тэр нь цаашдаа баталгаатай, тогтвортой үйлдвэрлэл болно. Тийм учраас үүнд зохицуулалтыг нь хийх хэрэгтэй болов уу гэж бодож байна.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	10. Хуулийн төслийн 5 дугаар бүлэгт “ХАА-н салбар хариуцсан төрийн төв байгууллага өөрийн харьяалалдаа дангаараа болон бусад төрийн төв байгууллагатай хамтран их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжил сургалтын төвүүдтэй байж болно” гэсэн заалтыг оруулаад та бүхнийг хамгаалаад үзээч гэж хэлэх гэсэн юм. Өөрөөр хэлбэл энэ хуулиар бидний харилцаанд байгаа янз бүрийн процесс, тулгамдаад байгаа асуудлыг шийдэх зорилгоор боловсруулж байгаа. Тэр асуудлыг шийдэж чадахгүй бол хууль маань дутуу боловсруулагдсан гэсэн үг.	ХААСалбарын дээд боловсрол, ЭШ, Үйлдвэрлэлийн нэгдсэн холбоог хангах /бүтэг маягийн өгүүлбэр оруулах/-Агуулгын саналыг хүлээн авсан

	11. Малчин, тариаланчийн зөрчлийг шийдвэрлэх асуудал дээр сая ажлын хэсгийн гишүүн Г.Даваадоржийн хариулсны дагуу заалтыг оруулж өгөөч. Орон нутгийн нөхцөлдөө харилцан зохицож гэдгийг. Хуулиар зохицуулахгүйгээр энэ асуудлыг шийднэ гэж байхгүй, заавал хуулиар зохицуулна. Гол нь хууль нь 2 талын хэрэгцээнд нийцсэн зохицуулалттайгаар орох ёстой.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	1. Хууль бол аливаа харилцааг зохицуулдаг. Тэр харилцаа нь амьдралаас урган гарч ирдэг. Тэр талаас нь харах юм бол хуулийн төсөл ерөнхийдүү, тунхгийн шинжтэй, зохицуулалт харьцангуй бага, байгаа ч гэсэн ерөнхий байна. 2. Манай ХАА-н салбарын хамгийн том баялаг, хамгийн том нөөц болох бэлчээрийн асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай. Бэлчээрийн маргаанаас үүдсэн асуудлууд олон байна. Энэ асуудлыг хуулиар зохицуулах байх. Бэлчээр гэдэг бол зөвхөн МАА-н асуудал биш, бэлчээрийн асуудлыг зөнд нь орших юм бол үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын асуудал, хүний эрхийн асуудал яригдана. Энэ асуудалд онцгой анхаарах ёстой. Асуудал төвөгтэй учир тойрч зугтаадаг зүйл байгаа байх.	Тусгасан
ХААИС-ийн профессор, Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академийн гишүүн Ж.Батчулуун:	3. ХАА-н салбарыг тэргүүлэх салбарын хэмжээнд хүргэх ёстой. Миний ойлгож байгаагаар боловсрол тэргүүлээд байна. Багшийн чиглэлээр суралцаж байгаа ихэнх оюутны төлбөрийг төрөөс дааж байгаа байх, гэтэл ХАА-н салбар тийм биш байна. Ядаж ХАА-н үндсэн чиглэлээр суралцаж байгаа оюутнуудын сургалтын төлбөрийг төрөөс дааж болохгүй юм уу? ХАА-н салбарыг агаар салхи, аялал зугаалтын байдлаар ашиглах гээд байна, тиймээс энэ чиглэлдээ онцгой анхаарах хэрэгтэй. Энэ бүгдийг харгалзаж үзэхгүй бол бидний яриад байгаа хууль амьдралд хэрэгжихгүй, хоосон цаас болох магадлалтай шүү.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
ХААИС, Агроэкологийн сургууль, Газрын менежментийн тэнхимийн эрхлэгч И.Мягмаржав:	1. ХАА-н газрын бүсчлэлийг орон нутгийн ИТХ тогтоохоор туссан гэж ярилаа. ХАА-н бүсчлэлийг орон нутаг тогтоох ямар ч боломжгүй байдаг. Тухайн ХАА-н газрын бүсчлэлийг тогтоохдоо дотоод хэрэгцээний хангамж хэр байгаа, тохиромжтой байдал, ашиглалт, хамгаалалт, менежментийн төлөвлөгөөтэй нь хамт хийж байж бүсчлэлийн төлөвлөгөө нь бүрэн болдог. Бүсчлэлийг тогтоох талаар Газрын тухай хуульд байдаг. Тиймээс энэ хуультайгаа уялдуулах шаардлагатай. Газар зохион байгуулалтын төлөвлөгт нь Улсын газар зохион байгуулалтын, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын, сум, дүүргийн нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө гэж байгаа. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө нь сум дээрээ хийгддэг, сумын ИТХ нь мэргэжлийн байгууллагаар батлуулж өгдөг. Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Газрын мэргэжлийн байгууллага хийдэг. Тиймээс газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан хийнэ гэж оруулж өгсөн дээр байх.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан

Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академийн гишүүн, ШУ-ны доктор, профессор Я.Ганболд:	2. Бэлчээрийн даац, багтаамж тогтоох бол том асуудал байдаг. Манай 3 яамны тогтоосон бэлчээрийн даац, багтаамж тогтоох аргачлал бол болохгүй байгаа. Төл малын идэх өвсний хэмжээ өөр, бусад малын идэх өвсний хэмжээ өөр. Төл мал, бусад малыг хонин толгой руу шилжүүлэхэд итгэлцүүр нь өөр байх ёстой. Тухайн бэлчээрийн сэргэн ургах чадвар нь бүс нутгаасаа хамаараад өөр байдаг. Тухайн бэлчээрийг давтан ашиглах тоо энэ арга дотор ороогүй байдаг. Нутаг дэвсгэрийн нөөцийг коэффициентоор оруулдаг. Миний хэлсэн энэ арга зүйгээр Барилга хот байгуулалтын яаманд боловсруулж өгсөн байгаа. Энэ арга зүйг улсын хэмжээнд хэрэгжүүлэх боломж нь юу юм гэдгийг судалж үзээч гэж хэлэх гэсэн юм. Бүс нутгийн онцлогт тохирсон, малын экологийн зохистой бүс нутгийн онцлогт тохируулаад бүс нутаг, орон нутагт тохирсон арга хэмжээнүүдийг энэ бодлоготоо тусгаж өгөөч гэж хүсмээр байна.	Зохихуулсан харилцааг судалж, агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	3. Баруун бүс нутаг маань экологийн яг ямар зохистой бүс нутаг юм, ямар төрлийн мал үржүүлбэл зохистой, үүнээс нь хамаараад баруун бүс нутагт бэлчээрийн даацад тохирсон мал, сүргийг зохистой бүтцийг тогтоож өгөөд түүн дотроо сум, орон нутаг маань өөрийнхөө онцлогтой тохирсон арга хэмжээнүүдийг авч явна. Өнөөдөр гэтэл төрийн бодлого ч гэсэн олон малтай байх юм бол сум, аймаг, улсын аварга болгоод байна. Гэтэл цаана нь мал сүргээ эрчимжүүлэх, бэлчээрийн даац, багтаамжтай уялдсан дэмжих бодлого байхгүй байгаа учраас Тусгасан хэрэгтэй байна.	Тусгасан
	4. Өртгийн сүлжээг кластераар хөгжүүлэх асуудал маш чухал. Малын түүхий эд үнэгүйдээд байна. Гэтэл энд хамгийн гол нь нөөц дээр тулгуурла гэж байна. Махныхаа, сүүнийхээ, төмс, хүнсний ногооныхоо хэрэгцээгээ тооцож үзээд дотоодын хэрэгцээг хэдэн хувь нь хангаж байгаа юм, үлдсэн хувийг бусад аймгууд юм уу, гадаад зах зээлд гаргах, нийлүүлэх боломж нь хэр байна. Үүнийг эдийн засгийн нөхцөлүүдтэй уялдуулаад хаана нь аль кластерын чиглэлийг байгуулж болохоор байна, хугацааг нь заагаад энэ хуулийн төсөлдөө оруулж өгөх нь зүйтэй гэж бодож байна.	Кластерын асуудлыг судалж, агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	1. ХАА-н үйлдвэрлэлийг явуулж байгаа үндсэн ажиллах хүчин бол малчин, тариаланч байгаа. Тиймээс энэ 2-ын ХАА-н үйлдвэрлэлд явуулахад ямар оролцоотой, эрх, үүрэгтэй байх, яаж дэмжих, ажлын байрыг яаж олшруулах талаар энэ хуульд тусгаж өгвөл яасан юм гэсэн саналтай байна.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	2. Хуулийн нэрийг өөрчилбөл яасан юм гэсэн санал байна. ХАА-н үйлдвэрлэлийн тухай ч юм уу эсвэл ХАА-н үйлдвэрлэлийн харилцааны тухай гэж нэрлэх ч юм уу.	Тусгасан
	3. Хууль өөрөө хэрэгжих ямар нэгэн механизмтай байх ёстой. Ялангуяа энэ ХАА-н тухай хуулийг хэрэгжүүлэх нэг механизмын бүрдэл хэсэг бол хөдөө суманд ажиллаж байгаа малын эмч, мал зүйч, агрономич, ХАА-н механикч инженер, эдийн засагч нар байгаа. Хөдөө орон нутагт яаж ажиллуулах, тэдний нийгмийн асуудлыг яаж шийдэх, хэрхэн дэмжих талаар энэ хуульд оруулж өгвөл сайн байна. Мал эмнэлгийн тухай хууль дээр нийгмийн асуудал гэж 36 сарын тэтгэмжээс өөр зүйл байхгүй.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан

ХААИС, Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн профессор П.Ариунсүрэн:	4. Хуулийн төслийн 6.2.4-т тахай, шувуу, загас, зөгийний аж ахуй гээд бүгдийг бичсэн байна. Эдгээр бол бие даасан ХАА-н төрөлжсөн аж ахуй, тиймээс үүнийг цааш нь аваад явах боломж байна уу.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	5. Хуулийн төслийн 16.1.2-т органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх гэж байна. Энэ чинь өөрөө хуультай. Заавал энд оруулж ирэх гээд байгаа юм уу эсвэл энэ хуулиар тэнд заагдаагүй асуудлыг зохицуулах гээд байна уу.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	6. Мал, амьтны тавлаг байдлын асуудал яригдана. Одоогоор стандарт хэрэгжиж байгаа. Тэр стандартад тусгагдаагүй, бодлогын хүрээний улсын хэмжээнд хамарсан, салбаруудыг хамарсан асуудлыг тусгасан гэж бодож байна. Явцын дунд цахимаар санал өгье.	Тусгасан
	1. Одоогоор бэлчээрийн тухай хууль гараагүй байгаа учир бэлчээрийн асуудлыг оруулж өгөх нь зүйтэй. Мал аж ахуйн үйл ажиллагаа явуулахад хамгийн гол хүчин зүйл бол уур амьсгалын хүчин зүйл байдаг. Уур амьсгалын хүчин зүйлтэй холбоотой заалт байна уу?, байхгүй бол Тусгасан өгөх хэрэгтэй. Бэлчээрийн даац багтаамжийг уур амьсгалаас хамааралтайгаар бэлчээрийн ургамлын нөөцөд тулгуурлаж тогтоогоод, ган, зудтай жил бол даац хэтрэх нь тодорхой, өнөтэй жил даац хэтрэх нь бага. Тиймээс уур амьсгалтайгаа холбоод илүү гарсан малын тоогоор нь эрх зүйн зохицуулалтаар ямар нэгэн арга хэмжээ авах зохицуулалт хийж өгөхгүй хэрэгтэй.	Тусгасан
	2. Газар зохион байгуулагч гэж орон нутагт ажиллаж боловч бэлчээрийн мэргэжлийн хүн ажилладаггүй учир бэлчээрийн ургамлаа таньж мэдэх гэх мэт бэлчээрийн судалгаагаа орхигдуулаад байна. Тиймээс сум орон нутаг бэлчээрийн мэргэжилтэнтэй байна гээд энэ хуульдаа зааж өгөх боломжтой юу.	Тусгасан
	3. Уул уурхайн газрууд бол бэлчээрийн газрыг уул уурхай болгоод буцааж нөхөн сэргээгээд бэлчээрийн газарт шилжүүлж байгаа. Нөхөн сэргээхдээ нутгийн ургамлаар ургамалжуулсан тохиолдолд бэлчээрийн газарт шилжүүлнэ гэж зааж өгөх хэрэгтэй. Тэгэхгүй бол байгалийн экосистем алдагдаж байна гэсэн судалгаа хийгдсэн байгаа. Нутгийн ургамлын үр үржүүлгийн асуудлыг ч гэсэн сайн тусгаж өгөх хэрэгтэй. Тэгэхгүй бол урдаас ирсэн ургамлын үрээр үр үржүүлэг хийгдэж экосистем алдагдаад байна.	Дагалдах хууль, байгаль орчны холбогдох хуульд Тусгасан, хэн хяналт тавихыг заах
	4. Эрчимжсэн МАА-д тэжээлийн нөөц байхгүй, тиймээс тэжээлийн нөөцийг бүрдүүлэхийн тулд фондтой байх ёстой. Тэнд нутгийн ургамлын үржүүлэгч хийж болно эсвэл нэг наст ургамлын үржүүлэг ч байж болно. Бэлчээр, тэжээлийн нөөцийг бий болгоогүй тохиолдолд менежмент хийж, үйлдвэрлэл явуулж чадахгүй. ХАА-н үйлдвэрлэлдээ ч, тэжээлдээ ч тэр ургамалжуулаач ээ гэдэг үгийг хэлэх гэсэн юм.	Эрсдэл, дэмжлэг зэрэг аль нэг хэсэгт Тусгасанаар Агуулгын саналыг хүлээн авсан
	5. Бид яагаад бэлчээр, тэжээлийн ургамлан нөмрөгийг бий болгох ажлыг хийхгүй байгаа юм бэ?. Толгой хууль учир энэ хуульдаа энэ ажлыг тусгаж өгөөч гэсэн хүсэлтэй байна.	Дагалдах хууль, байгаль орчны холбогдох хуульд Тусгасан, хэн хяналт тавихыг заах, хариуцлагажуулах

ХААИС, Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн Ахлах багш Б.Лхагвалдорж:	1. Бэлчээрийн МАА соёл буюу нүүдлийн мал аж ахуй соёл гэсэн агуулга. Тэгэхээр бэлчээрийн МАА-аас соёлыг нь салгах, нүүдлийн мал аж ахуйгаас нүүдлийн соёл гэдгийг салгах бол өрөөсгөл асуудал гэж бодож байна. Хуулийн төслийн 6.2.6-д “хөдөө аж ахуйн аялал жуулчлал” гэж оруулсан байна. Энэ бол ХАА-н соёлыг харах гэж жуулчид ирж байна. Гаднаас ирж байгаа жуулчид мал аж ахуйн соёл, нүүдлийн мал аж ахуйн онцлог энэ байдлыг харах, биеэрээ мэдэрч гэр мэдрэмжийг авах зорилготой. Үүнийг соёлынхоо агуулгаар тусгаж оруулбал зүгээр гэсэн саналтай байна.	Нэр томьёонд нүүдлийн соёл иргэншлийг хадгаласан гэдэг агуулгаар баяжуулсан.
	2. Залуу халаа үеийг бэлтгэхэд жендерийн асуудал хамгийн чухал. Охидуудаа хот суурин газарт сургууль, соёлд явуулчихдаг. Охидууд нь хот, суурин газарт ирээд буцаж очих сонирхолгүй байдаг. Би асуулт асуухдаа Хотын бүсгүй хөдөө нутагт гэдэг нэвтрүүлгээр жишээ аваад хэлсэн. Тэнд нийгмийн том асуудал бодитоор харагдаж байгаа. Нүүдлийн мал аж ахуйн соёл маань цаашаа үргэлжлээд явна гэвэл залуу халаа байх хэрэгтэй. Гэтэл тэнд залуучууд байна, охидууд нь байхгүй. Энэ асуудлын зохицуулах гаргалгааг бодож үзэх хэрэгтэй. Социализмын үед ХАА-н дээд сургууль дээр залуу малчны сургууль гэж хийж байсан юм байна лээ, архивд материал нь байдаг юм байна. Эндээс хоорондоо танилцаж, гэр бүл болдог байсан юм байна.	Тусгасан
	3. Хуулийн төслийн 7.2.2-7.2.4-т орон нутгийн эрх баригч нарт эрхийг нь өгөх заалт байна гэж харж байна. ХАА-н бүс тогтоох болбол өөрөө жаахан эрлэлтэй байх болов уу гэж бодож байна. Яагаад гэвэл 1979 онд Өвөрмонголд энэ асуудал үүсэж, бүс тогтоо гэснээс торло гэж хэлээгүй. Тэгвэл торлож урт хөлийн мал байхгүй болох асуудал үүссэн. Гэтэл нүүдлийн МАА-н соёлын гол бэлгэ тэмдэг бол адуу. Тиймээс үүнийг сайн бодох хэрэгтэй.	Тусгасан
	4. Хуулийн төслийн 10.3-т ХАА-н салбарын мэргэжилтэн бэлтгэлдэг танц сургууль бол ХААИС. Тиймээс энд шууд ХААИС гээд заагаад өгчихвөл яасан юм.	Агуулгын хүрээнд саналыг хүлээн авсан
	5. Хуулийн төслийн 8.4-т “нэг алхам урагш, нэг алхам хойш” зарчим байна. Энэ ямар зарчмыг хэлж байгаа юм бол, үүнийг Агуулгын саналыг хүлээн авсан хэрэгтэй.	Энэ зарчимд сайжруулалт хийж, тайлбар гаргасан.
	6. Бүтээгдэхүүний ялгарал гэж байна. Бүс нутгийг хөгжлийн ялгарлыг бий болгоно гэж үзэж байгаа бол өмнөд хөршийн ялангуяа Өвөрмонголын загвараас суралцвал гэсэн саналтай байна.	Газарзүйн заалттай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, урамшуулалтай уялдуулан хийх
Метагро ХХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирал Б.Оргил:	Метагро компани ХАА-н салбарт өөрийн хөрөнгөөр 60 сая доллар, Дэлхийн банкаас 30 доллар зээл аваад, нийт 100-аад сая долларын хөрөнгө оруулалт хийгээд, энэ хууль дээр хийгдэж байгаа бүх үйл явцыг эрсдэлээ үүрээд, өөрөө бүгдийг нь туулаад хийж байгаа компани юм. Миний анзаарсан нэг зүйл бол хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт	саналгүй

	хувийн хэвшлийн төлөөлөл дутмаг байна гэж харж байна. Өөрийн зүгээс бичгээр саналаа цаасаар өгнө. Миний нэг санал бол хуулийн төслийн хэлэлцүүлгээ хувийн хэвшлээ оролцуулсан хэлэлцүүлгийг заавал хийгээрэй гэсэн санал байна. Эндээс маш тодорхой санал гарч ирэхээр байна.	
Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн	ХӨДӨӨ АЖ АХУЙН ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСӨЛ Нэмэх санал: НЭГ: ҮНДЭСЛЭЛ: 1. Хүн бүрийн хийж чадах аж ахуй 2. Өргөн уудам нутагтай 3. Нөхөн сэргээгдэггүй салбарын орлогоос Нөхөн сэргээгддэг салбар руу дэмжлэг 4. Аливаа хүнс шинэ байх ХОЁР: ДЭМЖЛЭГИЙН ТАЛААР: ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ Нэг улаа үнэ төлбөргүйгээр, бусад шилжүүлэх эрхгүйгээр эзэмшүүлэх 1. МАЛЧДАД ӨВӨЛЖӨӨ, ХАВАРЖААНЫ ДООРХ ГАЗАР 1 га хүртэл 2. НОГООЧДОД НОГОО ТАРИХ зориулалтаар 10 га хүртэл 3. ТАРИАЛАНЧДАД тосны ургамлаас бусад таримал тариалах зориулалтаар 50 га хүртэл ДЭД БҮТЦИЙН ДЭМЖЛЭГ Хамгаалагдсан аж ахуй, Хүнс, тэжээлийн үйлдвэрүүдэд дараахь дэмжлэг • Цахилгаан эрчим хүчний шугам сүлжээ, дэд станц • Автозам • Интернэт сүлжээ • Гүний худгийн цооног ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН ДЭМЖЛЭГ • Хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийн тогтвортой байдлыг бүрдүүлэх	Хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийн тогтвортой байдлыг бүрдүүлэх хүрээнд Үндэсний баялийн сангийн Хөгжлийн сангийн төсөвт жил бүр зээлийн хүүгийн татаас эсхүл эх үүсвэр тусган батлуулж, Хөдөөгийн хөгжлийг дэмжих банк руу хуваарилж байх, Тусгай зориулалтын банк байгуулах, Төрийн банкныг Хөдөөгийн хөгжлийг дэмжих банк болгон өөрчлөн байгуулах асуудлаас бусад асуудлыг хуулийн төсөлд тусгасан.

	• Үндэсний баялгийн сангийн Хөгжлийн сангийн төсөвт жил бүр зээлийн хүүгийн татаас эсхүл эх үүсвэр тусган батлуулж Хөдөөгийн хөгжлийг дэмжих банк руу хуваарилж байх • Тусгай зориулалтын банк байгуулах • Төрийн банкийг Хөдөөгийн хөгжлийг дэмжих банк болгон өөрчлөн байгуулах ГУРАВ: ХЯЗГААРЛАЛТЫН ТАЛААР • Бэлчээр хамгаалах зорилгоор ӨВӨЛЖӨӨ, ХАВАРЖААНЫ ДООРХ ГАЗАР, ГҮНИЙ ХУДГИЙН ЦООНОГ хоорондын доод зайг тогтоох ДӨРӨВ: ДАГАЛДУУЛАН ӨРГӨН МЭДҮҮЛЭХ ХУУЛИЙН ТӨСӨЛ • Газрын тухай хууль • Тариалангийн тухай хууль ТАВ:ХАСАХ САНАЛ • Хүнс, ХАА-н асуудал хариуцсан орон нутгийн захиргааны байгууллагын удирдлагыг босоо томилохтой санал нийлэхгүй	
--	--	--

-oOo-